



ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ  
2015-2023



ГОВИЙН ОЮУ  
ХӨГЖЛИЙГ  
ДЭМЖИХ САН

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ  
ДЭМЖИХ САН”

# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



2023



ГОВИЙН ОЮУ  
ХӨГЖЛИЙГ  
ДЭМЖИХ САН

*Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

Удирдах зөвлөлийн даргын мэндчилгээ .....	2
“Говийн оюу хөгжлийг дэмжих сан” .....	3
“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн хөрөнгө оруулагч “Оюу толгой” компани .....	4-5
“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн бүтэц, зохион байгуулалт .....	6-8
“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөл .....	6
Харилцааны хороо .....	7-8
“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-д хүлээн авах төслийн саналын чиглэл .....	9-10
Санхүүжилт олгох үндсэн чиглэл .....	9
Санхүүжилт олгох үйл явц .....	10
“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн зорилтот хамрах нутаг дэвсгэр .....	11
Сангийн 2023 онд Өмнөговь аймагт оруулсан хөрөнгө оруулалт, үр шим .....	12-17
“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн үйл ажиллагааны он дараалал .....	18
Ирээдүй хойч үеийн төлөө сан .....	19
“Говийн оюу-Бизнес боломж” бизнесийн бичил зээл .....	19-24
Ирээдүй хойч үеийнхэнд зориулсан хадгаламж .....	25
“Говийн оюу-Оюутны тэтгэлэг” хөтөлбөр .....	26-34
Хандив тусламж .....	35-36
“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн 2023 оны онцлох үйл явдал .....	37-40
Батлагдсан төсөл хөтөлбөрийн хэрэгжилт .....	41
Сангийн 2015-2023 оны гүйцэтгэл .....	41
Сангийн 2023 оны гүйцэтгэл, санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрүүд .....	42-44
Сангийн Удирдах зөвлөлийн баталсан 2023 оны санхүүжилтийн эх үүсвэрийн хуваарилалт .....	45-50
Сангаас Удирдах зөвлөлийн баталсан идэвхтэй хэрэгжиж буй төсөл хөтөлбөр .....	51
2023 онд батлагдсан төсөл хөтөлбөрийн хэрэгжилт .....	51-59
Он дамжин хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүд .....	60-78
Санхүүжилтийн квот, 2023 оны санхүүжилтийн квотын хүрээнд хэрэгжсэн төсөл .....	79-185
Санхүүжилтийн квот, зорилго .....	79
Ханбогд суманд хуваарилагдсан санхүүжилтийн квот, хэрэгжсэн төсөл, хөтөлбөр .....	80-101
Манлай суманд хуваарилагдсан санхүүжилтийн квот, хэрэгжсэн төсөл, хөтөлбөр .....	102-114
Баян-Овоо суманд хуваарилагдсан санхүүжилтийн квот, хэрэгжсэн төсөл, хөтөлбөр .....	115-127
Баяндалай суманд хуваарилагдсан санхүүжилтийн квот, хэрэгжсэн төсөл, хөтөлбөр .....	128-135
Мандал-Овоо суманд хуваарилагдсан санхүүжилтийн квот, хэрэгжсэн төсөл, хөтөлбөр .....	136-143
Сэврэй суманд хуваарилагдсан санхүүжилтийн квот, хэрэгжсэн төсөл, хөтөлбөр .....	144-154
Булган суманд хуваарилагдсан санхүүжилтийн квот, хэрэгжсэн төсөл, хөтөлбөр .....	155-160
Номгон суманд хуваарилагдсан санхүүжилтийн квот, хэрэгжсэн төсөл, хөтөлбөр .....	161-165
Хүрмэн суманд хуваарилагдсан санхүүжилтийн квот, хэрэгжсэн төсөл, хөтөлбөр .....	166-171
Цогтцэций суманд хуваарилагдсан санхүүжилтийн квот, хэрэгжсэн төсөл, хөтөлбөр .....	172-175
Ханхонгор суманд хуваарилагдсан санхүүжилтийн квот, хэрэгжсэн төсөл, хөтөлбөр .....	176-177
Ноён суманд хуваарилагдсан санхүүжилтийн квот, хэрэгжсэн төсөл, хөтөлбөр .....	178-182
Гурвантэс суманд хуваарилагдсан санхүүжилтийн квот, хэрэгжсэн төсөл, хөтөлбөр .....	183-185
Сангийн ил тод байдал .....	186
Сангийн хяналт, шинжилгээ-үнэлгээ .....	187-196
Харилцагч байгууллагууд .....	197-200
Санхүүгийн тайлан .....	201-204



## “ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-ИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ

“Оюу толгой” компанийн Үйл ажиллагаа эрхэлсэн захирал,  
“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн дарга  
**ЭНДРЬЮ Уилсон**

Та бүхэндээ “Оюу толгой” ХХК-ийн хөрөнгө оруулалттай “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн 2023 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг хүргэж байгаадаа таатай байна. “Оюу толгой” ХХК нь Өмнөговь аймаг, тус аймгийн Ханбогд сумтай байгуулсан “Хамтын ажиллагааны гэрээ”-г хэрэгжүүлэх үүднээс “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” төрийн бус байгууллагыг үүсгэн байгуулсан.

“Оюу толгой” ХХК нь Өмнөговь аймгийн тогтвортой хөгжилд чиглэсэн төсөл, санал санаачилгуудыг дэмжин ажиллаж байна. “Оюу толгой” компани “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-д жил бүр таван сая ам.доллартой тэнцэх төгрөгийг олгодог. Тус сан нь үүсгэн байгуулснаас өнөөг хүртэл нийт 122.5 тэрбум төгрөгөөр 425 төсөл хөтөлбөр санхүүжүүлэн, амжилттай хэрэгжүүлээд байна.

2023 онд сангаас санхүүжүүлсэн “Даланзадгад сумын Дулааны цахилгаан станцад усаар үнс зайлуулах систем, үнсэн сан байгуулах” төсөл, “Цогт-Овоо сумын 15 ортой эмнэлгийн барилга” гэх мэт төслүүд бүрэн дуусаж, Даланзадгадын “1200 хүүхдийн сургууль”, “200 хүүхдийн цэцэрлэгийн барилга” барих төслүүдийн гүйцэтгэл 90-ээс дээш хувьд хүрлээ.

Түүнчлэн “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөл Өмнөговь аймгийн бүх сумдыг санхүүжилтийн квотод хамруулахаар ишийдвэрлэж 2023 онд нийт 2.7 тэрбум төгрөгийг сумдад хуваарилж, орон нутгийн иргэд, байгууллага тухайн сумандаа иргэдийн ахуй амьдралд нэн хэрэгцээтэй төслүүдийг өөрсдөө санаачлан хэрэгжүүлэх боломж олгосон юм.

“Говийн оюу-Оюутны тэтгэлэг” хөтөлбөрийн хүрээнд энэ жил 112 оюутан сургалтын бүрэн тэтгэлэгт хамрагдаж, “ХААН” банкттай хамтран хэрэгжүүлдэг “Говийн оюу-Бизнес боломж” бичил зээлийн хөтөлбөрийн хүрээнд 34 бизнес эрхлэгчдэд 1.9 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй бичил зээл олгосон ба Өмнөговь аймаг болон сумдад 79 сая төгрөгийн хандив олгосон.

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан” 2024-2028 он буюу дараагийн 5 жилийн ажлын хүрээг тодорхойлох зорилгоор стратеги төлөвлөгөөг боловсруулах ажил зохион байгуулж Хамтын ажиллагааны гэрээний сэдэвчилсэн 7 хавсралт тус бүрээр орон нутгийн иргэд, тухайн чиглэлийн байгууллагуудын төлөөлөл оролцуулсан цуврал хэлэлцүүлгийг амжилттай зохион байгууллаа.

“Оюу толгой” ХХК болон “Говийн оюу хөгжлийн дэмжих сан”-ийн хичээл зүтгэл нь орон нутгийн иргэдийн сайн сайхан амьдрал, орон нутгийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулахад хөшүүрэг болж байгаа бөгөөд орон нутгийн иргэдийн санаачилгад тулгуурласан стратеги төлөвлөгөө хэрэгжүүлэх нь сангийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх юм.



## ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН

2015 оны 04 сарын 22-ны өдөр Өмнөговь аймаг, тус аймгийн Ханбогд сум болон “Оюу толгой” компанийн хооронд байгуулсан Хамтын ажиллагааны гэрээний хэрэгжилтийг хангах үүднээс “Оюу толгой” компани нь “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” Төрийн бус байгууллагыг 2015 оны 09 сарын 25-ны өдөр үүсгэн байгуулсан.

Уг гэрээний 8.3-т заасны дагуу “Оюу Толгой” компани нь жил бүр 5 сая ам.доллар түүнтэй тэнцэх төгрөгийн санхүүжилтийг “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-аар дамжуулан Хамтын ажиллагааны гэрээний дагуу орон нутгийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулахад чиглэгдсэн төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэн ажиллаж байна.

## “ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

### АЛСЫН ХАРАА

Итгэлцэлд суурилсан  
сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид  
хамтдаа бүтээнэ

### ЭРХЭМ ЗОРИЛГО

Өмнөговьчуудын сайн  
сайхан амьдралыг  
дэмжсэн хамтын  
хөгжлийн санаачилгыг  
санхүүжүүлэгч сан байна

### ЭРХЭМЛЭХ ЗАРЧИМ

- Авилгаас ангид байх
- Хувийн ашиг сонирхлоос ангид байх
- Үндэслэл, тооцоо баримт нотолгоонд суурилсан шийдвэр гаргах
- Аливаа ялгаварлалгүйгээр нутгийн иргэдийн шударга оролцоог дэмжих, тэгш боломжоор хангах
- Бүх төслүүд Сангийн эрхэм зорилготой уялдсан байх
- Батлагдсан төслүүд тохиролцсон үр дүндээ хүрдэг байх



*Итгэцлэлд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

## “ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-ИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ “ОЮУ ТОЛГОЙ” КОМПАНИЙН ТАЛААР

“Оюу толгой” компани бол “Рио Тинто” компани (66 хувь) болон “Эрдэнэс Оюу толгой” ХХК (34 хувь)-ийн хувь нийлүүлсэн Монгол Улсын хамгийн том зэс, алтны компани юм. Уурхайн цогцолбор Улаанбаатар хотоос өмнө зүгт 550 километр, Монгол-Хятадын хилээс хойш 80 орчим километрт оршдог.

Олон арван жилийн хайгуулын үр дүнд Оюу толгойн ордыг 2001 онд нээн илрүүлж, улмаар 2013 онд анхны зэсийн баяжмалаа экспортод гаргасан билээ. Ил болон гүний уурхайгаас хүдэр олборлож, хоногт 100,000 тонн хүдэр баяжуулах хүчин чадал бүхий баяжуулах үйлдвэр, дагалдах байгууламж, дэд бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Оюу толгойг дэлхийн хамгийн том зэсийн уурхайн нэг болгох гүний уурхайн олборлолтоо 2023 оны 3 сард амжилттай эхлүүлсэн юм. Тус компани үйлдвэрлэсэн зэс, алтны агуулгатай баяжмалаа олон улсын зах зээлд борлуулдаг.

2023 оны эцсийн байдлаар Оюу толгойн нийт ажиллах хүчний 97.2 хувь нь монголчууд бөгөөд тэдний 23 орчим хувийг Өмнөговь аймгийн иргэд бүрдүүлжээ. “Оюу толгой” компани ажиллах хүчнийхээ эрүүл мэнд хийгээд хөдөлмөрийн аюулгүй байдалд эн тэргүүний ач холбогдол өгдөг бөгөөд Рио Тинто группийн хэмжээнд хамгийн аюулгүй уурхайн нэгд тооцогддог.

“Оюу толгой” компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигч талуудын төлөөллөөс бүрдэх бөгөөд стратегийн чиглэлийн дагуу шийдвэр гаргах, хяналт тавих үүрэг гүйцэтгэнэ. Харин уул уурхайн бизнесийн бүхий л чиглэлээр мэргэшсэн Гүйцэтгэх удирдлагын баг компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан, стратегийн бодлогыг хэрэгжүүлдэг. 2023 онд бид ирэх 10 жилийн тэмүүллийг маань бүрэн дүүрэн шингээсэн шинэчилсэн стратегиа баталж, Хамт олон, Хамтын ажиллагаа, Хөрст дэлхий, Хүртэх өгөөж гэсэн тэргүүлэх дөрвөн чиглэлийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

“Оюу толгой” компани нь 2015 оны 4 дүгээр сарын 22-нд Монгол Улсын Ашигт малтмалын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, хөрөнгө оруулагч “Рио Тинто” компанийн олон улсад мөрддөг стандарт журмын дагуу уурхайн үйл ажиллагаа явуулж буй Өмнөговь аймаг болон Ханбогд сумтай “Хамтын ажиллагааны гэрээ” байгуулсан. Энэ нь аймаг төдийгүй Монгол Улсын хэмжээнд уул уурхайн компани нутгийн захиргааны байгууллагатай иж бүрэн хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж буй анхны жишээ юм.

### АЛСЫН ХАРАА

Эрдэс баялгаас эрдэм мэдлэг, ур чадвар, үнэт зүйлс бүтээлцэнэ.




### ҮНЭТ ЗҮЙЛС


- Анхаарал халамжтай
- Зоримог шийдэмгий
- Сониуч соргог



### ҮНДСЭН ЗОРИЛГО

Дэлхийд тэргүүлэх, аюулгүй, тогтвортой зэсийн бизнесийг хамтдаа цогцлоож, эх орныхоо хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулна.







## “ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

### “ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-ИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн дүрмийн 8-д зааснаар сангийн эрх барих дээд байгууллага нь Удирдах зөвлөл байна.

#### Удирдах зөвлөлийн гишүүнчлэл

8.2 “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөл нь дараах 7 гишүүнээс бүрдэнэ:

- Өмнөговь аймаг болон Ханбогд сум хамтран нэр дэвшүүлж “Оюу толгой” ХХК-д бичгээр мэдэгдэн томилсон Удирдах зөвлөлийн гурван гишүүн (тус бүрийг нь Удирдах зөвлөлийн орон нутгийн гишүүн гэх)
- “Оюу толгой” ХХК-аас нэр дэвшүүлж Өмнөговь аймаг болон Ханбогд суманд бичгээр мэдэгдэн томилсон Удирдах зөвлөлийн дөрвөн гишүүн (тус бүрийг нь Удирдах зөвлөлийн “Оюу толгой”-ийн гишүүн гэх)

#### “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн дүрмээс

Гэрээний талууд Хамтын ажиллагааны гэрээнд нийцэж ажиллахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Сангийн Дүрмийн дагуу удирдах зөвлөлд зөвлөгөө өгөх, сангийн дүрмийн хэрэгжилтийг сахиулах, хөндлөнгийн хяналт тавих эрх бүхий хараат бус Итгэмжлэгдсэн зөвлөх сонгогдон ажиллаж байгаа.

## САНГИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД-2023 ОН



Удирдах зөвлөлийн дарга,  
“Оюу толгой” ХХК-ийн  
Үйл ажиллагаа эрхэлсэн  
захирал

**Зндрю Уулсон**



Удирдах зөвлөлийн  
гишүүн, Өмнөговь  
аймгийн ИТХ-ын дарга

**Н.Энхбат**



Удирдах зөвлөлийн  
гишүүн, Өмнөговь  
аймгийн Засаг дарга

**Р.Сэддорж**



Удирдах зөвлөлийн  
гишүүн, Өмнөговь  
аймгийн ИТХ-д Ханбогд  
сумаас сонгогдсон  
төлөөлөгч

**Ж.Занабазар**



Удирдах зөвлөлийн  
гишүүн, “Оюу толгой”  
ХХК-ийн Хууль,  
эрх зүйн асуудал  
хариуцсан захирал

**Д.Амарбаясгалан**



Удирдах зөвлөлийн  
гишүүн, “Оюу толгой”  
ХХК-ийн Боловсон  
хүчин, бүтэц зохион  
байгуулалт хариуцсан  
Ерөнхий менежер

**Мелисса Шаненганге**



Удирдах зөвлөлийн  
гишүүн “Оюу толгой”  
ХХК-ийн Орон нутгийн  
харилцааны Ерөнхий  
менежер

**Г.Сугар**





## ХАРИЛЦААНЫ ХОРОО

Харилцааны хороо нь Өмнөговь аймаг, “Оюу толгой” ХХК болон хамтран ажиллах орон нутаг дахь түншлэгч сумдын хоорондын аливаа хамтын ажиллагаанд хяналт тавьж ажиллана. Орон нутгийн засаг захиргаа, орон нутгийн төлөөлөгчид болон “Оюу толгой” ХХК-ийн үйл ажиллагаа хариуцсан менежерүүдийн бүрэлдэхүүнтэй байна. Харилцааны хорооны уулзалт нь дараах үндсэн хоёр зорилготой байна.

- a) Орон нутгийн оролцоо шаардсан аливаа үүрэг, амлалтын талаар олон талыг хамарсан, ил тод хэлэлцүүлэг өрнүүлэх
- b) Хөгжлийг дэмжих санд ирүүлсэн саналын талаарх баримтуудыг хянан хэлэлцэж, түүний хэрэгжих боломж, дарааллын талаар Хөгжлийг дэмжих сангийн санхүүжилтийн шалгуур, ялангуяа засаг захиргааны бодлого, төлөвлөлт, “Оюу толгой” төслийн урт хугацааны хөгжлийн чиглэл болон талуудын урт хугацааны тогтвортой хөгжлийн талаарх нэгдсэн алсын төсөөллийг харгалзан үзэж, Хөгжлийг дэмжих сангийн Удирдах зөвлөлд зөвлөмж өгөх.

**(Хамтын ажиллагааны гэрээний Хавсралт 2-оос)**



Итгэцээг суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ

## ХАРИЛЦААНЫ ХОРООНЫ ГИШҮҮД-2023 ОН

### ХАРИЛЦААНЫ ХОРООНЫ ДАРГА НАР



**Ц.Дэнээдорж**

Өмнөговь аймгийн  
Засаг даргын орлогч



**О.Цэрэннадмид**

“Оюу толгой”  
компанийн Бүсийн  
хөгжил хариуцсан  
Ахлах менежер

### ХАРИЛЦААНЫ ХОРООНЫ ГИШҮҮД



**Ц.Амартөгс**

Өмнөговь аймгийн  
Засаг даргын  
тамгын газрын  
дарга



**О.Эрдэнэ-Өрнөх**

Хөрөнгө оруулалт  
хөгжлийн бодлого  
төлөвлөлтийн  
хэлтсийн дарга



**Ц.Бадамцэрэн**

Нийгмийн бодлогын  
хэлтсийн дарга



**О.Мандахбаяр**

Баян-Овоо сумын  
Засаг дарга



**П.Баасанцогт**

Манлай сумын  
Засаг дарга



**Х.Нэхийт**

Ханбогд сумын  
Засаг дарга



**В.Мөнхбат**

Өмнөговь аймгийн  
ИТХ-ын төлөөлөгч,  
тэргүүлэгч



**Б.Энхмөнх**

Даланзадгад сумын  
иргэний төлөөлөл



**Д.Амартүвшин**

“Оюу толгой”  
компанийн Хангамж,  
худалдан авалтын  
газрын менежер



**Т.Самданжигмэд**

“Оюу толгой”  
компанийн Байгаль  
орчны менежер



**Э.Болд-Эрдэнэ**

“Оюу толгой”  
компанийн  
Сургалтын хэлтсийн  
менежер



## “ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-ИЙН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-ИЙН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ОРОЛЦОГЧ ТАЛУУД: ТӨСӨЛ САНААЧЛАГЧ, “ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”, ХАРИЛЦААНЫ ХОРОО, САНГИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭНИЙ 7 СЭДЭВЧИЛСЭН ЧИГЛЭЛЭЭР ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР САНХҮҮЖҮҮЛЖ ӨМНӨГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛД ХУВЬ НЭМЭР ОРУУЛНА.

### АШГИЙН БУС НИЙГЭМД ЧИГЛЭСЭН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН САНАЛ АВАХ ЧИГЛЭЛҮҮД



### ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЖИЖИГ ДУНД БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ- БИЗНЕСИЙН БИЧИЛ-ЗЭЭЛ

(Хаан банкаар дамжуулан жилийн 7,2% буюу сарын 0,6%-ийн хүүтэй 80-100 сая төгрөгийн бизнесийн хөнгөлөлттэй, бичил зээл олгож байна)

ОРОН НУТГИЙН БИЗНЕС ХӨГЖИЛ & БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ

САНХҮҮЖИЛТИЙН ЧИГЛЭЛҮҮД



Итгэцлэлд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ

## “ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-ИЙН САНХҮҮЖИЛТ ОЛГОХ ҮЙЛ ЯВЦ

### “ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-ИЙН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН ЧИГЛЭЛ, ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

НИЙГМИЙН ДЭД БҮТЦИЙН  
ТӨСӨЛ

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

НИЙГМИЙН ДЭД БҮТЭЦ,  
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
ТӨСӨЛ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ  
ДЭМЖИХ САН”-ИЙН ҮНДСЭН  
ЧИГЛЭЛТЭЙ УЯЛДСАН ХӨТӨЛБӨР

САНХҮҮЖИЛТИЙН  
КВОТ

#### Төслийн санал хүлээн авах

- Өмнөговь аймгийн үндсэн чиглэлтэй уялдсан байна

#### Нөхцөл байдлын шинжилгээ хийх

- Санал ХДС-ийн бичиг баримтуудад нийцсэн байна

#### Санхүүжилтийн шийдвэр гаргах

- Харилцааны хороо, Удирдах зөвлөлөөр батлуулна

#### Төслийн хэрэгжилт, хяналт, хаалт

- Төслийн хэрэгжилт, хяналт, төслийн хаалт, Захиалагч тогтвортой байдлыг хангана

- Сангийн үндсэн чиглэлээ боловсруулж батлуулна
- Жил бүр үндсэн чиглэлийн дагуу төсөл зарлаж санал хүлээн авна

#### Санхүүжилтийн шийдвэр гаргах

- Харилцааны хороо, Удирдах зөвлөлөөр батлуулна

#### Төслийн хэрэгжилт, хяналт, хаалт

- Төслийн хэрэгжилт, хяналт, төслийн хаалт, Захиалагч тогтвортой байдлыг хангана

- Санхүүжилтийн квотоор хийсэн ажлыг жил бүр дүгнэнэ
- Өмнөговь аймгийн сумдын Засаг дарга нартай санхүүжилтийн квот олгох гэрээ байгуулна
- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлөөс хуваарилсан санхүүжилтийн квотын хүрээнд сангийн удирдамжийн дагуу тухайн орон нутгийн ард иргэдэд хэрэгцээ шаардлагатай ашгийн бус төслүүдийг хэрэгжүүлнэ

#### Төслийн хэрэгжилт, хяналт, хаалт

- Төслийн хэрэгжилт, хяналт, төслийн хаалт, Захиалагч тогтвортой байдлыг хангана



## “ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-ИЙН ЗОРИЛТОТ ХАМРАХ НУТАГ ДЭВСГЭР

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан” Өмнөговь аймгийн бүх суманд хүрч ажиллаж, орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулж байна.



### Зорилтот газар


1


Журмаар зохицуулсны дагуу санхүүжилтийн квотод хамрагдсан сумд



Итгэцлэг суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ

## “ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-ААС 2015-2023 ОНД ӨМНӨГОВЬ АЙМГИЙН СУМДАД ОРУУЛСАН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ







“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-ИЙН САНХҮҮЖИЛТЭЭР ХЭРЭГЖСЭН  
ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТОТ БҮЛГИЙН ҮР ШИМ ХҮРТЭГЧ

**САНГААС САНХҮҮЖҮҮЛСЭН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН ҮР ӨГӨӨЖ  
ДАВХАРДСАН ТООГООР 840 МЯНГА ГАРУЙ ХҮНД ХҮРСНЭЭС ЗОРИЛТОД  
БҮЛГИЙН ИРГЭД ДАРААХ БАЙДЛААР ХАМРАГДСАН БАЙНА.**



Өмнөговь аймгийн 0-18 настай хүүхдэд тусгайлан чиглэсэн сургууль  
цэцэрлэгийн барилга, тохижилт, сургалт гэх мэт төсөл хөтөлбөрийн  
хүрээнд давхардсан тоогоор **54,0 МЯНГАН ХҮҮХЭД** үр шим хүртсэн.



Өмнөговь аймгийн эмэгтэйчүүдэд тусгайлан чиглэсэн эрүүл мэнд,  
хөдөлмөр эрхлэлт, ажлын байрны тохижилт, сургалт гэх мэт төсөл  
хөтөлбөрийн хүрээнд давхардсан тоогоор **27,0 МЯНГАН ЭМЭГТЭЙ**  
үр шим хүртсэн.



Өмнөговь аймгийн ахмад настнуудад тусгайлан чиглэсэн эрүүл мэнд,  
хөдөлмөр эрхлэлт гэх мэт төсөл хөтөлбөрийн хүрээнд давхардсан  
тоогоор **16,0 МЯНГАН АХМАД** үр шим хүртсэн.



Өмнөговь аймгийн залуучуудад тусгайлан чиглэсэн сургалт, хөдөлмөр  
эрхлэлт, сурах орчин нөхцөл сайжруулах тоног төхөөрөмжөөр  
хангах гэх мэт төсөл хөтөлбөрийн хүрээнд давхардсан тоогоор **42,0  
МЯНГАН ЗАЛУУЧУУД** үр шим хүртсэн.



Өмнөговь аймгийн малчдад тусгайлан чиглэсэн мал ариутгал,  
халдваргүйжүүлэлт, бэлчээр усжуулалт гэх мэт төсөл хөтөлбөрийн  
хүрээнд давхардсан тоогоор **29,0 МЯНГАН МАЛЧИН** үр шим  
хүртсэн.



Өмнөговь аймгийн хөгжлийн бэрхшээлтэй болон эмзэг бүлгийн  
иргэдэд тусгайлан чиглэсэн эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, орчин  
нөхцөл сайжруулах гэх мэт төсөл хөтөлбөрийн хүрээнд давхардсан  
тоогоор **2,0 МЯНГАН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭД** үр  
шим хүртсэн.





## “ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-ААС 2023 ОНД ӨМНӨГОВЬ АЙМГИЙН СУМДАД ОРУУЛСАН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

№	Сумын нэр	“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлөөс 2023 онд баталсан томоохон төслийн санхүүжилт /төгрөгөөр/	2023 Санхүүжилтийн квот /төгрөгөөр/	2023 оны “Говийн оюу-оюутны тэтгэлэг”-ийн санхүүжилт /төгрөгөөр/	2023 оны “Говийн оюу-бизнес боломж” бичил зээлийн хөтөлбөрийн санхүүжилт /төгрөгөөр/	Хандив /төгрөгөөр/	2023 онд сумдад оруулсан нийт хөрөнгө оруулалт /төгрөгөөр/
1	Ханбогд	4,360,442,356	294,222,400	4,073,000		10,500,000	4,669,237,756
2	Манлай		224,993,600	5,292,900	70,000,000	8,000,000	308,286,500
3	Баян-Овоо		224,993,600	1,800,000		9,500,000	236,293,600
4	Даланзадгад	10,004,916,618	224,993,600	113,633,856	1,711,060,000	11,229,000	12,065,833,074
5	Баяндалай		224,993,600	9,010,075		5,000,000	239,003,675
6	Булган		224,993,600	7,274,000			232,267,600
7	Номгон		224,993,600	4,788,500			229,782,100
8	Сэврэй		155,764,800	11,193,735	86,000,000	5,000,000	257,958,535
9	Цогт-Овоо	911,650,355	155,764,800	5,900,000			1,073,315,155
10	Мандал-Овоо		155,764,800		9,500,000	5,000,000	170,264,800
11	Хүрмэн		155,764,800	7,200,200		5,000,000	167,965,000
12	Цогтцэций		155,764,800	18,174,420			173,939,220
13	Ханхонгор		155,764,800	4,058,175			159,822,975
14	Ноён		155,764,800	1,735,000		5,000,000	162,499,800
15	Гурвантэс		155,764,800	22,650,955			178,415,755
16	Бүх сумыг хамарсан	1,000,000,000				15,000,000	1,015,000,000
	<b>Нийт</b>	<b>16,277,009,329</b>	<b>2,890,302,400</b>	<b>216,784,816</b>	<b>1,876,560,000</b>	<b>79,229,000</b>	<b>21,339,885,545</b>



Итгэцээг суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ

## “ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-ИЙН 2015-2023 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ҮР ШИМ

# 122.88 ТЭРБУМ ₮ 45.17 САЯ \$

Харилцагч,  
хамтрагч

827



Шинэ ажлын  
байр

719



Хандив,  
тусламж

3.1 тэрбум ₮



Үр шим  
хүртэгч

+840,000



Тэтгэлэгт  
оюутан

517



Бизнесийн  
хөнгөлөлттэй  
зээл

93



Санхүүжилтийн  
квот

8.5 тэрбум ₮



Төсөл  
хөтөлбөр

425





“ОЮУ ТОЛГОЙ” КОМПАНИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТАЙ  
“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-ААС 2015-2023 ОНД

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛД ХУВЬ  
НЭМРЭЭ ОРУУЛАХ НИЙГМИЙН ШИНЖ ЧАНАРТАЙ 425 ТӨСӨЛ  
ХӨТӨЛБӨР САНХҮҮЖҮҮЛЭН ХЭРЭГЖҮҮЛЖ **122 ГАРУЙ ТЭРБУМ**  
**ТӨГРӨГИЙН** ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ОРУУЛЛАА



6 цэцэрлэгийн барилга - нийт 1000 хүүхдийн багтаамжтай



2 сургуулийн барилга - нийт 1840 хүүхдийн багтаамжтай



3 сумын эрүүл мэндийн төвийн барилга - 10 ортой 2 ЭМТ, 15 ортой 1 ЭМТ, малын эрүүл мэндийн төвийн барилга



103 шинэ худаг, 52 худаг засвар



3 сумын уурын зуухны барилга, 2 сумын уурын зуухны тогоо шинэчлэл, Даланзадгад сумын ДЦС-д усаар үнс зайлуулах систем суурилуулалт



Сургалт-39 төслийн хүрээнд 358 сургалтаар 38850 хүнд хүрсэн



Мод үржүүлэг, усалгааны систем- усалгааны систем сумдад суурилуулж, 15350 мод



Тохижилт, үйлчилгээ - 99 төслийн хүрээнд амьдрах орчин сайжруулсан



1 өвс тэжээлийн агуулах  
Ус цэвэршүүлэх байгууламж



1 цамхагт харуулын байр



Бие засах газрын байгууламж - 104 ширхэг



Эрүүл мэндийн үйлчилгээ - 8502 ахмад настан, 3028 хүүхэд



Хог хаягдалд зориулсан ланфиллын байгууламж - 1



Бүрэн тохижуулсан аймгийн 1 музейн барилга, музейн тохижилт - 5 төсөл



2 удаагийн аймгийн хэмжээний мал угаалга - 5642 өвөлжөө хаваржаа ариутгал, 2.5 сая мал угаалга, ариутгал



Хүлэмж нийлүүлэлт-623 ширхэг



1 махны үйлдвэрийн барилга, 1 цэвэр усны цех



Тоног төхөөрөмж, тавилга, эдлэл хэрэгсэл нийлүүлэлт, тохижилт - 180 төсөлд 40,162 ширхэг



Түүх соёлын дурсгалт зүйл хадгалалт, хамгаалалтын ажил - 10 төсөл



5.3 км цахилгаан дамжуулах шугам, шугамын өргөтгөл 1, дэд станц 2



6.5км ус зайлуулах шугам, 19.98 бохир усны шугам, 20.1 км цэвэр усны шугам



1 спорт заал



Судалгаа, нэвтрүүлэг - 9 төслийн хүрээнд 2952 ном, гарын авлага, 3 хөрөг нэвтрүүлэг болон дүрс бичлэг хийсэн



Үерийн далан, суваг - 1.6 км

# “ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-ИЙН НИЙГМИЙН САЙН САЙХНЫ ТӨЛӨӨ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, АМЖИЛТ БҮТЭЭЛИЙН ОН ДАРААЛАЛ



Өмнөговь аймаг, Ханбогд сум, “Оюу толгой” компани хооронд Хамтын ажиллагааны гэрээ байгуулав



Баян-Овоо сумын эрүүл мэндийн төвийн барилгыг санхүүжүүлэв



Ханбогд сумын сум дундын малын эрүүл мэндийн төвийн барилга санхүүжүүлэв




Ханбогд сумын бүрэн тохижсон 640 хүүхдийн сургууль, 200 хүүхдийн цэцэрлэгийн барилга санхүүжүүлэв



Өмнөговь аймгийн 15 сумын 5951 малчин-өрхийн 2,5 сая толгой бог мал угааж сум бүрт суурин ванн барьсан



Ханбогд сумын өвс тэжээлийн агуулахыг барилга санхүүжүүлж ашиглалтад оруулав



Цогт-Овоо сумын 15 ортой эрүүл мэндийн төвийн барилга санхүүжүүлэв



“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-аас санхүүжүүлсэн Өмнөговь аймгийн Говийн байгаль түүхийн музейн барилга Монгол улсын шилдэг барилгаар шалгарлаа



Цогт-Овоо сумын 15 ортой эрүүл мэндийн төвийн барилга

2015

4 ТЭРБУМ ₮



Анхны хөрөнгө оруулалт- Даланзадгад сумын 25, 26-р цэцэрлэгийн барилга санхүүжүүлэв

2016

14 ТЭРБУМ ₮



Даланзадгад сумын 2-р сургуулийн заалын барилга санхүүжүүлэв

2017

26 ТЭРБУМ ₮



Ханбогд, Манлай сумын уурын зуухны төсөл санхүүжүүлэв

2018

38 ТЭРБУМ ₮



Мандал-Овоо сумын эрүүл мэндийн төвийн барилга санхүүжүүлэв



Өмнөговь аймгийн сумдад санхүүжилтийн квот олгож эхлэв

2019

51 ТЭРБУМ ₮



Манлай сумын 100 хүүхдийн цэцэрлэгийг барилгыг санхүүжүүлэв

2020


66 ТЭРБУМ ₮



Даланзадгад сумын 1200 хүүхдийн сургууль, 200 хүүхдийн цэцэрлэгийн барилгын шав тавьж ажил эхлүүлэв

2021


82 ТЭРБУМ ₮



Өмнөговь аймгийн Газрын харилцаа, барилга хог байгуулалтын газар, Мөнгөлын Барилгачдын холбооноос “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-г оруулагчаар өргөмжлөв

2022

101 ТЭРБУМ ₮



Ханбогд сумын төвийн 9.5 км цэвэр, 9 км бохир усны шугам угсралтын ажил санхүүжүүлж ашиглалтад оруулав

2023

122 ТЭРБУМ ₮



## “ИРЭЭДҮЙ ХОЙЧ ҮЕИЙН ТӨЛӨӨ САН”

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан” нь Хамтын ажиллагааны гэрээний зорилгод хүрч ажиллахын тулд Санхүүжилтийн удирдамжид заасны дагуу жилийн нийт санхүүжилтийнхээ 6%-ийг Өмнөговийн ирээдүй хойч үеийнхэнд зориулан “Өмнөговийн ирээдүй хойч үеийн төлөө сан” хэлбэрээр хуваарилдаг. Энэхүү хойч үедээ зориулсан санд хуваарилсан санхүүжилтийг:

- “Говийн оюу - Бизнес боломж” бизнесийн бичил зээлийн хөтөлбөр,
- Тусгай нөхцөлт Хадгаламж,
- “Говийн оюу - Оюутны тэтгэлэг” гэсэн үндсэн гурван хэлбэрээр хуваарилан зохих журмын дагуу зарцуулж байна.

## “ГОВИЙН ОЮУ-БИЗНЕС БОЛОМЖ” БИЗНЕСИЙН БИЧИЛ ЗЭЭЛ



ГОВИЙН ОЮУ  
ХӨГЖЛИЙГ  
ДЭМЖИХ САН



ХААН БАНК

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан” нь 2016 оноос хойш “Говийн оюу-Бизнес боломж” нэртэй орон нутгийн жижиг бизнесийг дэмжих санхүүжилтийн хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа бөгөөд уг бизнесийн бичил зээлийг Хаан банкаар дамжуулан олгож байна. 2016-2023 онд Өмнөговь аймгийн **93** бизнес эрхлэгч иргэдэд **3.5 тэрбум төгрөгийн** зээл олгосноос 2023 онд **34** бизнес эрхлэгч иргэдэд **1.9 тэрбум төгрөгийн** зээл олгосон байна.

### Бизнес эрхлэгчдэд олгосон зээлийн мэдээлэл

Сум	Зээлийн тоо	Олгосон зээл /өссөн дүнгээр/
Даланзадгад	74	3,076,034,300
Баян-Овоо	1	35,000,000
Ханбогд	10	177,000,000
Манлай	4	115,020,000
Мандал-Овоо	2	37,500,000
Сэврэй	2	86,000,000
<b>Нийт</b>	<b>93</b>	<b>3,526,554,300</b>

“Говийн оюу-Бизнес боломж” бичил зээлийн хүрээнд 2016-2023 онд нийт **179** ажлын байр шинээр бий болгосноос **83** түр ажлын байр, **96** байнгын ажлын байр шинээр бий болсон байна.

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Сангийн Удирдах зөвлөлийн 2022 оны шийдвэрээр “Говийн оюу-Бизнес боломж” бичил бизнесийн зээлийн хүү жилийн 12% байсныг бууруулан Хаан банктай тохиролцож жилийн хүүг **7.2%**, буюу сарын хүүг **0.6%** байхаар тогтоож, бизнесийн төрлөөс хамаарч нэг зээлдэгч 80-100 хүртэлх сая төгрөгийн зээл авах боломжтой болгосон.




Итгэцээг суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ

### Хөнгөлөлттэй зээлийн нөхцөл

Зээлийн төрөл	Зээлийн дээд хэмжээ	Хүү /жилийн/	Хугацаа
Эргэлтийн хөрөнгө нэмэгдүүлэх	80.0 сая хүртэл төгрөг	7.2%	36 хүртэл сар буюу хамтран ажиллах гэрээний дуусах хугацаанаас хэтрэхгүй байна
Хөрөнгө оруулалтын зээл	100.0 сая хүртэл төгрөг	7.2%	60 хүртэл сар буюу хамтран ажиллах гэрээний дуусах хугацаанаас хэтрэхгүй байна

### 2016-2023 онд зээл авсан бизнес эрхлэгчдийн харьяалал, олгосон зээлийн тоон мэдээлэл

Олгосон бичил зээлийн зориулалт





## “ГОВИЙН ОЮУ-БИЗНЕС БОЛОМЖ” ХӨНГӨЛӨЛТТЭЙ БИЧИЛ ЗЭЭЛИЙН ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДАН 2023 ОНД БИЗНЕСИЙН ЗЭЭЛ АВСАН БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС ДУРДВАЛ:

“Говийн оюу-Бизнес боломж” хөнгөлөлттэй зээлд хамрагдсан  
Баян-Овоо сумын бизнес эрхлэгч: Д.Мөнхнаран



### **Д.Мөнхнарангийн сэтгэгдэл:**

Баян-Овоо сумын бизнес эрхлэгч Дэлгэрбаяр овогтой Мөнхнаран миний бие нь Говийн оюу төсөлд OPPO хятад брэндийн гар утас худалдан борлуулах төсөл бичиж төслийн зээлд хамрагдсан. Уг төслийн зээлд хамрагдсанаар бизнес маань өргөжиж Гашуун сухайт хилийн боомт дахь Цагаан хад суурьшлын бүсэд салбар дэлгүүрээ нээснээр бизнесийн ашиг орлого нэмэгдэж ажил болон амьдралд өөрчлөлт дэвшилт гарсан. Бага хүүтэй зээл гэдэг бол бидэнд маш их тус дэм болсон төсөл байлаа. Уг төсөлд хамрагдсандаа маш их баяртай байгаа. Оюутолгой компани болон ХААН банкны хамт олондоо үргэлж баярлаж талархаж явдгаа илэрхийлье. Цаашдаа олон гэр бүлд гэрэл цацуулж хийж буй ажлаасаа үр шимээ хүртэж сайн сайхан амьдрах гүүр нь болоорой. Та бүхэндээ баярлалаа ажлын өндөр амжилт хүсье.

“Говийн оюу-Бизнес боломж” хөнгөлөлттэй зээлд хамрагдсан  
Даланзадгад сумын бизнес эрхлэгч: А.Мөнхчимэг



### **А.Мөнхчимэгийн сэтгэгдэл:**

Даланзадгад сумын бизнес эрхлэгч А.Мөнхчимэг нь Гандирс худалдааны төвд лангуу түрээслэн хүүхдийн хувцас худалдаалдаг ба “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн зээлд хамрагдсанаар салбар дэлгүүр нээх зорилгоор шинээр ашиглалтад орж буй барилгад үйлчилгээний талбай



худалдан авсан. Харилцагчийн сэтгэгдэл “Миний амьдралд үр өгөөжөө өгсөн хүү бага сайхан зээл таарлаа. Санхүүгийнхээ хэрэгцээг хангаж хүү багатай зээл авсандаа маш их баяртай байгаа. Та бүгдийн ажилд өндрөөс өндөр амжилт хүсье”

**“Говийн оюу-Бизнес боломж” хөнгөлөлттэй зээлд хамрагдсан  
Даланзадгад сумын бизнес эрхлэгч: Б.Нямсүрэн**



**Б.Нямсүрэнгийн сэтгэгдэл:**

Даланзадгад сумын бизнес эрхлэгч Б.Нямсүрэн “Сувд” гоо сайхны салоныг үүсгэн байгуулагч. Миний бие салонхоо эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэхэд зориулан тус төслийн зээлд хамрагдсан. Өмнө нь банкны энгийн нөхцөлтэй бизнесийн зээл авдаг байсан. Энэ төслийн зээл хүү бага байгаа нь бидэнд маш их өгөөжөө өгч байгаад талархаж байна.

**“Говийн оюу-Бизнес боломж” хөнгөлөлттэй зээлд хамрагдсан  
Даланзадгад сумын бизнес эрхлэгч: Б.Оюу**



**Б.Оюугийн сэтгэгдэл:**

Даланзадгад сумын бизнес эрхлэгч Б.Оюу миний бие нь түрээсийн байранд жимсний дэлгүүр ажиллуулдаг байсан. “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн хөнгөлөлттэй нөхцөл бүхий хөрөнгө оруулалтын зээлийг авч 299.58м.кв талбайтай 2 давхар үйлчилгээний төвийн барилгыг барьж шинэ оны босгон дээр ашиглалтад оруулан аймгийнхаа иргэдэд үйлчилж байна. Энэхүү зээл нь бизнес эрхлэгч бидэнд маш том боломж олгож байгаад таатай байна. Бидний үйл ажиллагааг дэмжин таатай нөхцөл бүхий зээлийн санал тавьсан танай хамт олонд маш их баярлалаа. Та бүхэнд шинэ оны мэнд хүргэе.





**“Говийн оюу-Бизнес боломж” хөнгөлөлттэй зээлд хамрагдсан  
Даланзадгад сумын бизнес эрхлэгч: О.Алимаа**



**О.Алимаагийн сэтгэгдэл:**

Даланзадгад сумын бизнес эрхлэгч О.Алимаа миний бие нь Гандирс худалдааны төвд талбай түрээслэн хүүхдийн хувцасны худалдаа эрхэлдэг ба “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн жилийн 7.2% хүүтэй хөрөнгө оруулалтын зээл авч 2 давхар 190.98 м.кв талбайтай үйлчилгээний төвийн барилгыг барьж ашиглалтад оруулан иргэдэд ая тухтай орчинд үйлчилгээ үзүүлэх үзүүлж байгаадаа баяртай байна. Сарын 0.6% гэдэг нь бизнес эрхлэгч бидэнд аймаг орон нутагтаа өөрсдийн хүч хөдөлмөрөөр бизнесээ өргөжүүлэхэд маш том дэмжлэг болж байгаад талархалтай байна.

**“Говийн оюу-Бизнес боломж” хөнгөлөлттэй зээлд хамрагдсан  
Даланзадгад сумын аж ахуй нэгж байгууллага: “Манал говь” ХХК**



**“Манал говь” ХХК-ийн хамт олны сэтгэгдэл:**

“Манал говь” ХХК нь Өмнөговь аймгийн Даланзадгад суманд уламжлалт анагаах ухаан, шүдний эмнэлгийн үйл ажиллагаа явуулдаг билээ. Манай компани нь 2023 онд шинэ эмнэлгийн байртай болон хэвтэн эмчлүүлэх тасаг нэмэгдэн өргөжсөн ба эмнэлгийн байрны тохижилтын ажилдаа зориулан “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-аас “Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих хөнгөлөлттэй зээл”-д хамрагдан жилийн 7.2%-ийн хүүтэй зээл авч өөрийн эмнэлгийн байраа тохижуулсан. Энэхүү зээл нь хугацаа урт хүү багатай учир өөрсдийн бизнесээ эхлүүлж буй мөн үйл ажиллагаагаа өргөжүүлж буй бизнес эрхлэгч нарт маш том санхүүгийн боломж олгодог. Бидний бизнесийн үйл ажиллагааг дэмжин орон нутагтаа нэгэн шинэ эмнэлгийг хамтдаа бий болгон, тогтвортой ажлын байрыг нэмэгдүүлэн, иргэдэд ая тухтай орчинд эмчлүүлэх, үйлчлүүлэх боломжийг олгосон та бүхэндээ баярлалаа.



**“Говийн оюу-Бизнес боломж” хөнгөлөлттэй зээлд хамрагдсан  
Мандал-Овоо сумын бизнес эрхлэгч: Д.Будхүү**



**Д.Будхүүгийн сэтгэгдэл:**

Мандал-Овоо сумын бизнес эрхлэгч Д.Будхүү нь модон эдлэлийн цех ажиллуулдаг. “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн зээлд хамрагдсанаар цехийн тоног төхөөрөмжөө шинэчилсэн. Уг төслийн зээл нь бидний амьдрал болон хийж байгаа ажилд маш их дэмжлэг болсон. “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн зээлд хамрагдсандаа сэтгэл хангалуун байна.

**“Говийн оюу-Бизнес боломж” хөнгөлөлттэй зээлд хамрагдсан  
Сэврэй сумын бизнес эрхлэгч: Б.Анхбаяр**



**Б.Анхбаярын сэтгэгдэл:**

Сэврэй сумын бизнес эрхлэгч Бямбаа овогтой Анхбаяр нь тус суманд хүнс, барааны дэлгүүр ажиллуулдаг. Миний бие нь банкны энгийн нөхцөлтэй бизнес зээлийн нь хүү өндөр байдаг учир тэр бүр зээл аваад байдаггүй байсан. “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн зээл нь хүү багатай зээл учир бид бүхний үйл ажиллагааг дэмжсэн зээл гэж харж байна. Хаан банктай хамтран хэрэгжүүлж буй төсөл нь үнэхээр нүдээ олсон харилцагч нарт хүртээмжтэй зээл байна. Сэтгэгдэл өндөр байна.



## “ИРЭЭДҮЙ ХОЙЧ ҮЕИЙН ТӨЛӨӨ САН”-ИЙН ТУСГАЙ НӨХЦӨЛТ ХАДГАЛАМЖ

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан” нь Өмнөговь аймгийн хүүхэд залуучуудад зориулан жил бүрийн нийт санхүүжилтийн **2%**-ийг **10** жилийн хугацаатай хадгаламжид байршуулж байна. Уг хадгаламжийг 2016 онд нээж одоогийн байдлаар **3.3 тэрбум** төгрөг хуримтлуулаад байна.

Ирээдүй хойч үеийн төлөө сангийн журмын дагуу уг хадгаламжийн эх үүсвэрийг Өмнөговь аймгийн ирээдүй хойч үеийнхэнд зориулсан эрсдэл багатай, урт хугацааны хөрөнгө оруулалт шаардагдах төсөл хөтөлбөрт дэмжихэд зарцуулах эсвэл үргэлжлүүлэн хадгалах ажлыг 2026 онд шийдвэрлэнэ.

## “ГОВИЙН ОЮУ - ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГ” ХӨТӨЛБӨР

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-аас Өмнөговь аймгийн ирээдүй хойч үеийн төлөө зориулан хэрэгжүүлдэг томоохон хөтөлбөрүүдийн нэг нь “Говийн оюу - Оюутны тэтгэлэг” хөтөлбөр юм. Уг хөтөлбөрийг 2023 онд 8 дахь жилдээ амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна.

“Говийн оюу - Оюутны тэтгэлэг” хөтөлбөр нь магадлан итгэмжлэгдсэн дотоодын их дээд сургуульд Өмнөговь аймагт хэрэгцээтэй байгаа мэргэжлээр амжилттай суралцаж буй Өмнөговь аймгийн оюутнуудыг дэмжих зорилгоор сургалтын бүрэн тэтгэлэг болон нэг удаа аймагтаа ирэх зардлыг мөн өгдөг.

“Говийн оюу - Оюутны тэтгэлэг” хөтөлбөрт 2016 онд 30, 2017 онд 57, 2018 онд 55, 2019 онд 45, 2020 онд 47, 2021 онд 90, 2022 онд 81, 2023 онд 112 оюутан тус тус хамруулсан бөгөөд 2016-2023 онд давхардсан тоогоор Өмнөговь аймгийн 517 оюутанд 1.5 тэрбум төгрөгийн тэтгэлэг олгосон. Тэтгэлэгт хамрагдаж төгссөн оюутнуудын 85% нь эзэмшсэн мэргэжлээрээ орон нутагтаа ажиллаж, 4% нь ажил идэвхтэй хайж, 11 хувь нь дараагийн шатны сургалтад хамрагдаж байна.




2023-2024 оны хичээлийн жилийн тэтгэлэгт хөтөлбөрийн хэрэгжилтийн тухайд:


- Өмнөговь аймгийн ЗДТГ-аас тус аймагт хэрэгцээтэй байгаа мэргэжлийн чиглэлийг санд ирүүлсний дагуу аймгийн ЗДТГ-ын боловсрол, хүний нөөцийн мэргэжилтнүүд, Ханбогд сумын төлөөлөл, “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-гийн төлөөлөл болон хөтөлбөрийн удирдах байгууллагаар сонгогдсон “Говийн оюуны хөтөч” төрийн бус байгууллага, Өмнөговь аймагт боловсролын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын төлөөлөөс бүрдсэн сонгон шалгаруулах хороо 2023-2024 оны хичээлийн жилд тэтгэлэгт хамрагдах оюутнуудыг сонгон шалгаруулсан.
- “Говийн оюу - Оюутны тэтгэлэг” хөтөлбөрийн хүрээнд 2023 онд магадлан итгэмжлэгдсэн дотоодын их, дээд сургуульд Өмнөговь аймагт дутагдалтай байгаа мэргэжлээр амжилттай суралцаж байгаа тэтгэлгийн гэрээгээ сунгасан болон шинээр тэтгэлэгт хамрагдсан нийт 112 оюутанд тэтгэлэг олгосон.



### Тэтгэлэг авсан оюутнуудыг сумдаар ангилсан байдал




### 2016-2023 онд "Говийн оюу-оюутны тэтгэлэг" хөтөлбөрт хамрагдсан оюутнуудын сумын харьяалал




Он	Баяндалай	Баян-Овоо	Булган	Гурвантэс	Даланзадгад	Мандал-Овоо	Манлай	Ноён	Номгон	Сэврэй	Ханбогд	Ханхонгор	Хүрмэн	Цогт-Овоо	Цогтцэций
2016	1			1	18		1	1	1	1	3	1		2	
2017	5	2	1		33	1	4	1	1	1	2	3		2	1
2018	3	3	2	2	31	1	3		1		3	3	1	1	1
2019	3	2	3	1	23	1	3	1	1	1	2	1	1	2	1
2020	3	1	3	4	16	1	2		3	5	1		2	1	5
2021	4		2	7	47	2			4	7	4	2	2	2	7
2022	7	1	3	5	38		3	1	2	6	3	1	3	4	4
2023	5	1	4	13	55		3	1	3	6	2	2	4	3	10



### “ГОВИЙН ОЮУ- ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГ” ХӨТӨЛБӨРТ 2023 ОНД ХАМРАГДСАН ОЮУТНУУДЫН МЭРГЭЖЛИЙН ЧИГЛЭЛ



### “ГОВИЙН ОЮУ- ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГ” ХӨТӨЛБӨРТ 2016-2023 ОНД ХАМРАГДСАН ОЮУТНУУДЫН МЭРГЭЖИЛ






Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ

“ГОВИЙН ОЮУ-ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГ” ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДАН ТӨГССӨН  
ОЮУТНУУДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ

Тэтгэлэгт хамрагдан төгссөн оюутнуудын мэдээлэл  
(төгссөн оюутны тоо: 116)





“ГОВИЙН ОЮУ-ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГ” ХӨТӨЛБӨРТ 2023-2024 ОНЫ  
ХИЧЭЭЛИЙН ЖИЛД ХАМРАГДСАН ОЮУТНУУД



**Д.АЛТАНЖАРГАЛ**

Этүгэн-Шүдний эмч



**Ц.АМИНА**

Монгол улсын  
консерватори-Лимбэчин



**З.АНАРБОЛД**

ШУТИС-Маркшейдр



**Г.АНУУЖИН**

МУБИС-Нийгмийн  
ажилтан



**Г.АНХАА**

Этүгэн-Эмч



**У.БААСАНСҮРЭН**

МУИС-Аялал жуулчлал



**Э.БАДАМХАНД**

АШУУИС-Дүрс  
оношилгооны техникч



**Т.БАДАМХАНД**

Идэр их сургууль-  
Нийгмийн ухааны багш



**Ү.БАТБАЯР**

Үндэсний техникийн  
ИС-Уул уурхайн ашиглалт  
технологи



**Э.БАТПҮРЭВ**

ХААИС-Барилгын  
инженер



**Б.БАТХИЛЧИН**

Үндэсний техникийн  
ИС-Уул уурхайн ашиглалт  
технологи



**Б.БАТХИШИГ**

ХААИС-Мал зүйч



**Р.БАЯРМАА**

МУИС-Археологи



**С.БАЯРМӨНХ**

Этүгэн ИС-Шүдний эмч



**У.БИЛГҮҮН**

ШУТИС-Уул уурхайн  
машин тоног төхөөрөмж



**С.БОЛОР**

Этүгэн-Эмч



**Ү.БОЛОРЗУЛ**

МУБИС-Нийгмийн ухааны  
багш



**А.БОЛОРОО**

Этүгэн ИС-Эмч



**О.БУДДОРЖ**

Үндэсний техникийн ИС-  
Уул уурхайн ашиглалтын  
технологи



**Т.БУЛГАНТАМИР**

АШУУИС-Шүдний эмч



**Б.БУЯНДЭЛГЭР**

АШУУИС-Эм зүйч



**Э.БУЯНДЭЛГЭР**

Этүгэн ИС-Эм зүйч



**Д.БУЯНЖАРГАЛ**

ШУТИС- Робот хиймэл оюун ухаан



**Б.ГАНЦЭЦЭГ**

Этүгэн ИС-Шүдний эмч



**Э.ДАЛАЙЖАРГАЛ**

МУИС-Археологи



**Б.ДОЛГОРЦЭНД**

ХААИС-Аялал жуулчлал



**Б.ДОРЖЦЭНД**

Их засаг их сургууль-Архитектур



**П.ДӨЛГӨӨН**

АШУУИС-Хүүхдийн эмч



**А.ДЭЛГЭРМАА**

АШУУИС-Эмч



**Х.ЕСҮЖИНГОО**

Глобал удирдагч-Эмч



**Б.ЖАМЦ**

ШУТИС-Программ хангамж



**Н.ЖЕНСТЕР**

ШУТИС-Уул уурхайн ашиглалтын технологи



**Д.ЖИМСМАА**

Их засаг их сургууль-Бага ангийн багш



**Ө.ЗАЯА**

МУИС-Англи хэлний багш



**Б.ЗОЛЖАРГАЛ**

АШУУИС-Уламжлалт эмчилгээний эмч



**Б.ЗОЛЗАЯА**

АШУУИС-Шүдний эмч



**ГИТГЭЛТТАЙВАН**

Их засаг их сургууль-Жүжигчин



**Т.ЛХАГВА-ОЧИР**

ШУТИС- Уул уурхайн машин тоног төхөөрөмж



**Б.ЛХАМЖАРГАЛ**

МУИС-Биологийн багш



**И.ЛХАМ-ОСОРЖИН**

МУИС-Нийгмийн ажилтан



**О.МАНДУХАЙ**

Этүгэн ИС-Эм зүйч



**Б.МАРАЛГОО**

ШУТИС-Мэдээлэл технологи



**О.МАРАЛ-ЭРДЭНЭ**

ХҮИС-Сэтгэлзүйч



**О.МИЧИДМАА**

Этүгэн ИС-Эм зүйч



**С.МӨНГӨНЗУЛ**

Шинэ анагаах ухааны ИС-Эм зүйч





**Т.МӨНГӨНЗУЛ**

АШУУИС-Эмч



**Ц.МӨНХ-ОРГИЛ**

Энэрэл дээд сургууль-  
Эм зүйч



**Ж.МӨНХСАЙХАН**

ШУТИС-Системийн  
аюулгүй байдал



**Ж.МӨНХЦЭЦЭГ**

Их засаг ИС-Дулааны  
инженер



**С.МЯГМАРБАЯР**

ХУИС-Программ хангамж



**М.МЯГМАРСҮРЭН**

МУБИС-Математикийн  
багш



**Ж.МЯГМАРСҮРЭН**

Этүгэн ИС-Шүдний эмч



**Х.НАМУУН**

ХУИС-Сэтгэлзүйч



**М.НАМУУН**

МУБИС-Нийгмийн  
ажилтан



**М.НАМУУНДАРЬ**

Рояль олон улсын их  
сургууль-Архитектур



**Г.НАМУУНСАЙХАН**

МУИС-Сэтгэл судлал



**Г.НАНДИНБОЛОР**

АШУУИС-Эмч



**Б.НАНДИНСҮРЭН**

МУБИС-Аялал жуулчлал



**Г.НАНДИН-ЭРДЭНЭ**

Этүгэн ИС-Эм зүйч



**Ц.НАРАНЦЭЦЭГ**

МУИС-Хүрээлэн буй  
орчны инженер



**Г.НАСАНЖАРГАЛ**

МУБИС-Нийгмийн  
ажилтан



**Б.НАСАНТОГТОХ**

ХААИС-Байгаль орчны  
нөхөн сэргээлт



**Б.НАСАНЦЭЦЭГ**

АШУУИС-Шүдний эмч



**У.НИНЖИН**

Этүгэн ИС-Эм зүйч



**Б.НОМИН**

МУБИС-Сэтгэл судлал



**М.НОМИНЦЭЦЭГ**

Их засаг их сургууль-  
Архитектур



**Н.НОМИНЧУЛУУН**

АШУУИС-Эм зүйч



**Б.НЭМЭХБАЯР**

Их засаг их сургууль-Эмч



**Ц.НЯМДАРЬ**

МУИС-Нийгмийн ажилтан



**Б.ОДОНЗОРИГ**

Этүгэн ИС-Эмч



**И.ОТГОНЖАРГАЛ**

ХААИС-Хүнсний чанар эрүүл ахуйн үнэлгээ



**А.ОЮУНБОЛОР**

АШУУИС-Шүдний эмч



**Х.ОЮУ-ЭРДЭНЭ**

Этүгэн ИС-Хүний их эмч



**Б.ӨЛЗИЙНАРАН**

ШУТИС-Мэдээллийн систем



**Б.ӨНӨБОЛД**

МУИС-Программ хангамж



**Б.ӨСӨХБАЯР**

Их засаг олон улсын их сургууль-Программ хангамж



**Ц.САРАНГУА**

Нийгмийн сэтгэл судлалын дээд сургууль-Сэтгэл судлал



**Б.САРАНТУЯА**

ШУТИС-Нийгмийн ажилтан



**О.САРАНЦАЦРАЛТ**

МУБИС-Нийгмийн ажилтан



**Н.СУГИРСҮРЭН**

Их засаг олон улсын их сургууль-График дизайн



**Г.СУХБАТ**

МУИС-Геологи



**М.СУХБАТ**

ШУТИС-Уул уурхайн машин тоног төхөөрөмж



**Б.ТӨГӨЛДӨР**

МУИС-Программ хангамж



**Н.ТӨРБАЯР**

Их засаг олон улсын их сургууль-Архитектур



**Э.ТҮВШИНБАЯСАХ**

Шинэ Монгол технологийн коллеж-Барилгын инженер



**Т.ТЭГШБАЯР**

Төмөр замын дээд сургууль-Тээврийн зохион байгуулалт



**Б.УУГАНЦЭЦЭГ**

МУБИС-Насан туршийн боловсролын багш



**Б.УУГУУЛСАЙХАН**

АШУУИС-Хүүхдийн эмч



**Э.ҮРЖИНБАДАМ**

ШУТИС-Архитектур



**Ц.ХАЛИУНЗАЯА**

МУИС-Программ хангамж



**Ш.ХАНГАРЬД**

ШУТИС-Системийн аюулгүй байдал



**Ц.ХУЛАН**

СУИС-Журжигчин



**Б.ХУЛАН**

АШУУИС-Шүдний эмч



**Т.ХУНЗУЛ**

Этүгэн ИС-Эм зүйч



**А.ЦОГДЭЛГЭР**

ХААИС-Байгаль орчны нөхөн сэргээлт



**О.ЦЭНГҮҮН**

МУИС-Программ хангамж



**С.ЦЭНГЭЛМАА**

Этүгэн ИС-Шүдний эмч



**М.ЦЭНГЭЛМАА**

АШУУИС-Хоол зүйч



**М.ЦЭНД-АЮУШ**

АШУУИС-Эмч



**Ө.ЦЭРЭНБАЯР**

МУБИС-Монгол хэл, уран зохиолын багш



**Э.ЦЭРЭНЧУНТ**

ХААИС-Барилгын инженер



**Б.ЦЭЦЭГДЭЛГЭР**

Этүгэн ИС-Шүдний эмч



**Г.ЧОГЖИНМАА**

МУБИС-Аялал жуулчлал



**Б.ЭНХЗУЛ**

МУИС-УБ сургууль-Археологи



**Э.ЭНХЦЭЦЭГ**

ШУТИС-Уул уурхайн механик инженер



**Б.ЭНЭРЭЛ**

Ач анагаах ухааны их сургууль- Эмч



**Э.ЭРДЭНЭБУЛГАН**

АШУУИС-Эмч



**Д.ЭРДЭНЭХИШИГ**

АШУУИС-Эмч



**М.ЭРДЭНЭЦЭЦЭГ**

МУБИС-Сэтгэл судлал



**О.ЭРДЭНЭЧИМЭГ**

ШУТИС-График дизайн



**Б.ЭРСҮҮХ**

Оточ манрамба-Уламжлалт эмчилгээний эмч



**Б.ЭРХЭМЗАЯА**

АШУУИС-Эх баригч



Итгэцээг сууринсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ





## ХАНДИВ ТУСЛАМЖ

“Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” нь Хандив тусламжийн журмын дагуу Өмнөговь аймаг, тус аймгийн сумдад шаардлагатай тулгамдсан асуудал, журамд заасан хандивын төрлийн дагуу 2016-2023 онд 3.1 тэрбум төгрөгийн Хандив тусламж олгосон байна.

2023 онд дараах чиглэлүүдээр нийт 79.2 сая төгрөгийн хандив тусламж олгосон байна.


### “ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-ААС 2023 ОНД ОЛГОСОН ХАНДИВ





“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-ААС  
2016-2023 ОНД ОЛГОСОН НИЙТ ХАНДИВ


2016-2023 онд олгосон хандив



Он	Тоо	Дүн
2016	5	33,000,000
2017	12	368,125,762
2018	20	175,412,560
2019	25	370,588,700
2020	11	322,595,920
2021	4	866,500,000
2022	16	917,950,000
2023	15	79,229,000
<b>Нийт</b>	<b>93</b>	<b>3,133,401,942</b>

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-ААС  
2016-2023 ОНД ОЛГОСОН НИЙТ ХАНДИВЫН ЗОРИУЛАЛТ

2016-2023 онд олгосон хандивыг төгрөгөөр харуулав



## 2023 ОНЫ 1-Р УЛИРЛЫН ОНЦЛОХ МЭДЭЭ



“Говийн оюу хөгжлийг дэмжих сан” 2022 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангаа боловсруулан Англи, Монгол хэл дээр 2300 хувь хэвлэн нийтэд тарааж танилцуулж [www.goviioyu.mn](http://www.goviioyu.mn) цахим хуудсанд байршууллаа.

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн санхүүжилттэй дэд бүтцийн төслүүд төлөвлөгөөний дагуу оны 1-р улирлаас үргэлжлэн хэрэгжсэн.



Өмнөговь аймгийн ИТХ-аас жил бүрийн сар шинийн босгон дээр улиран одож буй жилд Өмнөговь аймгийн хөгжил цэцэглэлтэд хувь нэмэр оруулсан, эрхэлсэн ажилдаа онцгой амжилт гаргасан байгууллага, хувь хүмүүсийг шалгаруулан шагнаж урамшуулдаг “Аймгийн 9 алдартан” шагналаар “Оюу толгой” ХХК-ийн хөрөнгө оруулалттай “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” “Шилдэг хөрөнгө оруулагч” номинацид нэр дэвшин шалгарч “Аймгийн 9 алдартан”-ны нэг болж туулай жилийн сар шинийн босгон дээр энэхүү нэр хүндтэй шагналаа хүлээн авлаа. “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн шийдвэрээр “Аймгийн 9 алдартны шагнал”-ын 1,000,000 төгрөгийн татварын дараах орлого 900,000 төгрөгийг 2023 оны төсөл хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэрт хуваарилсан.

Манлай, Баян-Овоо, Ханбогд сумдын тэмээний баярт зориулан хандив олгож өв соёлоо түгээн дэлгэрүүлэх үйлст дэмжлэг үзүүлж хамтран ажиллаа.



# САНГИЙН 2023 ОНЫ

## 2023 ОНЫ 2-Р УЛИРЛЫН ОНЦЛОХ МЭДЭЭ

Харилцааны хороо болон “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөл хуралдаж Санд ирсэн төсөл хөтөлбөрийн саналуудтай танилцаж Ковид-19 цар тахлын үеийн үнийн өсөлттэй холбоотойгоор өмнөх онуудад хэрэгжиж эхэлсэн дэд бүтцийн 3 төслийн нэмэлт санхүүжилт болон 4 шинэ төслийн санхүүжилтийг баталж, Сангийн үйл ажиллагаатай холбоотой бусад асуудлуудыг хэлэлцэн шийдвэр гаргалаа



“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн 2022 оны үйл ажиллагаа болон санхүүгийн үйл ажиллагаанд Грант Торнтон аудитын компаниас аудит хийж дүгнэлт гаргалаа.



“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн шийдвэрийн дагуу Өмнөговь аймгийн 15 сумын Засаг дарга нартай санхүүжилтийн квотын гэрээ байгуулж өмнөх онуудад санхүүжилтийн квотоор хэрэгжсэн төсөл хөтөлбөрүүдтэй танилцсан.



# ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ



“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн санхүүжилттэй Өмнөговь аймгийн хэмжээний болон сумдын санхүүжилтийн квотын төслүүд гэрээ, төлөвлөгөөний дагуу амжилттай хэрэгжиж байна.



## 2023 ОНЫ 3-Р УЛИРЛЫН ОНЦЛОХ МЭДЭЭ



“Говийн оюу-Оюутны тэтгэлэг” хөтөлбөр 8 дахь жилдээ амжилттай хэрэгжиж 2023-2024 оны хичээлийн жилд Өмнөговь аймагт хэрэгцээтэй мэргэжлээр сурч буй Өмнөговь аймгийн 112 оюутанд тэтгэлэг олголоо.



Өмнөговь аймгийн наадам, тус аймгийн Манлай, Сэврэй, Мандал-Овоо, Хүрмэн, Баяндалай, Ноён, Ханбогд сумдын наадам болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих зорилготой Говь-трай-2023 үйл ажиллагаанд нийт 61.2 сая төгрөгийн хандив олгосон.



# САНГИЙН 2023 ОНЫ

# ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ



"Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-ийн 2024-2027 оны 5 жилийн стратегийг тодорхойлох ажил зохион байгуулж зөвлөх үйлчилгээ үзүүлэх байгууллага сонгон шалгаруулж ажил эхлүүлээ.




"Оюу толгой" компанид аудит хийсэн Коппер марк компанийн аудитад "Оюу толгой" компаниас оруулсан орон нутгийн хөрөнгө оруулалт буюу "Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-аас санхүүжүүлэн хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүдийн мэдээлэл өгсөн. Рио Тинто компанийн Нийгмийн хөрөнгө оруулалт хариуцсан багийнханд Сангийн үйл ажиллагааны мэдээлэл өгсөн.



"Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-аас 2023 онд Өмнөговь аймгийн нийт сумдад олгосон санхүүжилтээр сумд нийт 40 төсөл хөтөлбөр хэрэгжүүлэн сангаас хэрэгжилтэд хяналт тавьж холбогдох санхүүжилтийг олгож ажилласан.



## 2023 ОНЫ 4-Р УЛИРЛЫН ОНЦЛОХ МЭДЭЭ






Харилцааны хороо болон "Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-ийн Удирдах зөвлөлийн хурал зохион байгуулагдаж "Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-ийн үйл ажиллагаатай холбоотой асуудлуудыг хэлэлцэн шийдвэр гаргаж 2024 онд сангаас санхүүжүүлэх 4 төсөл хөтөлбөрийн санхүүжилтийг батлав.

# САНГИЙН 2023 ОНЫ

# ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ

Хараат бус судалгааны хүрээлэл/IRIM/ хамтран Хамтын ажиллагааны гэрээний сэдэвчилсэн 7 хавсралт тус бүрээр олон талт хэлэлцүүлэг зохион байгуулж дуусгав.



“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-аас 2022 онд санхүүжүүлсэн томоохон төсөл хөтөлбөрүүд бүрэн дуусаж ашиглалтад хүлээн авлаа.



“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн танилцуулах материал, брошюр 1500 ширхэг, бусад танилцуулга 2000 ширхгийг хэвлүүлж “Оюу толгой” компанийн нээлтэй өдрүүд, олон нийтийн уулзалт, хурал чуулганы үеэр олон нийтэд түгээж, цаг үеийн мэдээ, мэдээллийг Сангийн цахим хуудас, Facebook хуудсанд цаг тухай бүрд мэдээлсэн. 2023 онд Сангийн Facebook хуудсаар 93.8 мянган хүнд хүрсэн.




## САНХҮҮЖИЛТИЙН ГҮЙЦЭТГЭЛ- 2015-2023 (өссөн дүнгээр)




“ОЮУТОЛГОЙ” ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ /2015-2023/

**122.88 ТЭРБУМ ₮/45.17 САЯ \$**




Төсөл хөтөлбөрийн  
санхүүжилт




Ирээдүй хойч үеийн  
төлөө сан

- Хөнгөлөлттэй зээл
- Оюутны тэтгэлэг
- Ирээдүй хойч үед зориулсан хадгаламж



Орон нутгийн  
хандив



Сангийн үйл  
ажиллагаа, хэвлэл  
мэдээлэл, бусад

## ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-аас 2015-2023 онуудад “Оюу толгой” компаниас хүлээн авсан санхүүжилтийг төсөл хөтөлбөр, ирээдүй хойч үеийн төлөө сан (хөнгөлөлттэй зээл, оюутны тэтгэлэг, ирээдүй хойч үед зориулсан хадгаламж), орон нутгийн хандив, үйл ажиллагаа гэсэн 4 үндсэн чиглэлээр зарцуулан Өмнөговь аймгийн нийгэм эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулан ажиллаж ирсэн.

“Оюу толгой” компаниас 8 жилийн хугацаанд нийт 122.88 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хүлээн авснаас 88.56%-ийг буюу 100 гаруй тэрбум төгрөгийг томоохон хэмжээний 122, санхүүжилтийн квотын 303 буюу нийт 425 төсөл хөтөлбөр санхүүжүүлэхэд зориулсан. Тэдгээр нь бүгд нийгмийн шинж чанартай, олон нийтэд үр ашгаа өгөх төслүүд байсан бөгөөд Өмнөговь аймаг, тус аймгийн Ханбогд сум, “Оюу толгой” компани хооронд байгуулсан Хамтын ажиллагааны гэрээний Сэдэвчилсэн 7 хавсралт болох нийгмийн дэд бүтэц, нийгмийн суурь үйлчилгээ, байгаль орчны менежмент, усны менежмент, уламжлалт мал аж ахуй бэлчээрийн менежмент, үндэсний түүх соёл, аялал жуулчлал, орон нутгийн бизнес хөгжил гэсэн чиглэлийн дагуу хэрэгжиж байна.




Итгэцээг суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ

## САНХҮҮЖИЛТИЙН ГҮЙЦЭТГЭЛ-2023 ОН




“ОЮУТОЛГОЙ” КОМПАНИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ /2023/

**21.62 ТЭРБУМ ₮/6.2 САЯ \$**




Төсөл хөтөлбөрийн  
санхүүжилт




Ирээдүй хойч үеийн  
төлөө сан

- Хөнгөлөлттэй зээл
- Оюутны тэтгэлэг
- Ирээдүй хойч үед зориулсан хадгаламж



Орон нутгийн  
хандив



Сангийн үйл  
ажиллагаа, хэвлэл  
мэдээлэл, бусад


## “ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-ААС САНХҮҮЖҮҮЛСЭН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөл нь 2023 онд шинээр 4 томоохон төсөл, хөтөлбөр, он дамжин хэрэгжиж буй 3 нийгмийн дэд бүтцийн төслийн нэмэлт санхүүжилт олгохоор шийдвэрлэсэн. Мөн Өмнөговь аймгийн нийт сумдад олгосон санхүүжилтийн квотоор мөн онд нийт 68 төсөл, хөтөлбөр хэрэгжээд байна.

Ингэснээр 2023 онд “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” -аас санхүүжилтийн квотын болон Өмнөговь аймагт хэрэгжих томоохон нийт 72 шинэ төсөл, хөтөлбөр санхүүжүүлж Хамтын ажиллагааны гэрээний дараах сэдэвчилсэн хавсралтын хүрээнд төслүүд хэрэгжүүлсэн.



2023 онд санхүүжүүлсэн төсөл хөтөлбөр-  
Хамтын ажиллагааны гэрээний сэдэвчилсэн хавсралт тус бүрээр - (₮)





**“Говийн Оюу хөгжлийн дэмжих сан”-аас 2015-2023 онд  
санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрийг Хамтын ажиллагааны гэрээний  
Сэдэвчилсэн хавсралтын дагуу ангилбал:**



№	Сэдэвчилсэн хавсралт	Төслийн тоо	Хөрөнгө оруулалт (₮)
1	Нийгмийн дэд бүтэц, хөрөнгө оруулалт	66	75,802,271,004
2	Байгаль орчны менежмент	19	1,376,654,160
3	Нийгмийн суурь үйлчилгээ	239	20,209,680,501
4	Орон нутгийн бизнес хөгжил	18	3,417,033,405
5	Уламжлалт мал аж ахуй, бэлчээрийн менежмент	19	2,008,818,739
6	Усны менежмент	18	3,417,747,485
7	Үндэсний түүх соёл	46	1,960,124,299
	<b>Нийт</b>	<b>425</b>	<b>108,192,329,593</b>



## УДИРДАХ ЗӨВЛӨЛӨӨС САНГИЙН 2023 ОНЫ САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭРИЙГ ХУВААРИЛСАН ХУВААРИЛАЛТ

№	ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН НЭР	САНХҮҮЖИЛТ (₮)	САНХҮҮЖИЛТ (\$)
<b>УДИРДАХ ЗӨВЛӨЛӨӨС БАТАЛСАН ТОМООХОН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР</b>			
<b>Нийгмийн дэд бүтэц</b>			
<b>Үнийн өсөлтөөс шалтгаалсан нэмэлт санхүүжилт олгосон төсөл</b>			
1	Даланзадгад сумын 200 хүүхдийн цэцэрлэгийн барилгын материалын үнийн өсөлттэй холбоотой нэмэлт санхүүжилт	595,607,955	171,040.14
2	Даланзадгад сумын 1200 хүүхдийн сургуулийн барилгын материалын үнийн өсөлттэй холбоотой нэмэлт санхүүжилт	7,949,243,663	2,282,776.37
3	Цогт-Овоо сумын 15 ортой эрүүл мэндийн төвийн барилгын материалын үнийн өсөлттэй холбоотой нэмэлт санхүүжилт	911,650,355	261,797.72
<b>Шинээр батлагдсан төсөл</b>			
1	Ханбогд сумын төвийн гадна цэвэр, бохирын шугамын угсралт-2023	4,360,442,356	1,252,183.88
2	Хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрийн барилга	1,350,065,000	387,696.82
<b>Дэд дүн (А)</b>		<b>15,167,009,329</b>	<b>4,355,494.93</b>

<b>Тогтвортой хөгжлийн хөтөлбөр</b>			
1	Үр дүнд суурилсан боловсрол	1,000,000,000	287,169
2	“Нэн ховордсон амьтан ургамлыг хамгаалах, шилжин нутагшуулах, үржүүлэх, хамгаалах, амьдрах орчныг сайжруулах” төсөл	110,000,000	31,588.59
<b>Дэд дүн (Б)</b>		<b>1,110,000,000</b>	<b>318,757.59</b>
<b>ТОМООХОН ТӨСЛҮҮДИЙН САНХҮҮЖИЛТИЙН ДҮН (В)</b>		<b>16,277,009,329</b>	<b>4,674,252.52</b>



### Санхүүжилтийн квотоор хэрэгжсэн төслүүд

#### ХАНБОГД СУМ

	2023 онд хуваарилсан санхүүжилтийн квот (Г)	294,222,400	85,000
1	Цахим танхим	39,640,000.00	11,383.38
2	Ахмадын хөгжил сайн орчин	19,183,500.00	5,508.91
3	Стандарттай Ханбогд	20,000,000.0	5,743.38
4	Эд мөрийн баримт хадгалах агуулах	8,827,500.0	5,406.67
5	Хүүхдийн сурч хөгжих таатай орчин	19,700,000.0	5,657.23
6	Тохилог таатай орчинд сурч хөгжье	19,000,000.0	5,456.21
7	Оюунлаг сурагч	17,550,000.0	5,039.82
8	Галба циркийн дугуйлангийн сургалтын тоног төхөөрөмж	20,055,000.0	5,759.17
9	Усаа хайрляя	19,200,000.0	5,513.64
10	Тав тухтай ариун цэврийн өрөө	40,000,000.0	11,486.76
11	Хог ангилан ялгах сав	70,000,000.0	20,101.83
12	Дулаан байр тухтай орчин	19,945,000.0	5,727.59
13	Хүүхдэд ээлтэй хотхон	20,000,000.0	5,743.38
14	Алслагдсан багийн боловсролын үйлчилгээг дээшлүүлэх	40,000,000.0	11,486.76
	Эрсдэлийн сангийн зарцуулалт	0	0

#### БАЯН-ОВОО СУМ

	2023 онд хуваарилсан санхүүжилтийн квот (Д)	224,993,600	65,000
1	Иргэддээ ойрхон шуурхай төрийн алба	35,000,000.00	11,060.44
2	Чамбай	5,000,000.0	10,050.92
3	Англи хэлний кабинет тохижуулах	21,000,000.0	6,030.55
4	Хүүхэд бүр жаргалтай байг	20,000,000.0	5,743.38
5	Соёлын төвийн тохижилт	50,000,000.0	14,358.45
6	Идэр аварга бөхийн клуб байгуулах	25,000,000.0	7,179.23
7	Ариун багаж аюулгүй үйлчилгээ	19,650,000.0	5,642.87
8	Нутгийн цомог	19,000,000.0	5,456.21
9	Сонинд мөнхөрсөн Баян-Овоогийн 100 жил	20,000,000.0	5,743.38
	Эрсдэлийн сангийн зарцуулалт	0	0





МАНЛАЙ СУМ			
	<b>2023 онд хуваарилсан санхүүжилтийн квот (Е)</b>	<b>224,993,600</b>	<b>65,000</b>
1	Наадмын талбайн модны усжуулалт	30,000,000.0	8,615.07
2	Манлай сум 100 жилд	60,000,000.0	17,230.14
3	Сургуулийн хүүхдийн автобус	65,000,000.0	18,665.99
4	ЭМТ-д автомашин нийлүүлэх	26,317,000.0	7,557.43
5	Чацарганын төгөл	5,370,800.0	1,542.33
6	Шатар даамны кабинет тохижуулах	10,000,000.0	2,871.69
7	Гэр бүлийн харилцааны үнэ цэнэ	7,262,000.0	2,085.42
8	Аюулгүй цэвэр орчинд ая тухтай суралцацгаая	9,794,000.0	2,812.53
	Эрсдэлийн сангийн зарцуулалт	0	0
ДАЛАНЗАДГАД СУМ			
	<b>2023 онд хуваарилсан санхүүжилтийн квот (Ё)</b>	<b>224,993,600</b>	<b>65,000</b>
	Эрсдэлийн сангийн зарцуулалт	0	0
БАЯНДАЛАЙ СУМ			
	<b>2023 онд хуваарилсан санхүүжилтийн квот (Ж)</b>	<b>155,764,800</b>	<b>45,000</b>
1	Уламжлалт гэр тэрэг	10,000,000.0	2,871.69
2	Иргэний танхим алдрын булан	10,000,000.0	2,871.69
3	Гадаа талбайн засвар ба тоглоом	23,000,000.0	6,604.89
4	Соёлын төвийн хувцас хийх	35,956,200.0	10,325.51
5	100 жил	38,000,000.0	10,912.42
	Эрсдэлийн сангийн зарцуулалт	0	0
СЭВРЭЙ СУМ			
	<b>2023 онд хуваарилсан санхүүжилтийн квот (З)</b>	<b>155,764,800</b>	<b>45,000</b>
1	Эрэгтэйчүүдийн бие засах газар	15,000,000.00	4,307.54
2	Эмэгтэйчүүдийн бие засах газар	15,000,000.00	4,307.54
3	Цаг уурын талбайн тохижилт	4,000,000.00	1,148.68
4	Сэврэй сумын музейн тохижилт	19,800,000.00	5,685.95
5	Ёслол хүндэтгэлийн өргөөний гадна тохижилт	20,000,000.00	5,743.38



Итгэцээг суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ

6	Цоохор ирвэс хамгаалах, сурталчлах	41,000,000.00	11,773.93
7	Нийтийн бие засах газар	40,000,000.00	11,486.76
	Эрсдэлийн сангийн зарцуулалт	0	0
<b>МАНДАЛ-ОВОО СУМ</b>			
	<b>2023 онд хуваарилсан санхүүжилтийн квот (И)</b>	<b>155,764,800</b>	<b>45,000</b>
1	Монгол соёл бидний бахархал	89,000,000.0	25,558.04
2	Иргэдийн эрүүл аюулгүй амьдрал	57,400,000.0	16,483.50
3	Үндэсний өв соёл	9,000,000.0	2,584.52
4	Монгол наадгай	15,000,000.0	4,307.54
	Эрсдэлийн сангийн зарцуулалт	0	0
<b>ЦОГТ-ОВОО СУМ</b>			
	<b>2023 онд хуваарилсан санхүүжилтийн квот (Й)</b>	<b>155,764,800</b>	<b>45,000</b>
	Эрсдэлийн сангийн зарцуулалт	0	0
<b>НОМГОН СУМ</b>			
	<b>2023 онд хуваарилсан санхүүжилтийн квот (К)</b>	<b>155,764,800</b>	<b>45,000</b>
1	Номгон сум Хүндэтгэлийн өргөө	48,857,000.0	14,030.22
2	Эрүүл орчинд хүүхэд бүр жаргалтай байг	6,900,000.0	1,981.47
3	Урлагийн уран шаглаа	92,143,000.0	26,460.61
	Эрсдэлийн сангийн зарцуулалт	0	0
<b>БУЛГАН СУМ</b>			
	<b>2023 онд хуваарилсан санхүүжилтийн квот (Л)</b>	<b>155,764,800</b>	<b>45,000</b>
1	Булган сумын сургуулийн Түүхээ мөнхөлье номын эх бэлтгэл, хэвлэл	30,000,000.0	8,615.07
2	Булган сумын 5-р цэцэрлэгийн гал тогооны төхөөрөмж	20,000,000.0	5,743.38
3	Булган сумын төвийн төвийн номын сангийн тохижилт	19,900,000.0	5,714.66
	Эрсдэлийн сангийн зарцуулалт	0	0



ХҮРМЭН СУМ			
	<b>2023 онд хуваарилсан санхүүжилтийн квот (М)</b>	<b>155,764,800</b>	<b>45,000</b>
1	Лед дэлгэц самбар	21,000,000.0	6,030.55
2	Дотуур байрны орчныг сайжруулах	25,000,000.0	7,179.23
3	Гэрэлт Хүрмэн	48,200,000.0	13,841.55
4	Найрсаг Хүрмэн	59,999,500.0	17,230.00
5	Хүрмэн сум Хүндэтгэлийн өргөө	16,962,000.0	4,870.96
	Эрсдэлийн сангийн зарцуулалт	0	0
ЦОГТЦЭЦИЙ СУМ			
	<b>2023 онд хуваарилсан санхүүжилтийн квот (Н)</b>	<b>155,764,800</b>	<b>45,000</b>
1	Аз жаргалын өргөө байрны тохижилт	130,000,000.0	37,331.97
2	Жонон хөгжмийн сургалт зохион байгуулах	100,630,000.0	28,897.82
	Эрсдэлийн сангийн зарцуулалт	0	0
ХАНХОНГОР СУМ			
	<b>2023 онд хуваарилсан санхүүжилтийн квот (О)</b>	<b>155,764,800</b>	<b>45,000</b>
1	Цитоговь эмийн санг тохижуулах	145,893,393.0	41,896.06
2	Эмийн сангийн цэвэр, бохирын шугамын холболт	9,861,496.0	2,831.92
	Эрсдэлийн сангийн зарцуулалт	0	0
НОЁН СУМ			
	<b>2023 онд хуваарилсан санхүүжилтийн квот (Ө)</b>	<b>155,764,800</b>	<b>45,000</b>
1	Ноён сумын иргэний танхим тохижуулах	30,000,000.0	8,615.07
2	Дэлхийн хүүхдийн гараа	50,000,000.0	14,358.45
3	Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх	70,000,000.0	20,101.83
	Эрсдэлийн сангийн зарцуулалт	0	0
ГУРВАНТЭС СУМ			
	<b>2023 онд хуваарилсан санхүүжилтийн квот (П)</b>	<b>155,764,800</b>	<b>45,000</b>
1	Зорилтот бүлгийн өвлийн хүлэмж	9,980,000.0	5,737.64
2	Чөлөөт бөхийн бэлтгэлийн тоног төхөөрөмж	14,620,000.0	4,198.41
	Эрсдэлийн сангийн зарцуулалт	0	0



*Итгэцээг суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

2023 ОНД ӨМНӨГОВЬ АЙМГИЙН 15 СУМАНД ХУВААРИЛСАН НИЙТ САНХҮҮЖИЛТИЙН КВОТЫН ДҮН (P)		2,682,616,000	775,000
<b>БУСАД</b>			
1	Ирээдүй хойч үеийн төлөө сан	1,289,160,025.8	370,206.81
2	Хандив тусламж	214,860,004.3	61,701.13
3	ХДС-ийн үйл ажиллагаа	779,917,382.0	223,968.10
	Дэд дүн (C)	2,283,937,412.1	655,876.04
	Тендерийн хэмнэлт (T)	371,708,597.9	106,743.18
	Нийт дүн (Y) (B+P+C+T)	21,615,271,339.0	6,207,240.00



## “ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-ИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛӨӨС 2023 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХЭЭР БАТАЛСАН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД:

### 1. “ХАНБОГД СУМЫН ГЭР ХОРООЛЛЫН ЦЭВЭР, БОХИР УСНЫ ШУГАМ БАРИХ-2023” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

БАРИЛГЫН ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

“САН” ХХК

4,360,442,356 төгрөг



#### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Ханбогд сум нь суурин болон хөдөлгөөнт хүн амын төвлөрөл ихтэй томоохон сум бөгөөд 2023 оны статистикийн судалгаагаар тус суманд албан ёсны бүртгэлтэй 7986 хүн ам, 2193 өрх тоологдсон. Энэхүү томоохон суурин болон хөгжиж байгаа сумын хувьд иргэдийн эрүүл, аюулгүй орчинд тав тухтай амьдарч, ажиллах орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд нэн тэргүүнд сумын төвийн инженерийн шугам сүлжээг өргөтгөж гэр хорооллын айл өрхийг төвлөрсөн шугам сүлжээнд холбох нь чухал дэмжлэг болох юм.
- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн санхүүжилтээр 2022 онд тус сумын Гоёот, Хөөвөр, Бага булаг хорооллын 30 аж ахуйн нэгж байгууллага, 325 айл өрх, 30 гудамж цэвэр бохир усны төвлөрсөн шугамд холбох 18,5 км шугамын ажил хийгдэж ашиглалтад шилжүүлсэн. Дээрх төслийн хүрээнд 50 гаруй айл өрх, албан байгууллагыг цэвэр, бохир усны төвлөрсөн шугамд холбогдсон бөгөөд томоохон суурин болон хөгжиж буй тус сумын хувьд салбар шугамын өргөтгөлийг үргэлжлүүлэх, илүү олон хэрэглэгчийг төвлөрсөн шугамд холбох хэрэгцээ, шаардлага өндөр байна.



### **ТӨСЛИЙН ЗОРИЛГО:**

- Ханбогд сумын төвийн айл өрх, албан байгууллагыг цэвэр, бохир усны төвлөрсөн шугам сүлжээнд холбож тэдгээр суурьшлын бүсийн ард иргэдийг эрүүл, ая тухтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх.

### **ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:**

- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2023 оны № 03 тогтоолоор “Ханбогд цэвэр бохирын шугам - 2023” төслийг 5,300,579,475 төгрөгөөр санхүүжүүлэхээр батлав.
- Захиалагч аймгийн ЗДТГ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсны дагуу захиалагч Өмнөговь аймгийн ЗДТГ, гүйцэтгэгч “Сан” ХХК, санхүүжүүлэгч “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” санхүүжилтийн гуравласан гэрээг байгуулснаар барилга угсралтын ажлыг эхлүүлэв.

### **ҮР ДҮН:**

- Шар дов, Баян хөөвөр хорооллын 31 аж ахуйн нэгж байгууллага, 516 айл өрх, 23 гудамжийг цэвэр, бохир усны төвлөрсөн шугам сүлжээнд холбогдох боломжтой болно.
- Иргэдийн ундны усны чанар сайжирна.
- Иргэдийн ая тухтай, эрүүл, аюулгүй орчинд амьдарч, ажиллах нөхцөл сайжирна.
- Хөрсний бохирдлыг бууруулна.
- Айл өрх, албан байгууллагын санхүүгийн чадавхад эерэг нөлөөлнө.
- Шугам сүлжээний үйл ажиллагааг хариуцагч байгууллагын борлуулалтын орлого нэмэгдэнэ.

**2023 онд барилга угсралтын ажил 60 хувьд хүрсэн.**





## 2. “ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН БАРИЛГА” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

БАТЛАГДСАН ТӨСӨВ:

ХЭРЭГЖИЛТ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

1,350,065,000 төгрөг

ГҮЙЦЭТГЭГЧ СОНГОН ШАЛГАРУУЛЖ БАЙНА



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Хүн амын тоо нэмэгдэхийн хэрээр өсөн нэмэгдэж буй хог хаягдлын нэг нь хуванцар хог хаягдал юм. Өмнөговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас аймгийн хэмжээнд 2022 оны байдлаар жилдээ ойролцоогоор 220,8 тонн энгийн хог хаягдал гарсан үүний 20-30 хувь нь дахин боловсруулах боломжтой хог хаягдал байгаагаас одоогоор нийт хог хаягдлын 8 орчим хувийг дахин боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлж байна гэсэн судалгаа гаргасан байна. Өмнөговь аймгийн ЗДТГ, Өмнөговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газартай хамтран Хог хаягдлын тухай хууль, Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны “Нутгийн хишиг” хөтөлбөрийн дагуу хог ангилан ялгах, дахин боловсруулах үйлдвэрийг байгуулахаар төслийг санаачилсан бөгөөд дараах холбогдох ажлуудыг зохион байгуулсан байна. Үүнд:
  - Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хуванцар дахин боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийг “Хангайн Эрхэс” ХХК, “Хазаарбат” ХХК нар аймгийн ЗДТГ-т нийлүүлсэн.
  - Орчин үеийн технологийн шийдлийг ашигласан хог хаягдал боловсруулах үйлдвэрийн барилгын зураг төсвийг боловсруулах ажлыг “Хязгааргүй шулуун” ХХК гүйцэтгэн аймгийн ЗДТГ-т хүлээлгэн өгсөн.
  - Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолын дагуу “Цэмцгэр Өмнөговь” ОНӨААТҮГ-г байгуулаад байна. Тус газар нь хог дахин боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааг хариуцан ажиллана.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулж, ангилах, цуглуулах, дахин ашиглах, дахин боловсруулах.



*Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

### **ТӨСЛӨӨР БИЙ БОЛОХ ҮР ӨГӨӨЖ:**

- Байгаль орчны бохирдлыг бууруулна.
- Өмнөговь аймгийн бүх сумдаас дахин боловсруулах боломжтой 6 төрлийн хог хаягдлыг цуглуулж байгаль орчинд шууд хаягдах хог хаягдлыг бууруулна.
- Шинээр байгуулагдсан “Цэмцгэр Өмнөговь” ОНӨААТҮГ ажлын байртай болно.
- Шинээр байнгын 5 ажлын бий болж иргэдийн өрхийн орлого нэмэгдэнэ.

Уг төсөл нь “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2023 оны 3 тоот тогтоолоор батлагдсан бөгөөд одоогийн байдлаар Өмнөговь аймгийн Засаг даргын тамгын газраас тендер зохион байгуулж гүйцэтгэгч сонгон шалгаруулж байна.





### 3. ҮР ДҮНД СУУРИЛСАН БОЛОВСРОЛ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

БАТАЛСАН ДҮН:

ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ**

**“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”**

**1,000,000,000 төгрөг**

1. МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
2. ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ
3. ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗАР
4. СИНГАПУР УЛСЫН СИНГ ЭД ГЛОБАЛ СКУУЛХАУС БОЛОВСРОЛД ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ /SING ED GLOBAL SCHOOLHOUSE/
5. СИНГАПУР УЛСЫН ИНВИКТУС ОЛОН УЛСЫН СУРГУУЛЬ /INVICTUS INTERNATIONAL SCHOOL/
6. ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИУД



МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР

БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



SING•ED



ГОВИЙН ОЮУ  
ХӨГЖЛИЙГ  
ДЭМЖИХ САН

#### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Боловсролын салбарын өнөөгийн олон улсын чиг хандлага багш, сурагчийн боловсролын асуудлыг цогцоор нь авч үзэж, багшийг чадавхжуулан бэлтгэж сургах, ажлын байранд нь мэргэжлийн тасралтгүй хөгжлийг нь хангах гэсэн хоорондоо уялдаатай шаталсан хөгжлийн тогтолцоог бий болгохыг зорьж байна. Мөн “мэргэжлийн, тасралтгүй, хөгжил” хэмээх багш хөгжлийн загвар, ойлголт ч бий болсон байна. Иймд Өмнөговь аймаг боловсролын салбарын чанар, салбарын хөгжлийг олон улсын чиг хандлагад нийцүүлэх, Азийн орнуудын шилдэг туршлага, загваруудыг нэвтрүүлэх ажлын хүрээнд Сингапур улс болон Монгол улсын Боловсрол, шинжлэх ухааны яамтай хамтран 6 жилийн цогц хөтөлбөр хэрэгжүүлэх санаачилгатай гарган ажиллаж байна.



## **ТӨСЛИЙН ЗОРИЛГО:**

- Монголын хамгийн анхны боловсролын шинэчлэлийг бодитой цогцоор нь хэрэгжүүлж буй загвар аймаг болох.

## **ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:**

- Уг хөтөлбөр нь “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2023 оны 3 тоот тогтоолоор батлагдсан бөгөөд одоогийн байдлаар хөтөлбөр хэрэгжүүлэх бэлтгэл ажил хангаж байна.

“Үр дүнд суурилсан боловсрол” хэмээх энэхүү хөтөлбөр нь 6 жилийн хугацаанд хэрэгжих бөгөөд дараах үндсэн 3 хүрээнд хөтөлбөр хэрэгжинэ.

1. Өмнөговь аймагт олон улсын STEM (Шинжлэх ухаан, технологи, инженерчлэл, математик тооцоолол) сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, загвар сургалтын орчин бий болгох, олон улсын сүлжээнд нэгдсэн FABLAB (дижитал үйлдвэрлэлийн лаборатори) байгуулах
2. Өмнөговь аймгийн ЕБС-ийн багш нарт зориулсан 21-р зууны чадамжид суурилсан заах арга зүйг шинэчлэх хөтөлбөр
3. Өмнөговь аймгийн K-12 (цэцэрлэгийн ангиас 12 дугаар анги хүртэлх) ангийн багш нарт зориулсан Англи хэлний хөтөлбөр.

Уг хөтөлбөр нь “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2023 оны 3 тоот тогтоолоор батлагдсан бөгөөд одоогийн байдлаар Өмнөговь аймгийн Засаг даргын тамгын газраас тендер зохион байгуулж гүйцэтгэгч сонгон шалгаруулж байна.

## **ҮР ДҮН:**

- 1-р хүрээний ажил: Өмнөговь аймагт олон улсын STEM (Шинжлэх ухаан, технологи, инженерчлэл, математик тооцоолол) сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, загвар сургалтын орчин бий болгох, олон улсын сүлжээнд нэгдсэн FABLAB (дижитал үйлдвэрлэлийн лаборатори) байгуулах.

## **1-р хүрээний ажлаас гарах үр дүн:**

- Хөтөлбөрөөр 22 мастер сургагч багш бэлтгэх: Мастер сургагч багш нар нь тодорхойлсон 4 сургуулийн тус бүр 5 багш, санал болгож буй төв лабораторийн 2 ажилтнаас бүрддэг. Мастер сургагч багш нар нь Олон улсын багшийн сурган хүмүүжүүлэгч академи /IFEA/ түүнтэй тэнцэхүйц гэрчилгээ олгох сургалтад хамрагдана.
- Сертификат олгох сургалт, түүнтэй дүйцэхүйц 4-6 модультай цахим багшийн дэмжих сургалт, “хийнгээ суралцах” заах арга зүйд суралцахад чиглэгддэг. Fablab for K-12 хөтөлбөрийн нэг хэсэг болох мастер сургагч багш нар сурагчидтай харилцан хамтрах замаар сургалтын үйл ажиллагааг явуулах, мөн аймгийн бусад сургуулийн багш нарт сургалтын үр нөлөө ач холбогдлыг сурталчлах зорилгоор сургах, баталгаажуулах болно.
- Мастер сургагч багш нарын 2 нь Фабын Мастер сургагч багшийн гэрчилгээ авна. 22 Мастер сургагч багш нар хамтран аймгийнхаа үлдсэн 22 сургуулийн 90 гаруй багштай дүйцэхүйц IFEA курст хамрагдах үүрэгтэй. Энэ нь арга зүй боловсруулах замаар STEM-ийн практик сургалтын нэг хэсэг болгон Фабын үйл ажиллагааг хангах сурган заах эрхийн гэрчилгээтэй 110 чадварлаг багшийн экосистемийг бий болгоно.
- Төсөлд мөн FabLabs.io платформыг Төвийн FabLab-ийн 2 ажилтан хариуцах ёстой. FabLabs.io нь FabLab-ын гишүүдийг 2000 гаруй FabLab-ын дэлхийн сүлжээгээр холбосон иж бүрэн онлайн платформ бөгөөд тэд FabLab-ийн янз бүрийн санаачилгад суралцах, оролцох, шинийг санаачлах зорилгоор нэгдэж, туршлага, мэдлэгээ хуваалцах боломжтой



болоод зогсохгүй Фаб хөдөлгөөний эцэг профессор Нейл Гершенфельдийн удирдсан Дижитал үйлдвэрлэлийн дипломын сургалтад хамрагдах хүртэл боломжтой болно.

- Төвийн FabLab-аар дамжуулан оюутан, багш нарын жил бүр зохион байгуулдаг Fab challenges, Fab City Challenges зэрэг старт-ап хөтөлбөрүүдэд оролцохыг боломж нээгдэнэ. Улмаар салбар бүрийн хамтын ажиллагаанд оролцож бодит ертөнцөд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх чиглэлээр ажиллах бөгөөд STEM мэдлэг, ур чадварыг эзэмшсэнээр ирээдүйн шилдэг дэлхийд өрсөлдөх чадвартай иргэнийг бэлдэж буй явдал юм.

### **2-р хүрээний ажил: Өмнөговь аймгийн ЕБС-ийн багш нарт зориулсан 21-р зууны чадамжид суурилсан заах арга зүйг шинэчлэх хөтөлбөр**

7 цуврал сургалтууд зохион байгуулж багш нарт ур чадвар эзэмшүүлнэ.

Хамрах хүрээ: Өмнөговь аймгийн ЕБС-ийн багш нараас 200 багшийг сонгож сургагч мастер багш бэлтгэж улмаар аймаг, улсын хэмжээнд түгээн дэлгэрүүлэх, сургах ажлыг зохион байгуулна.

### **3-р хүрээний ажил: Өмнөговь аймгийн К-12 (цэцэрлэгийн ангиас 12 дугаар анги хүртэлх) ангийн багш нарт зориулсан Англи хэлний хөтөлбөр**

Энэхүү хүрээнд ажил нь 2 хэсгээс бүрдэх ба 1-р хэсэгт Англи хэлний мастер сургагч багш нарын чадавхийг хөгжүүлэх ажил хийнэ. Сургалтад хамрагдсан нийт аймгийн хэмжээнд ажиллаж буй 2000 багш нарын англи хэлний мэдлэгийг тогтоож англи хэлний мастер багш бэлтгэж К-12 багшийн англи хэлний чадварыг хөгжүүлж Инвиктус глобал скулххаус/Invictus Global School-house-ийн ухаалаг сургуулийн хөтөлбөр болон түүний холимог сургалтын арга барилыг нэвтрүүлэх зорилготой мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулна.

2-р хэсэгт К-12 багш нар сургалтынхаа 60 орчим хувийг цахимаар бие даан суралцах, 40 орчим хувийг англи хэлний мастер сургагч багшийн цахим хичээл, нүүр тулсан танхимын сургалтаар зарцуулна. Нийт 200 цагийн англи хэлний үр дүнд суурилсан сургалт хийнэ.



Итгэцлэг суурьлсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ


#### 4. НЭН ХОВОРДСОН АМЬТАН УРГАМЛЫГ ХАМГААЛАХ, ШИЛЖҮҮЛЭН НУТАГШУУЛАХ, ҮРЖҮҮЛЭХ, ХАМГААЛАХ, АМЬДРАХ ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ ТӨСЛИЙН ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ БОЛОВСРУУЛАХ

ЗАХИАЛАГЧ:  
САНХҮҮЖҮҮЛЭГЧ:  
ХАМТРАГЧ БАЙГУУЛЛАГА:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ  
“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”  
ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН,  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

БАТАЛСАН ДҮН:  
ГҮЙЦЭТГЭГЧ:

110,000,000 төгрөг  
ГҮЙЦЭТГЭГЧ СОНГОН ШАЛГАРУУЛЖ БАЙНА



ГОВИЙН ОЮУ  
ХӨГЖЛИЙГ  
ДЭМЖИХ САН

#### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Өмнөговь аймгийн хувьд тус нутаг дэвсгэр дээрх нэн ховор, ховор амьтан ургамлыг судлах, хамгаалах үйл ажиллагааг зохих түвшинд явуулдаг ч, цогц судалгаа, шинжилгээ, хамгаалалтын төв байхгүй байгаа тул бий болгох шаардлагатай байна.

#### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- “Говийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв” байгуулах, үүгээр дамжуулан судалгаа шинжилгээний ажил хийх, бэртэж гэмтсэн амьтдыг асран хамгаалах, байгаль хамгаалах экологийн боловсролыг түгээх, судлаачид, зочид жуулчдыг татах говь цөлийн бүсийг төлөөлөх аялал жуулчлал, судалгаа шинжилгээний түшиц газартай болох зорилготой.

#### ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

- Уг төсөл нь “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2023 оны 3 тоот тогтоолоор батлагдсан бөгөөд одоогийн байдлаар Өмнөговь аймгийн ЗДТГ-аас тендер зохион байгуулж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж байна.



#### **ҮР ДҮН:**

1. Говь цөлийн нэн ховор, ховор амьтдыг судлах, хамгаалах төв байгуулагдана
2. Нэн ховор, ховор амьтдын талаарх судалгааны ажил сайжирч олон улсад эргэлтэд орсноор илүү их судалгааны төсөл хөтөлбөр хэрэгжих суурь болно
3. Нэн ховор, ховор зүйл амьтны тоо толгойг өсгөж, тогтвортой тоо толгой бий болгоно.
4. Нэн ховор, ховор амьтдыг хамгаалах Монгол улсдаа жишиг газар байгуулагдана.
5. Өмнөговь аймгийн нэг томоохон байгалийн аялал жуулчлалын үзмэр болж гадаад дотоодын жуулчдын тоог нэмэгдүүлнэ.
6. Тус төвийг дагаж аялал жуулчлалын баазууд хөгжих, орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлнэ.
7. Иргэд, оюутан, сурагчдын экологийн боловсрол олгох нэг томоохон түшиц газар болно.
8. Орон нутагт ажлын байр нэмэгдэнэ.
9. Дээрх бүхний үр дүнд говь, цөл, түүний биологийн олон янз байдлыг хайрлан хамгаалах ажил өргөжин тэлнэ.



Итгэлийг суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ

## “ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-ИЙН САНХҮҮЖИЛТЭЭР ОН ДАМЖИН ХЭРЭГЖИЖ БҮЙ ТОМООХОН ТӨСЛҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Төслийн нэр	Батлагдсан он	ХДС санхүүжилт-₮	Төлөв	Төслийн явц, мэдээлэл
1	Цогт-Овоо сумын 15 ортой эрүүл мэндийн төвийн барилга	2021.04.16	3,926,366,916	Баталгаат хугацаанд байна	2023 оны 11 сарын 16-нд барилга ашиглалтад оруулах комиссын дүгнэлт гарсан.
2	Даланзадгадын 1200 хүүхдийн сургууль	2020.07.24	18,160,630,688	Хэрэгжиж байна	2023 оны эцсийн байдлаар ажлын гүйцэтгэл 90%-д хүрсэн.
3	Даланзадгад сумын 200 хүүхдийн цэцэрлэгийн барилга	2021.04.16	3,476,190,686	Хэрэгжиж байна	2023 оны эцсийн байдлаар ажлын гүйцэтгэл 90%-д хүрсэн.
4	Даланзадгад сумын үйлдвэрлэлийн бүсийг бохир усны шугамд холбох	2022.04.11	973,708,238	Хэрэгжиж байна	2023 оны эцсийн байдлаар улсын комисс ажилласан. Комиссын үүрэг даалгавар биелүүлэх үе шатанд байна. Гүйцэтгэл-90%
5	Даланзадгад сумын ДЦС-д усаар үнс зайлуулах систем болон үнсэн сан байгуулах	2022.11.16	1,500,000,000	Баталгаат хугацаанд	2023 оны 12 сарын 19-нд барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлт гарсан.
6	Дэлхийн иргэд Ханбогдоос	2022.07.28	239,982,402	Баталгаат хугацаанд	Комисс ажиллаж хүлээн авсан- 2023.03.30
7	Эко жорлон	2022.11.16	579,305,200	Хэрэгжиж байна	2 бохирын машин нийлүүлсэн. Эко жорлон барих ажил хийгдэж байна.
9	Галын машин	2022.11.16	497,000,000	Баталгаат хугацаанд байна	Комисс ажиллаж хүлээн авсан- 2023.03.30
10	Цахим багш	2022.11.16	869,636,900	Хэрэгжиж дууссан	Комисс ажиллаж хүлээн авсан- 2023.05.18
11	Өмнөговь аймгийн түүх соёлын дурсгалт зүйлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан үүсгэх	2022.11.04	84,570,000	Хэрэгжиж байна	2023 оны эцсийн байдлаар төсөл хэрэгжиж байна. Ажлын гүйцэтгэл 80%-д хүрсэн.
12	Даланзадгад сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах	2021.04.16	250,000,000	Хэрэгжиж байна	Даланзадгад сумын бүх багийн хурлуудад танилцуулж хэлэлцүүлэг зохион байгуулсан. Ажлын гүйцэтгэл 90%-д хүрсэн.
11	Бэлчээр усжуулалт-2 аян-2022	2022.04.11	1,777,875,215	Хэрэгжиж байна	Ажлын гүйцэтгэл 60%-д хүрсэн.
12	Цээжний хөндийн хагалгааны багаж	2022.11.16	39,984,000	Хэрэгжиж байна	Тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээ байгуулсан.
13	“Бүсийн оношилгоо эмчилгээний төвд шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэх”	2022.04.11	458,900,000	Баталгаат хугацаанд байна	Комисс ажиллаж хүлээн авсан- 2023.07.03



## 1. “ЦОГТ-ОВОО СУМЫН 15 ОРТОЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН БАРИЛГА” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

“ЭВТ ЦАХИРАЛ” ХХК

3,926,366,916 төгрөг



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Цогт-Овоо суманд 2020 оны жилийн эцсийн байдлаар албан ёсны бүртгэлтэй 1896 хүн ам тоологдсон бөгөөд засаг захиргааны анхан шатны нэгж болсон 4 багтай сум юм. Мөн тус сум нь Өмнөговь аймгийн төвөөс Улаанбаатар хот орох улсын чанартай төв засмал замын дагуу байршилтайгаас шалтгаалан орон нутгийн иргэд, уул уурхайн ажилчид, гадаад дотоодын аялагч гэх мэт зорчин өнгөрөх иргэдийн тоо харьцангуй ихтэй байдаг тул ердийн сумын эмнэлгээс илүү ачаалалтай ажилладгаас гадна гэнэтийн осол аваарын үед үзүүлэх анхан шатны яаралтай тусламж үйлчилгээний хүртээмж маш муу байдаг. Тус сумын эрүүл мэндийн төв нь 16 ажилтан, 9 ортойгоор эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлдэг. Эрүүл мэндийн төвийн барилга нь 2007 онд ашиглалтад орсон 9 ортой тул өрөө тасалгаа, орны тоо хүрэлцдэггүй, эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээний стандарт хангагдаагүй, эмнэлгийн дотоод халдвар дамжих эрсдэл өндөр, яаралтай тусламж үйлчилгээний үед хүлээлт, дараалал ихтэй зэрэг олон хүндрэлтэй асуудал тулгардаг байсан.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Стандартын шаардлага хангасан эмнэлгийн барилга барьж иргэдэд чанар, хүртээмжтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх болон эмч, эмнэлгийн ажилтнуудын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах.



## ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 05 дугаар тогтоолоор “Цогт-Овоо сумын 15 ортой эрүүл мэндийн төвийн барилга” төслийг 3,106,754,176 төгрөгөөр санхүүжүүлэхээр батлав.
- Захиалагч аймгийн ЗДТГ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсны дагуу захиалагч Өмнөговь аймгийн ЗДТГ, гүйцэтгэгч “Эвт цахирал” ХХК, санхүүжүүлэгч “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” санхүүжилтийн гуравласан гэрээг байгуулснаар барилга угсралтын ажлыг эхлүүлэв.
- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2023 оны 03 дугаар тогтоолоор “Цогт-Овоо сумын 15 ортой эрүүл мэндийн төвийн барилга барих” төслийн материалын үнийн өсөлтийн зөрүү, нэмэлт ажлыг санхүүжүүлэхээр 911,650,355 төгрөг батлав.

## ҮР ДҮН:

- Цогт-Овоо сум стандартын шаардлага хангасан эмнэлгийн барилгатай болсон.
- Эрүүл мэндийн үйлчилгээний төрөл, чанар, хүртээмж дээшилнэ.
- Эрүүл мэндийн үйлчилгээний орчин нөхцөл сайжирна.
- Эмч, эмнэлгийн ажилтнууд ая тухтай орчинд ажиллана.
- Эмч, ажилчдын ажлын бүтээмжид эерэг нөлөө үзүүлнэ.

## 2023 ОНЫ 11 САРЫН 16-НД БАРИЛГА АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ ГАРЧ ЦОГТ-ОВОО СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ БАРИЛГЫГ АШИГЛАЛТАД ШИЛЖҮҮЛЭВ







## 2. ДАЛАНЗАДГАД СУМЫН 1200 ХҮҮХДИЙН СУРГУУЛИЙН БАРИЛГА” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

БАРИЛГЫН ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

“ХҮННҮГИЙН ГОВЬ” ХХК

18,160,630,688 төгрөг



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Өмнөговь аймгийн төв Даланзадгад хот нь сүүлийн жилүүдэд хүн амын төвлөрөл эрс нэмэгдэж байгаатай уялдан сургууль цэцэрлэгийн хэрэгцээ өсөн нэмэгдэж байна. Даланзадгад сумын 6 сургуулийн 5 нь 2 ээлжээр хичээллэдэг, шинэ төлөвлөлтийн бүс дэх гэр хорооллуудад оршин сууж байгаа 3,193 өрхийн хүүхдүүд сургууль цэцэрлэгтээ 4-6 км холоос явдаг. Энэ нь нийтийн тээвэр хөгжөөгүй тус суманд хүүхдүүд их холоос сургууль, цэцэрлэгтээ явахад бэрхшээлтэй байдаг. Даланзадгад суманд 2,591 сурагчийн суудал дутагдаж байгаа зэрэг нөхцөл байдалд үндэслэн төслийг санаачилсан.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Даланзадгад сумын сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлж 1 ээлжээр хичээллэдэг сургуулийн тоог нэмэгдүүлэх, жил бүр хүрээгээ тэлж буй төвөөс алслагдсан гэр хорооллын хүүхдүүдийн сурах нөхцөлийг сайжруулах, сургууль цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх.

### ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

- “Даланзадгад сумын 1200 хүүхдийн сургуулийн барилга барих” төслийг “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор 4,626,167,267 төгрөг, 2021 оны 05 дугаар тогтоолоор 5,585,219,758 төгрөгөөр санхүүжүүлэхээр тус тус батлав.
- Захиалагч аймгийн ЗДТГ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсны дагуу захиалагч Өмнөговь аймгийн ЗДТГ, гүйцэтгэгч “Хүннүгийн говь” ХХК, санхүүжүүлэгч “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” санхүүжилтийн гуравласан гэрээг байгуулснаар барилга угсралтын ажлыг эхлүүлэв.



*Итгэцээг суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2023 оны 03 дугаар тогтоолоор “Даланзадгад сумын 1200 хүүхдийн сургуулийн барилга барих” төслийн үнийн өсөлтийн зөрүүг санхүүжүүлэхээр 7,949,243,663 төгрөг батлав.

**ҮР ДҮН:**

- Даланзадгад сумын сургуулийн хүртээмж нэмэгдэнэ.
- 1 ээлжээр хичээллэдэг сургуулийн тоог нэмэгдүүлнэ.
- Анги дүүргэлтийг багасгана.
- Алслагдсан гэр хорооллын сурагчид гэртээ ойрхон сургуульд явах нөхцөл бүрдэнэ.
- 100 орчим шинэ ажлын байр бий болно.

**БАРИЛГА УГСРАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ 90%-ТАЙ БАЙНА.**





### 3. “ДАЛАНЗАДГАД СУМЫН 200 ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН БАРИЛГА” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

“ХАНБОГД АРВИЖИХ” ХХК

3,476,190,686 төгрөг



#### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Даланзадгад сумын шинэ суурьшлын бүсийн хамран сургах тойргийн сургуулийн өмнөх насны хүүхдүүдийг цэцэрлэгт бүрэн хамруулж чадахгүй байгаа, зарим хүүхдүүдийн хамрагдаж буй цэцэрлэг гэрээс нь 4-6 км хол байрлалтай байдаг нь хүүхэд, гэр бүлд бэрхшээлтэй байдаг. Даланзадгад сумын Гурван сайхан, Нисэх, Баруун сайхан хорооллын хойд тал, Төгөл зэрэг алслагдсан гэр хороололд цэцэрлэгийн насны 300 хүүхэд бүртгэлтэй. Улсын стандартаар цэцэрлэгийн нэг ангид 25 хүүхэд хамрагдах ёстой байтал Даланзадгад сумын бүх цэцэрлэгийн дундаж анги дүүргэлт 40 хүүхэдтэй мөн 2020 оны байдлаар дээрх хорооллуудын 136 хүүхэд цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаа зэрэг нь сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагааг хүүхэд бүрд тэгш, хүртээмжтэй явуулах нөхцөл тааруу байгааг өөрчилж хүүхэд бүрийг цэцэрлэгт хамруулах боломжоор хангах шаардлагатай байсан.

#### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Даланзадгад сумын сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагааг хүүхэд бүрд тэгш, хүртээмжтэй явуулахад дэмжлэг болох.
- Даланзадгад сумын Гурван сайхан хороололд 200 хүүхдийн цэцэрлэгийн барилга барина.

#### ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

- “Даланзадгад сумын 200 хүүхдийн цэцэрлэгийн барилга барих” төслийг “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2020 оны 03 дугаар тогтоолоор 450,000,000 төгрөг, 2021 оны 05 дугаар тогтоолоор 1,765,485,316 төгрөг, 2022 оны 02 дугаар тогтоолоор 682,680,000 төгрөгөөр санхүүжүүлэхээр тус тус батлав.
- Захиалагч аймгийн ЗДТГ “Даланзадгад сумын 200 хүүхдийн цэцэрлэгийн барилга барих” ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулж гэрээ байгуулсны дагуу захиалагч Өмнөговь аймгийн ЗДТГ, гүйцэтгэгч “Ханбогд арвижих” ХХК, санхүүжүүлэгч “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”



*Итгэцлэлд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

санхүүжилтийн гуравласан гэрээг байгуулснаар барилга угсралтын ажлыг эхлүүлэв.

- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2023 оны 03 дугаар тогтоолоор “Даланзадгад сумын 200 хүүхдийн цэцэрлэгийн барилга барих” төслийн материалын үнийн зөрүүг санхүүжүүлэхээр 595,607,955 төгрөг батлав.

**ҮР ДҮН:**

- Даланзадгад сумын цэцэрлэгийн хүртээмж нэмэгдэнэ.
- Анги дүүргэлтийг багасгана.
- Хүүхдүүд гэртээ ойрхон цэцэрлэгт хамрагдана.
- Сургуулийн өмнөх боловсролын хоцрогдол багасна.
- 35 ажлын байр шинээр бий болно.
- Цэцэрлэгт хамрагдсан хүүхэд бүрийн тоогоор эцэг эхчүүд, асран хамгаалагч нар ажил эрхлэх боломжтой болж өрхийн орлогоо нэмэгдүүлнэ.

**“Барилгын ажил бүрэн дууссан бөгөөд дулаан болон цэвэр усны эх үүсвэрт холбогдсоны дараа барилга ашиглалтад шилжүүлэх комисс ажиллана.”**





#### 4. “НУТГИЙН ҮЙЛДВЭРЛЭГЧ-БОХИРЫН ШУГАМ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

“АЛТАЙН ҮНДЭС КОНСТРАКШН” ХХК

973,708,238 төгрөг



#### ТОВЧ МЭДЭЭЛЭЛ:

- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 02 дугаар тогтоолоор “Нутгийн үйлдвэрлэгч” хөтөлбөрийн хүрээнд үйлдвэр, технологийн паркийг дэд бүтцэд холбох төслийг 1,000,000,000 /нэг тэрбум/ төгрөгөөр санхүүжүүлэхээр батлав.
- Захиалагч аймгийн ЗДТГ “Нутгийн үйлдвэрлэгч” хөтөлбөрийн хүрээнд үйлдвэр, технологийн паркийг дэд бүтцэд холбох ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулж гэрээ байгуулсны дагуу захиалагч Өмнөговь аймгийн ЗДТГ, гүйцэтгэгч “Алтайн үндэс констракшн” ХХК, санхүүжүүлэгч “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” хооронд санхүүжилтийн гуравласан гэрээг байгуулснаар барилгын ажлыг эхлүүлэв.
- Төслийн хүрээнд Даланзадгад сумын үйлдвэрийн бүсээс аймгийн хуучин цэвэрлэх байгууламж уруу бохир усны гол шугам барих ажил хийгдсэн бөгөөд 2023 оны 10 сарын 13-нд барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлт гарсан.



*Итгэцээг суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

## 5. “ДАЛАНЗАДГАД СУМЫН ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦАД УСААР ҮНС ЗАЙЛУУЛАХ СИСТЕМ БОЛОН ҮНСЭН САН БАЙГУУЛАХ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

“ШҮТЭЭН-ЭРДЭНЭ” ХХК

1,500,000,000 төгрөг



### ТОВЧ МЭДЭЭЛЭЛ:

- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 12 дугаар тогтоолоор “Даланзадгад сумын Дулааны цахилгаан станцад усаар үнс зайлуулах систем болон үнсэн сан байгуулах” төслийг 1,500,000,000 төгрөгөөр санхүүжүүлэхээр батлав
- Захиалагч аймгийн ЗДТГ “Даланзадгад сумын Дулааны цахилгаан станцад усаар үнс зайлуулах систем болон үнсэн сан байгуулах” ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулж гэрээ байгуулсны дагуу захиалагч Өмнөговь аймгийн ЗДТГ, гүйцэтгэгч “Шүтээн-Эрдэнэ” ХХК, санхүүжүүлэгч “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” хооронд санхүүжилтийн гуравласан гэрээг байгуулснаар төслийн ажлыг эхлүүлэв.
- Төслийн хүрээнд гүйцэтгэсэн ажлыг 2023 оны 12 сарын 19-нд барилга ашиглалтад оруулах комиссын дүгнэлт гарсан.



## 6. “ДЭЛХИЙН ИРГЭД ХАНБОГДООС” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

“ТИКЕТ ЦЕНТР” ХХК

239,982,402 төгрөг



### ТОВЧ МЭДЭЭЛЭЛ:

- Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-ийн Удирдах зөвлөлийн 2022 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн 08 дугаар тогтоолоор “Дэлхийн иргэд Ханбогдоос” төслийг 245,000,000 төгрөгөөр санхүүжүүлэхээр батлав.
- Захиалагч Ханбогд сумын ЗДТГ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсны дагуу захиалагч Ханбогд сумын ЗДТГ, гүйцэтгэгч “Тикет центр” ХХК, санхүүжүүлэгч “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” санхүүжилтийн гуравласан гэрээг байгуулснаар төслийн ажлыг эхлүүлэв.
- Төслийн хүрээнд Ханбогд сумын Ерөнхий боловсролын 1, 2 дугаар сургуульд 56 нэр төрлийн 687 ширхэг тавилга, сургалтын хэрэгсэл нийлүүлж англи хэлний 6 кабинет, сэтгэл зүйчийн 2 кабинет тохижуулсан бөгөөд 2023.03.30-нд комисс ажиллаж төслийн ажлыг хүлээн авсан.



*Итгэцээг суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

## 7. “ЭКО ЖОРЛОН” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:  
САНХҮҮЖҮҮЛЭГЧ:  
ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ  
“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”  
“СОД МОНГОЛ ГЭГЭЭ” ХХК,  
“БИ ЮУ ЭМ ДИ” ХХК  
579,305,200 төгрөг**



### ТОВЧ МЭДЭЭЛЭЛ:

- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 12 дугаар тогтоолоор “Эко жорлон төслийг 599,994,300 төгрөгөөр санхүүжүүлэхээр батлав.
- Захиалагч аймгийн ЗДТГ “Эко жорлон” төслийн ажлыг 2 багц болгон тендер зарлан гүйцэтгэгч сонгон шалгаруулж гэрээ байгуулсны дагуу захиалагч Өмнөговь аймгийн ЗДТГ, гүйцэтгэгч “Сод Монгол гэгээ” ХХК, “Би Юу Эм Ди” ХХК-тай санхүүжүүлэгч “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” санхүүжилтийн гуравласан гэрээг тус тус байгуулснаар төслийн ажлыг эхлүүлэв.
- Багц-1 ажлын гүйцэтгэгчээр “Сод Монгол гэгээ” ХХК ажиллаж Өмнөговь аймгийн Засаг Даргын Тамгын Газарт 2 ширхэг бохир ус зайлуулах авто машин нийлүүлсэн.
- Багц-2 ажлын гүйцэтгэгч “Би Юу Эм Ди” ХХК Өмнөговь аймгийн 13 сумын нийтийн эзэмшлийн талбай, Шар цав, Говийн бага дархан цаазат газар, Говь гурван сайхны байгалийн цогцолборт газар зэрэг бүс нутагт эко жорлон барьж байна.





## 8. “ГАЛЫН МАШИН” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

“ГОВИЙН ТӨГӨЛДӨР ИРЭЭДҮЙ” ХХК

497,000,000 төгрөг



### ТОВЧ МЭДЭЭЛЭЛ:

- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 12 дугаар тогтоолоор “Галын машин” төслийг 500,000,000 төгрөгөөр санхүүжүүлэхээр батлав.
- Захиалагч аймгийн ЗДТГ “Галын машин” төслийн гүйцэтгэгч сонгон шалгаруулж гэрээ байгуулсны дагуу захиалагч Өмнөговь аймгийн ЗДТГ, гүйцэтгэгч “Говийн төгөлдөр ирээдүй” ХХК, санхүүжүүлэгч “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” хооронд санхүүжилтийн гуравласан гэрээг байгуулснаар төслийн ажлыг эхлүүлэв.
- Төслийн хүрээнд Говь гурван сайхан нисэх буудалд Sinotruck 4x2 HOWO гал унтраах автомашин нийлүүлсэн бөгөөд 2023.11.27-нд комисс ажиллаж уг автомашиныг хүлээн авсан.



## 9. “ЦАХИМ БАГШ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:  
САНХҮҮЖҮҮЛЭГЧ:  
ГҮЙЦЭТГЭГЧ:  
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ  
“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”  
“АЙ ТИ ЗОН” ХХК  
869,636,900 төгрөг



### ТОВЧ МЭДЭЭЛЭЛ:

- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 12 дугаар тогтоолоор “Цахим багш” төслийг 874,000,000 төгрөгөөр санхүүжүүлэхээр батлав.
- Захиалагч аймгийн ЗДТГ “Цахим багш” төслийн гүйцэтгэгч сонгон шалгаруулж гэрээ байгуулсны дагуу захиалагч Өмнөговь аймгийн ЗДТГ, гүйцэтгэгч “Ай Ти Зон” ХХК, санхүүжүүлэгч “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” хооронд санхүүжилтийн гуравласан гэрээг байгуулснаар төслийн ажлыг эхлүүлэв.
- Төслийн хүрээнд Өмнөговь аймгийн ерөнхий боловсролын сургуулийн багш нарыг зөөврийн компьютероор хангахад зориулж АЗДТГ-т 230ш зөөврийн компьютер нийлүүлсэн бөгөөд 2022.05.23-ны өдөр багш нарт гардуулсан.



## 10. “ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ТҮҮХ СОЁЛЫН ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙН БҮРТГЭЛ МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН ҮҮСГЭХ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:  
САНХҮҮЖҮҮЛЭГЧ:  
ГҮЙЦЭТГЭГЧ:  
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ  
“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”  
МУИС-ИЙН УЛААНБААТАР СУРГУУЛЬ  
84,570,000 төгрөг**



### ТОВЧ МЭДЭЭЛЭЛ:

- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 02 дугаар тогтоолоор “Өмнөговь аймгийн түүх соёлын дурсгалт зүйлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан үүсгэх” төслийг 85,070,000 төгрөгөөр санхүүжүүлэхээр батлав.
- Захиалагч аймгийн ЗДТГ “Өмнөговь аймгийн түүх соёлын дурсгалт зүйлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан үүсгэх” төслийн гүйцэтгэгч сонгон шалгаруулж гэрээ байгуулсны дагуу захиалагч Өмнөговь аймгийн ЗДТГ, гүйцэтгэгч МУИС-ийн Улаанбаатар сургууль, санхүүжүүлэгч “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” хооронд санхүүжилтийн гуравласан гэрээг байгуулснаар төслийн ажлыг эхлүүлэв.
- Төслийн хүрээнд Өмнөговь аймгийн 13 сумын нутаг дэвсгэрээр явж түүх-соёлын өв, дурсгалт газар, археологийн дурсгалуудыг бүртгэх, цуглуулсан мэдээлэлдээ тулгуурлан “Соёлын өвийн тухай хууль”-ийн дагуу мэдээллийн сан үүсгэж цахим, цаасан хэлбэрээр болон ном хэвлүүлэхэд бэлэн PDF файлаар боловсруулж, захиалагчид хүлээлгэн өгнө. Ажлын гүйцэтгэл 90%-д хүрсэн.



*Итгэмцэлд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

## 11. “ДАЛАНЗАДГАД СУМЫН ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

“ММ АРХИТЕКТУР” ХХК

250,000,000 төгрөг



### ТОВЧ МЭДЭЭЛЭЛ:

- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 05 дугаар тогтоолоор “Даланзадгад сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах” төслийг 250,000,000 төгрөгөөр санхүүжүүлэхээр батлав.
- Захиалагч аймгийн ЗДТГ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсны дагуу захиалагч Өмнөговь аймгийн ЗДТГ, гүйцэтгэгч “ММ Архитектур” ХХК, санхүүжүүлэгч “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” санхүүжилтийн гуравласан гэрээг байгуулснаар төслийг эхлүүлэв.
- Даланзадгад сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Даланзадгад сумын бүх багийн хурлуудаар иргэдэд танилцуулж хэлэлцүүлэг зохион байгуулсан. Ажлын гүйцэтгэл 90%-д хүрсэн.



## 12. “БЭЛЧЭЭР УСЖУУЛАЛТ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

БАТЛАГДСАН ТӨСӨВ:


ГҮЙЦЭТГЭГЧ, ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

1,800,000,000 төгрөг

1. “БЭЛЧЭЭР УСЖУУЛАЛТЫН ХОЁРДУГААР АЯН-2022, БАГЦ-1”:  
**“ХИШИГ ЮНИВЕРС” ХХК, 355,000,000 ТӨГРӨГ**
2. “БЭЛЧЭЭР УСЖУУЛАЛТЫН ХОЁРДУГААР АЯН-2022, БАГЦ-2”:  
**“ХИШИГ ЮНИВЕРС” ХХК, 356,000,000 ТӨГРӨГ**
3. “БЭЛЧЭЭР УСЖУУЛАЛТЫН ХОЁРДУГААР АЯН-2022, БАГЦ-3”:  
**“СОЙЛ ИНЖЕНЕРИНГ” ХХК, 358,875,215 ТӨГРӨГ**
4. “БЭЛЧЭЭР УСЖУУЛАЛТЫН ХОЁРДУГААР АЯН-2022, БАГЦ-4”:  
**“ЭХНИЙ ЭХЭН” ХХК, 354,000,000 ТӨГРӨГ**
5. “БЭЛЧЭЭР УСЖУУЛАЛТЫН ХОЁРДУГААР АЯН-2022, БАГЦ-5”:  
**“ЭХНИЙ ЭХЭН” ХХК, 354,000,000 ТӨГРӨГ**



### ТОВЧ МЭДЭЭЛЭЛ:

- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 02 дугаар тогтоолоор “Бэлчээр усжуулалтын хоёрдугаар аян-2022” төслийг 1,800,000,000 төгрөгөөр санхүүжүүлэхээр батлав.
- Захиалагч аймгийн ЗДТГ дээрх ажлыг 5 багц болгон тендер зарлаж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан гэрээ байгуулсны дагуу захиалагч Өмнөговь аймгийн ЗДТГ болон санхүүжүүлэгч “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” нь төслийн гүйцэтгэгчид болох “Хишиг юниверс” ХХК, “Сойл



## *Итгэцээг суурилсан сайхан ирээдүйг Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

инженеринг” ХХК, “Эхний эхэн” ХХК-тай санхүүжилтийн гуравласан гэрээг тус тус байгуулснаар төслийг эхлүүлэв.

- Төслийн хүрээнд Өмнөговь аймгийн 15 сумын усан хангамж дутагдалтай бэлчээрт 60 инженерийн хийцтэй худаг шинээр гаргаж 90.0 мянган га бэлчээрийг усжуулж, 180 орчим малчин өрхийн 90.0 мянган толгой малыг найдвартай усны эх үүсвэртэй болгоход дэмжлэг болох юм.
- 2023 оны байдлаар төслийн хүрээнд гаргах бүх худгийг гаргаж дууссан бөгөөд худгуудыг хүлээж авах комисс ажиллаж байна.



### 13. “ЦЭЭЖНИЙ ХӨНДИЙН ХАГАЛГААНЫ БАГАЖ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

“Л ХОЁР” ХХК

39,984,000 төгрөг



#### ТОВЧ МЭДЭЭЛЭЛ:

- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 12 дугаар тогтоолоор “Цээжний хөндийн хагалгааны багаж” төслийг 40,000,000 төгрөгөөр санхүүжүүлэхээр батлав.
- Захиалагч аймгийн ЗДТГ “Цээжний хөндийн хагалгааны багаж” төслийн гүйцэтгэгч сонгон шалгаруулж гэрээ байгуулсны дагуу захиалагч Өмнөговь аймгийн ЗДТГ, гүйцэтгэгч “Л хоёр”, санхүүжүүлэгч “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” хооронд санхүүжилтийн гуравласан гэрээг байгуулснаар төслийн ажлыг эхлүүлэв.
- Төсөл хэрэгжиж байна.



Итгэцээд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ

## 14. “БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВД ШААРДЛАГАТАЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ НИЙЛҮҮЛЭХ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:


ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

“НДАБ” ХХК

458,900,000 төгрөг



### ТОВЧ МЭДЭЭЛЭЛ:

- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 02 дугаар тогтоолоор “Бүсийн оношилгоо эмчилгээний төвд шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэх” төслийг 626,200,000 төгрөгөөр санхүүжүүлэхээр батлав.
- Захиалагч аймгийн ЗДТГ дээрх ажлыг 3 багц болгон тендер зарлаж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан гэрээ байгуулсны дагуу захиалагч Өмнөговь аймгийн ЗДТГ болон санхүүжүүлэгч “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” нь төслийн гүйцэтгэгчид болох “Мед импекс интернэшнл” ХХК, “Ай мед техноложик” ХХК, “НДАБ” ХХК -тай санхүүжилтийн гуравласан гэрээг тус тус байгуулснаар төслийг эхлүүлэв.
- Дээрх төслийн хүрээнд 2023 онд “НДАБ” ХХК Өмнөговь аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвд хөхний рентген зураг авах тоног төхөөрөмж, эрүү нүүр, шүдний дэлгэмэл рентген аппарат нийлүүлж 2023.07.03-нд комисст хүлээлгэн өгсөн.





## САНХҮҮЖИЛТИЙН КВОТ

### САНХҮҮЖИЛТИЙН КВОТ, ЗОРИЛГО

Санхүүжилтийн квотын зорилго нь “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн жилийн нийт санхүүжилтийн тодорхой хэсгийг Өмнөговь аймгийн сумдад квот тогтоон хуваарилах замаар сумдын удирдлага, иргэдийн оролцоонд тулгуурлан тэдгээр сумдын хөгжил, иргэдийн сайн сайхан байдлыг дэмжихэд чиглэсэн төсөл, хөтөлбөрүүдэд зарцуулах, хуваарилах юм.

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөл нь “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-аас Өмнөговь аймгийн Түншлэгч болон уул уурхайгүй сумдад хуваарилан олгодог байсан санхүүжилтийн квотын хамрах хүрээг нэмэгдүүлэх зорилгоор Сангийн төсөл хөтөлбөр санхүүжүүлэх санхүүжилтийн удирдамжид 2023 онд нэмэлт өөрчлөлт оруулан санхүүжилтийн квотыг дараах байдлаар олгохоор тогтов.

Тухайн жилд Өмнөговь аймгийн нийт 15 сумдад дээрх зорилгоор хуваарилах санхүүгийн дэмжлэгийн хэмжээ:

- Ханбогд суманд 85,000 ам.доллартой тэнцэх төгрөгийн санхүүжилтийн квот
- Манлай, Баян-Овоо, Даланзадгад сумдад тус бүрд 65,000 ам.доллартой тэнцэх төгрөгийн санхүүжилтийн квот
- Өмнөговь аймгийн бусад сумдад сум тус бүрд 45,000 ам.доллартой тэнцэх төгрөгийн санхүүжилтийн квот

№	Санхүүжилтийн квотод хамрагдсан сумын нэр	2023 онд хуваарилах боломжит нийт санхүүжилт (₮)	2023 оны гүйцэтгэл (₮)	Үлдэгдэл санхүүжилт (₮)
1	Ханбогд сум	511,282,591	401,101,000	110,181,591
2	Манлай	232,768,340	232,285,755	482,585
3	Баян-Овоо	260,543,125	249,210,000	11,333,125
4	Даланзадгад	240,801,830	-	240,801,830
5	Баяндалай	166,525,881	116,956,200	49,569,681
6	Сэврэй	157,726,600	154,800,000	2,926,600
7	Булган	156,046,215	69,900,000	86,146,215
8	Номгон	166,489,064	147,900,000	18,589,064
9	Цогт-Овоо	157,660,400	-	157,660,400
10	Мандал-Овоо	179,912,520	178,150,000	1,762,520
11	Хүрмэн	176,297,601	171,161,500	5,136,101
12	Цогтцэций	243,272,100	242,793,605	478,495
13	Ханхонгор	155,764,800	155,754,889	9,911
14	Ноён	155,764,800	150,000,000	5,764,800
15	Гурвантэс	155,764,800	42,388,240	113,376,560



*Итгэмцэлд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*



## 2023 ОНД ХАНБОГД СУМАНД ОЛГОСОН КВОТООР САНХҮҮЖҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТЭСЭЛ:

### 1. “ЦАХИМ ТАНХИМ” ТЭСЭЛ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТЭСӨВ:

**ХАНБОГД СУМЫН ЗДТГ**

**“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”**

**“ТӨВЛҮҮН ГОВЬ” ХХК**

**39,640,000 төгрөг**



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Сүүлийн жилүүдэд дэлхий нийтэд төдийгүй манай оронд захиргааны шинэтгэлийн хүрээнд олон чухал өөрчлөлтийг хийсний нэг нь төрийн үйлчилгээнд цахим үйлчилгээг нэвтрүүлж байна. Эдүгээ төрийн үйлчилгээг аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны гэсэн түвшнүүдэд хэрэгжүүлдэг бөгөөд төрийн үйлчилгээний дийлэнх хэсэг нь орон нутгийн Засаг даргын Тамгын газраар дамжин хэрэгжиж байна. Ханбогд сумын хувьд уул уурхай дагасан хүн амын төвлөрөл ихтэйгээс 2022 оны байдлаар албан ёсны бүртгэлтэй 8154 хүн ам, хөдөлгөөнт 20,000 гаруй хүн амтай томоохон сум юм. Энэ нь иргэд, аж ахуйн нэгж байгууллагад хаягийн тодорхойлолт, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн лавлагаа, жолооны үнэмлэхийн лавлагаа, цагдаагийн газрын лавлагаа, татварын лавлагаа гэх мэтээс эхлэн төрийн 80 гаруй төрлийн үйлчилгээ үзүүлэхэд дараалал, хүлээлт маш их гардаг.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Төрийн үйлчилгээг цахим болгож харилцан ялгаатай чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын зардал, чирэгдлийг бууруулах, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, хэрэглэгчдэд хүргэж буй үйлчилгээг ил тод, түргэн шуурхай, хунд сурталгүй болгож төрийн үйлчилгээг хөгжүүлэхэд чухал дэмжлэг болох.



### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Өмнөговь аймгийн Ханбогд сумын Засаг даргын Тамгын газарт цахим танхим байгуулахад шаардлагатай 15ш программ, техник хэрэгсэл нийлүүлж, танхимыг тохижуулсан.

### ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэнэ.
- Иргэд, аж ахуйн нэгж байгууллага 82 төрлийн үйлчилгээг цахим машинаас авах боломжтой болсон.

### Сэтгэгдэл Ханбогд сумын ЗДТГ-ын Угтах үйлчилгээний ажилтан Т.Бумцэнд:



*Нутгаа хөгжүүлэх төрийн үйлчилгээг ард түмэнд ойртуулсан нүдээ олсон сайхан танхимтай болсонд баяртай байна. Иргэд E-Монголиа-с бүх төрийн лавлагаа, Гэрэгэ нос машин нь 101 төрлийн үйлчилгээ, газрын цахим машины лавлагаа, канон зэрэг олон төрлийн үйлчилгээг нэг дороос, түргэн шуурхай хүлээн авдаг болсноор сэтгэгдэл өндөр, нүүр дүүрэн инээмсэглэлтэй баярлалаа гээд гардаг болсон нь сайхан байна. Энэ сайхан танхимтай болох төслийг дэмжсэн сумын ЗДТГ, санхүүгийн дэмжлэг үзүүлсэн “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-д баярласан талархсанаа илэрхийлье.*



## 2. “АХМАДЫН ХӨГЖИЛ САЙН ОРЧИН” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ХАНБОГД СУМЫН ЗДТГ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

“ГАЛБА АХМАДЫН ХОРОО” ТББ

19,183,500 төгрөг



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Ханбогд сумын Галба ахмадын хороо нь 450 гаруй ахмадыг эгнээндээ багтаан тэдний эрх ашиг, нийгмийн баталгааг хангахад тодорхой хувь нэмэр оруулан байнгын үйл ажиллагаа явуулдаг идэвх санаачилгатай хамт олон юм. Тус ахмадын хороо нь 2019 онд “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн санхүүжилтээр “Эрүүл насжилт” төслийг санаачлан хэрэгжүүлж ахмадуудынхаа эрүүл, урт удаан, идэвхтэй амьдралыг дэмжихэд чиглэсэн дасгалын тоног төхөөрөмжтэй болж байсан. Ахмадууд сардаа 3-4 удаа уулзалт, сургалт, уралдаан тэмцээн зохион байгуулдаг бөгөөд илүү тохилог орчин бий болгохоор төслийг санаачилсан.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Ахмад настны хэрэгцээнд тулгуурлан тэдэнд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх, биеэ даасан байдал, идэвх оролцоог хангах, дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилготой.

### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Өмнөговь аймгийн Ханбогд сумын Ахмадын хороонд шаардлагатай тавилга, техник хэрэгсэл нийлүүлж, ахмадын өргөө тохижуулсан.



### ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Ханбогд сумын 445 ахмад төслийн үр шимийг хүртэнэ.
- Ахмадууд чөлөөт цагаа өнгөрүүлэх тохилог, тав тухтай орчин бүрдэнэ.
- Ахмадуудад шаардлагатай сургалт, мэдээллийг хамгийн хялбар, энгийн хэлбэрээр олж авахад нь дэмжлэг болно.

### СЭТГЭГДЭЛ **Ханбогд сум Галба Ахмадын хорооны дарга Ч.Амгалан:**



“Говийн оюу хөгжлийг дэмжих сан” нь иргэдийн эрүүл мэнд, боловсрол, сургалт, байгаль орчин, соёлын өвийг хамгаалах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зэргээр орон нутгийн тогтвортой хөгжилд чухал хувь нэмэр оруулахад чиглэсэн олон сайхан төсөл хөтөлбөрийг санхүүжүүлж байдагт иргэд бид үргэлж талархаж байдаг билээ. Ханбогд сумын Галба Ахмадын хороо нь 500 шахам ахмад настны хүрээнд үйл ажиллагаагаа зохион байгуулдаг. Манай Ахмадын хороо нь 2023 онд ахмад настуудынхаа эрүүл мэндийг хамгаалах, аятай тухтай амарч эрхэлж тоглох, чөлөөт цагаа хөгжилтэй өнгөрүүлэх зорилготойгоор “Ахмадын хөгжил сайн орчин” төслийг санаачлан хэрэгжүүлж төслийн хүрээнд тавилга эд хогшил худалдан авсан юм. Бидний төслийг дэмжсэн Ханбогд сумын ЗДТГ, санхүүжүүлэгч “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-д баярлаж талархсанаа илэрхийлье.



*Итгэлийг суурьлсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

### 3. “СТАНДАРТТАЙ ХАНБОГД” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ХАНБОГД СУМЫН ЗДТГ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

“МАНЛАЙН УНДРАГА” ХХК

20,000,000 төгрөг



#### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Ханбогд сумын ЗДТГ нь албан ёсны бүртгэлтэй болон хөдөлгөөнт 28,000 гаруй иргэдэд төрийн бүхий л салбарын үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэхээр зорин ажилладаг. Тус ЗДТГ нь үйл ажиллагаандаа Олон улсын чанарын менежментийн тогтолцооны ISO9001:2015 стандартыг нэвтрүүлэн 19 үндсэн ажилтан, багийн Засаг дарга 5, гэрээт 5 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулдаг бөгөөд ажилтан, албан хаагчдынхаа ажиллах орчин нөхцөлийг нь сайжруулах байгууллагынхаа дотоод зохион байгуулалтыг сайжруулахаар энэхүү төслийг санаачилсан байна.

#### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Ханбогд сумын ЗДТГ-ын дотоод тохижилтыг сайжруулахаас гадна ажилтан, албан хаагчдынхаа тав тухтай орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх.

#### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Өмнөговь аймгийн Ханбогд сумын Засаг даргын Тамгын газарт тавилга, эд хогшил нийлүүлсэн.

#### ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Ханбогд сумын ЗДТГ-ын албан хэрэгцээнд шаардлагатай, дутагдалтай эд зүйлсийг бүрдүүлсэн.
- Албан хаагчдад тогтвор суурьшилтай, урам зоригтой, ажлын бүтээмж өндөртэй ажиллахад нь эерэг дэмжлэг болно.
- Төрийн албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх нь ISO9001:2015 стандартыг хэрэгжүүлэхэд чухал нөлөө болно.



#### 4. “ЭД МӨРИЙН БАРИМТ ХАДГАЛАХ АГУУЛАХ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ: 18,827,500 төгрөг

ХАНБОГД СУМЫН ЗДТГ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

“ГОВЬ БАЯН ЭНЕРГИ” ХХК



##### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Сумын орон тооны бус зөвлөлд албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгсэл ихээр ирдэг нь тэдгээрийг бүрэн, бүтэн, горимын дагуу хадгалах үүрэг хариуцлага даган гардаг бөгөөд суманд зориулалтын агуулахгүйгээс хураагдсан эд зүйлсийг хуулийн этгээдийн гаргасан шийдвэрийн дагуу худалдан борлуулах, үнэлэх, устгалд оруулах ажлын хэрэгжилт муу байна.

##### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Албадлагын арга хэмжээ авах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хураан авсан хөрөнгө, орлогоос хохирол нөхөн төлүүлэх, эд зүйл, хэрэгсэл, хөрөнгө, орлогыг улсын орлого болгох, худалдан борлуулах, шилжүүлэх, устгахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

##### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Өмнөговь аймгийн Ханбогд сумын Засаг даргын тамгын газарт доторлож тохижуулсан 20 тонны контейнер нийлүүлсэн.

##### ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Төрийн албаны ажлыг хөнгөвчилж үр дүнд нь эерэг нөлөө болно.
- Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах журмын хэрэгжилтэд түлхэц болно.



## 5. “ХҮҮХДИЙН СУРЧ ХӨГЖИХ ТААТАЙ ОРЧИН” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ХАНБОГД СУМЫН ЗДТГ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

С.ЖИНЖИЙБАДАМ

19,700,000 төгрөг



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Ханбогд сумын 29-р цэцэрлэг нь 2019 онд “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн санхүүжилтээр 200 хүүхдийн хүчин чадалтайгаар баригдсан бөгөөд одоогоор 311 хүүхэд, 33 багш ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна. Тус цэцэрлэг нь төрөөс баримталдаг сургалтын өмнөх боловсролын бодлого, хөтөлбөрийн дагуу хүүхдүүдээ хөгжүүлэх, багш, ажилтнууддаа чадавхжуулахад анхаарах, сургалтын орчин нөхцөлийг стандартад нийцүүлэх гэх мэтээр үйл ажиллагааныхнаа чанарт анхааран ажиллаж байна. Гэвч цэцэрлэгийн анги танхимуудад тоглоом хураах тавиуруудгүйгээс анги танхимууд эмх цэгцгүй байдгаас гадна багш нарын үндсэн ажилд зарцуулах цагийг бууруулдаг гэж үзэж байна. Мөн хүүхдийн бие бялдрын хөгжил, насанд тохирсон дасгалын тоног төхөөрөмжтэй болж тэдний сонирхол идэвх оролцоог нэмэгдүүлэн сургалтын чанараа сайжруулах саналтай байна.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Сургалтын өмнөх боловсролын үйлчилгээний орчин нөхцөлийг сайжруулж чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх.

### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Ханбогд сумын 29 дүгээр цэцэрлэгт хүүхдийн бие бялдрыг хөгжүүлэх төхөөрөмж, тоглоомын тавиурууд нийлүүлсэн.





### ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Цэцэрлэгийн хүүхдүүд өөрийн нас, биед тохирсон дасгал хөдөлгөөний төхөөрөмжүүдэд хичээллэх нь тэдний сурч хөгжих идэвх оролцоог нэмэгдүүлнэ.
- Хүүхдийн эрүүл мэнд, бие бялдрын хөгжил сайжирна.
- Цэцэрлэгийн анги танхимын тохижилт сайжирна.
- Хүүхдүүд эмх цэгцтэй орчинд сурч хөгжинэ.
- Багш нарын ажлыг хөнгөвчилнэ.

### Сэтгэгдэл 29-р цэцэрлэгийн эрхлэгч Х.Болорцэрэн:



Хүүхдийн сурч хөгжих таатай орчин бүрдүүлэхэд нийлүүлэгдсэн тоглоом хичээлийн хэрэглэгдэхүүний тавиур, бие бялдрын дасгалын төхөөрөмжтэй болсноор багш хүүхдийн хөгжилд дэвшилт гарч хүүхэд тоглонгоо хөгжихөд үнэтэй хувь нэмэр болж байна. Тоног төхөөрөмж хэрэглэгдэхүүн байхгүй үед анги танхимын булангууд нь эмх замбараа муутай байсан бол одоо булангуудаа тохижуулан баяжуулалт хийж хүүхдүүдээ хөгжүүлж ажиллаж байгаа нь үр өгөөжтэй байгаа билээ.



*Итгэмцэлд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

## 6. “ТОХИЛОГ ТААТАЙ ОРЧИНД СУРЧ ХӨГЖЬЕ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

**ХАНБОГД СУМЫН ЗДТ**

**“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”**

**“ГАЛБЫН ГОВИЙН ГЭРЭЛТ ИРЭЭДҮЙ” ТББ**

**19,000,000 төгрөг**



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Ханбогд сумын нэг, хоёрдугаар сургууль нь нийт 1000 гаруй суралцагч хүлээн авах хүчин чадалтай боловч хүн амын төвлөрлөөс шалтгаалан 1700 гаруй сурагч суралцдаг. Төслийн санаачлагч Ж.Одгэрэл нь бага ангийн багшаар 17 жил, бага боловсрол хариуцсан сургалтын менежерээр 9-н жил ажилласан, Тэргүүлэх зэрэгтэй багш бөгөөд 2020 онд бага ангийн сурагчдын сурлагын хоцрогдлын арилгах зорилгоор ГЭГЭЭРЭЛ СУРГАЛТЫН ТӨВ -ийг нээж өнгөрсөн хугацаанд боловсролыг дэмждэг байгууллагуудтай хамтарч нийт 520 сурагчдад сургалт зохион байгуулсан байна. Энэ хугацаанд тус сургалтын төвөөр үйлчлүүлэх хүүхдийн тоо жил ирэх тутам нэмэгдсэнээс гадна эцэг эхчүүдээс ажилдаа явсан хойгуур хүүхэд маань хараа хяналтгүй болдог, хичээл даалгавраа хийхгүй, гадуур сэлгүүцдэг тул хүүхдийн гэрийн даалгаврыг хийлгэх, ажлаас тартал хараа хяналт тавиад байлгаж өгөөч гэдэг хүсэлт олноор ирдэг болсноор 2023 оны 7-р сараас сургалтын төвдөө 120 кв.м барилгын өргөтгөл хийж улмаар олон хүүхэд нээлттэй байлгах зорилгоор ХҮҮХЭД ХӨГЖЛИЙН ТӨВ болгон өргөжүүлэн ажилласан байна. Тус сургалтын төв өөрийн нөөц хүчин чадлаараа хөгжлийн төвөө тохижуулж байгаа бөгөөд зорилтот бүлгийн буюу уул уурхайн компани, төрийн байгууллагад ээж, аав, асран хамгаалагч нар нь хоёулаа ажилладаг, өрх толгойлсон эрэгтэй, эмэгтэйн хүүхдүүд, бүтэн болон хагас өнчин хүүхдүүдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хичээлийн хоцрогдлоос арилгахад нь дэмжлэг болохоор энэхүү төслийг санаачилжээ.



### **ТӨСЛИЙН ЗОРИЛГО:**

- Бага ангийн сурагчдад хичээлийн бус цагаар тав тухтай, тайван сэтгэлзүйн орчинд шинэлэг, сонирхолтой арга зүйгээр эрдэм мэдлэг олгох, өөрийгөө хөгжүүлэх, гэрийн даалгавраа хийхэд нь туслах ба суралцахуйн шинэ чадваруудад сургах.

### **ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:**

- Ханбогд сумын зорилтот бүлгийн буюу уул уурхайн компани, төрийн байгууллагад ээж аав, асран хамгаалагч нар нь хоёулаа ажилладаг, өрх толгойлсон эмэгтэйн хүүхдүүд, бүтэн болон хагас өнчин, үл хайхрах хүчирхийлэлд өртдөг 1-5 дугаар ангийн нийт 75 хүүхдийг судлан хамруулж хүүхдэд монгол хэл, математик хичээлийн хоцрогдол арилгах, иргэний ёс зүй, хөгжим, иог, гоо зүй, бүжиг зэрэг 7 чиглэлээр хөгжүүлэх сургалтыг 3 сарын хугацаанд зохион байгуулна. Төслийн хэрэгжилт 2024 оны 01 сард эхэлнэ.

### **ТӨСЛИЙН ҮР ДҮН:**

- Үл хайхрах хүчирхийлэлд өртдөг болон бусад шаардлагатай хүүхдүүдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд дэмжлэг үзүүлэх.
- Сургалтад хамрагдсан сурагчдын сурлагын түвшинд ахиц гарна.
- Хүүхдүүдийг гэнэтийн аваар ослоос хамгаалахад эерэг дэмжлэг болно.
- Сурагчдын сэтгэх чадвар дээшлэх, авьяас чадвараа нээхэд дэмжлэг болно.
- Төсөлд хамрагдсан сурагчдын эцэг, эх сэтгэл тайван ажил хөдөлмөрөө эрхлэхэд нь дэмжлэг болно.



## 7. “ОЮУНЛАГ СУРАГЧ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:


ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ХАНБОГД СУМЫН ЗДТГ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

Х.ОЮУНБИЛЭГ

17,550,000 төгрөг



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Ханбогд сумын 1, 2-р сургууль нь нийт 1000 гаруй суралцагч хүлээн авах хүчин чадалтай боловч хүн амын төвлөрлөөс шалтгаалан 1700 гаруй сурагч суралцаж байна. Энэ нөхцөл байдлаас шалтгаалж анги танхимын хүрэлцээ дутагдаж сургуулийн үйл ажиллагаа зөвхөн сургалтын хөтөлбөрийн хүрээнээс хэтрэхгүй байгаа нь сурагчдад хоцрогдол арилгах, гүнзгийрүүлэн суралцах боломжууд гарахгүй байна. Төслийн санаачлагч Х.Оюунбилэг нь бага ангийн арга зүйч багш мэргэжилтэй бөгөөд 43 жил ажилласан туршлагатай.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Ханбогд сумын нэг, хоёрдугаар сургуулийн 1-5 дугаар ангийн математик, монгол хэлний хичээлийн хоцрогдолтой малчин өрх, уул уурхайн компанид ажилладаг эцэг эхтэй, төрийн албан хаагчийн эзэнгүүддэг гэх мэт анхаарал, халамж шаардлагатай сурагчдын сурлагын чанарт ахиц гаргах.

### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Ханбогд сумын Ерөнхий боловсролын нэг, хоёрдугаар сургуулийн 1-5 дугаар ангийн 200 хүүхдэд



математик, монгол хэлний хичээлийн хоцрогдол арилгах сургалтыг 5 сарын хугацаанд зохион байгуулна. Хөтөлбөрийн хүрээнд электрон самбар-1ш, өнгөт принтер-1ш, ламинаторын машин-1ш зэргийг худалдаж авч ашиглах бөгөөд хөтөлбөр дууссан дараа Ханбогд сумын 1-р сургуульд хүлээлгэн өгнө.

### ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Хичээлийн хоцрогдолтой сурагчдын мэдлэгийн түвшинд ахиц гарч тэдгээр сурагчийн өөртөө итгэх итгэл нэмэгдэнэ.
- Сурагчдын чөлөөт цагаа үр дүнтэй өнгөрүүлэх зөв дадалд нь эергээр нөлөөлнө.
- Сурагч нь эх хэлээрээ зөв ярьж, бодол санаагаа ойлгомжтой илэрхийлэн, бүтээлчээр уншиж бичин, хэл соёлоороо бахархдаг болно.
- Монгол хэлний зүй, үгийн сангийн анхан шатны мэдлэг ойлголт эзэмших.
- Төрөл бүрийн эхийг уншиж, сонсож ойлгох, санаа бодлоо амаар болон бичгээр илэрхийлэх арга барил эзэмших.
- Эх хэлээрээ чадварлаг, соёлтой харилцах, үгийн сангаа нэмэгдүүлэх хүсэл эрмэлзэлтэй болох. Хэлний хэрэглээнд тулгуурлан унших, бичих, ярих, сонсох чадварыг эзэмшин, хэл сурах арга барилд суралцана.
- Сурагчдын математикийн боловсролд дэмжлэг үзүүлж ахиц гаргана.
- Орон зай, цаг хугацаа, гэх мэт энгийн ойлголтуудаас эхлээд аливаа юмсын зүй тогтлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр танин мэдэх арга барилд суралцана.
- Сурагчдын сэтгэх чадвар дээшлэх, авьяас чадвараа нээхэд эерэг дэмжлэг болно.

### СЭТГЭГДЭЛ **Иргэн Тогосмаа:**



Манай охин Буянзаяа нь Ханбогд сумын 2-р сургуулийн 2-р ангид сурдаг. Би 6 хүүхэдтэй ам бүл 7-уул. 2023 онд бага хүүхдээ төрүүлсэн бөгөөд энэ хүүхэд маань төрлөхийн саажилттай төрсөн тул ажил хийх боломжгүй гэртээ хүүхэд харж байна. Энэ үед “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн санхүүжилтээр бага ангийн хүүхдийн хичээлийн хоцрогдол арилгах “Оюунлаг сурагч” төсөл хэрэгжиж Буянзаяа маань үнэ төлбөргүй хамрагдаж унших, бичих, тоо бодох чадварууд нь сайжирсаар байгаад баяртай байна. Төслийг санаачлан сургалт явуулж байгаа багш нартаа маш их баярлалаа.



*Итгэлийг суурьлсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

## 8. “ГАЛБА ЦИРКИЙН ДУГУЙЛАНГИЙН СУРГАЛТЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:


ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ХАНБОГД СУМЫН ЗДТГ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

ГЯНЖМАА

20,055,000 төгрөг



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Өмнөговь аймгийн Ханбогд сумын Соёлын төвийн дэргэдэх “ГАЛБА” циркийн дугуйлан 2012 оноос үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Дугуйлан одоогийн байдлаар 2 багш, 20 сурагчтайгаар сургалтын үйл ажиллагаагаа явуулж агаарын үзүүлбэрийн хэрэгсэл, газрын үзүүлбэрийн хэрэгсэл, жижиг матраас ашиглан жилийн дөрвөн улиралд тогтмол бэлтгэл, сургуулилт хийж байна.

#### “Галба” циркийн дугуйлангийн сурагчдын гаргасан амжилтууд:

- 2012 онд Өсвөрийн циркчидийн анхдугаар их наадамд уран нугаралтын номероор оролцож тусгай байр, 5-р их наадамд агаарын номер болон хөлөөр шидэгчээр оролцож тусгай байр, Монгол Улсын Консерваторын нэрэмжит шагнал
- 2015 онд авьяаслаг Өмнөговьчууд урлагийн наадамд тэргүүн байр-18 хүүхэд
- 2016 онд Дэлхийн Гиннесийн номд бүртгүүлэх уран нугараачдын чуулбар болох ‘Уул усны домог’ нугаралтад 13 хүүхэд
- 2020 онд Монгол улсын Консерваторын Цирк бүжгийн ангид 1 хүүхэд суралцуулж төгссөн.

#### Гадаад харилцаа:

- 2019 онд Турк улсад зохиогдсон аялан тоглолтод уран нугаралт, агаарын үзүүлбэрээр дугуйлангийн 2 сурагч
- 2020-2021 онд Турк улсад шидэлттэй акробат, газрын үзүүлбэрээр дугуйлангийн 1 сурагч



- 2022 онд Испани улс руу агаарын үзүүлбэрээр дугуйлангийн 1 сурагч
- 2023 онд Бүгд Найрамдах Хятад улс “Морьтны гайхамшиг” тоглолтод дугуйлангийн 2 төгсөгч
- 2023 онд Испани улсад аялан тоглолтод дугуйлангийн 1 сурагч тус тус оролцож байна.
- 2023 оны 9-р сарын 20-нд Олон улсын циркчидийн тэмцээнд Болгар улсад нэг эмэгтэй шидэлттэй акробатаар ЗОЛА БРОСС хамтлагийн Хишигтэн групптэй оролцоно. 2023 оны 9-р сарын 20-ны өдөр Болгар улсад зохион байгуулагдах Олон улсын циркчидийн “Алтан морь” тэмцээнд ЗОЛА БРОСС хамтлагийн Хишигтэн групптэй хамтран “Шидэлттэй акробат” төрлөөр тус дугуйлангийн суралцагч нь оролцохоор бэлтгэл хангаж байна.

Өнгөрсөн хугацаанд “Галба” циркийн дугуйланд техник хэрэгслийн шинэчлэл хийгдэж байгаагүй бөгөөд цаашид дугуйлангийн үйл ажиллагааг илүү хүртээмжтэй, шинэлэг болгон хөгжүүлэхэд уран сайхны гимнастикийн бусад төрлийн зориулалтын хэрэгслүүд дутагдалтай байсан

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Ханбогд сумын сургууль, цэцэрлэгийн насны хүүхдүүд болон хараа, сонсголын бэрхшээлтэй хүүхдүүд амралт чөлөөт цагаа зөв зохистойгоор өнгөрүүлэн цаашид монгол улсын төдийгүй олон улсын чанартай тэмцээн, уралдаанд оролцох боломжийг олгох зорилготой.

### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Ханбогд сумын Соёлын төвийн дэргэдэх “Галба” циркийн дугуйланд 19 нэр төрлийн 172 ш сургалтын хэрэгсэл нийлүүлж байна.

### ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Циркийн дугуйлангийн нийт хүүхдүүд орчин үе, мэргэжлийн шаардлагад нийцсэн сургалтын хэрэгсэл ашиглан тав тухтай орчинд бэлтгэл, сургуулилтаа хийнэ.
- Хүүхдийн бие бялдрын хөгжлийг өв тэгш, эрүүл чийрэг, зөв болгоход эергээр нөлөөлнө.
- Мэргэжлийн шаардлага хангасан, шинэлэг олон нэр төрлийн сургалтын хэрэгслээр хангагдана.
- Аймаг орон нутагт төдийгүй Олон улсын хэмжээнд циркийн урлагийг сурталчлан таниулахад дэмжлэг болно.
- Монгол уран нугараачдын арга барил, техникийн өвөрмөц онцлогийг залуу үедээ өвлүүлэхэд дэмжлэг болно.

### СЭТГЭГДЭЛ “Галба” циркийн дугуйлангийн багш Г. Янжмаа:



Юуны түрүүнд та бүхэндээ маш их баярлаж байгаагаа дуулгахад таатай байна. “Галба циркийн тоног төхөөрөмжийг шинэчлэн сайжруулах” төсөл хэрэгжсэнээр циркийн дугуйланд хамрагдаж буй хүүхэд залуучуудын сурах орчин нөхцөл цаашилаад циркийн урлагаар хичээллэх хүсэл сонирхлыг нэмэгдүүлэхэд маш их дэмжлэг болсон. Эхний ээлжийн аппарат хэрэгсэл нийлүүлэгдэн циркийн сургалтын үйл ажиллагаандаа хэрэглэгдэхүүн болгон ашиглаж байна. Та бүхний цаашдын үйл ажиллагаанд нь өндрөөс өндөр

амжилт хүсье. Олон олон хүүхдийн мөрөөдлийг биеллээ олоход нь, сурч боловсроход нь тусалж дэмжих төсөл юм.



*Итгэцээг суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

## 9. “УСАА ХАЙРЛАЯ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ: **19,200,000 төгрөг**

**ХАНБОГД СУМЫН ЗДТ**

**“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”**

**“МӨНХ НОГООН ГАЛБА” ТББ**



**ГОВИЙН ОЮУ  
ХӨГЖЛИЙГ  
ДЭМЖИХ САН**

### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- “Мөнх ногоон Галба” ТББ нь Гурван талт зөвлөлийн санаачилгаар 2018 онд үйл ажиллагаагаа эхэлж говь нутгийн уул ус, ургамал, амьтны мөнхийн таатай орчныг өвлүүлэн үлдээх эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг байна. Тус байгууллагын үйл ажиллагаа явуулдаг Ханбогд сумын нутаг дэвсгэр дээр 4 багийн 83 малчин өөрсдийн энгийн болон гүний гар худгийн түвшний хэмжилтийг хийж байна. Уул уурхайн байгаль орчинд үзүүлэх нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зорилгоор малчид иргэд унд ахуйн усаа хянах хамгаалах зорилгоор стандартын шаардлагад нийцсэн багажийг өдөр тутамдаа хэрэглэх зайлшгүй шаардлага тулгараад байна.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Уул уурхайгаас байгаль орчинд үзүүлэх нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зорилгоор малчидтай хамтран худгийн усны түвшнийг жилийн 4 улиралд тогтмол хийх, судалгаа мэдээлэл гаргах.

### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Ханбогд сумын 4 багт усны автомат түвшин хэмжигч, усны түвшин хэмжигч метр тус бүр 1ш буюу нийт 8ш багаж нийлүүлэх бөгөөд багаж хэрэгслийн захиалга хийгдсэн.

### ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Ханбогд сумын малчид унд, ахуйн усаа хянах, хамгаалахад судалгаа мэдээлэлтэй болно
- “Мөнх ногоон галба” ТББ-ын үйл ажиллагаанд дэмжлэг болно.





## 10. “ТАВ ТУХТАЙ АРИУН ЦЭВРИЙН ӨРӨӨ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ХАНБОГД СУМЫН ЗДТГ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

Д.СҮХЭЭ

40,000,000 төгрөг



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- 2024 онд Ханбогд сумын түүхт 100 жилийн ойгоо тэмдэглэнэ. Тус сумын наадмын талбайд уламжлалт нүхэн жорлон байдаг бөгөөд энэ нь хөрс, агаарыг маш их бохирдуулдаг. Иймд иргэд, наадамчдад эрүүл ахуйн шаардлага хангасан үйлчилгээгээр үйлчлэх, байгаль орчны бохирдлыг бууруулах зорилготойгоор зөөврийн нийтийн ариун цэврийн байгууламж байгуулах хүсэлтэй байна. Уг ариун цэврийн байгууламж нь зөөврийн буюу машинд чирч явах боломжтой тул сум орон нутаг ямар ч арга хэмжээ зохион байгуулсан авч явж хэрэглэх боломжтой бөгөөд цуглуулсан бохирыг бохир ус зайлуулах төв системд юүлэх зориулалттай хийгдэнэ. Чингэлгийн хэмжээ нь 6м\*3м байх бөгөөд эрэгтэй, эмэгтэй, хүүхдийн ариун цэврийн өрөөтэй байх ба тус бүрдээ гар угаах, ариун цэврийн материал хадгалах өрөөтэйгөөр хийж наадмын талбайн дэргэд байрлуулан наадамчдад үйлчлэх юм.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Олон нийтийг хамарсан арга хэмжээний үеэр ил задгай бие засаж байгаль, орчныг маш ихээр бохирдуулдгийг бууруулах, халдварт өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, иргэд, наадамчдад ая тухтай орчин бүрдүүлэх.

### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Машинаар чирч зөөвөрлөх боломжтой чингэлэг хийж ариун цэврийн өрөөний зориулалтаар тохижуулан Ханбогд сумын ЗДТГ-т хүлээлгэж өгнө. Төслийн ажлыг 2024 оны 1-р улиралд дуусгана.

### ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Ханбогд сумын овоо тахилга, Дэмчогийн хийд, наадмын талбай зэрэг газруудад зөөвөрлөн ашиглах боломжтой, стандартын шаардлагад нийцсэн нийтийн ариун цэврийн байртай болох бөгөөд нүхэн жорлонгоос үүсдэг хөрс, агаарын бохирдол, халдварт өвчлөл гэх мэт олон сөрөг эрсдэлийг бууруулна.



Итгэцээг суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ

## 11. “ХОГ АНГИЛАН ЯЛГАХ САВ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ХАНБОГД СУМЫН ЗДТГ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

“ХАНБОГД ХОТ ТОХИЖИЛТ” ОНӨААТҮГ

70,000,000 төгрөг



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- “Ханбогд хот тохижилт” ОНӨААТҮГ нь 2015 оноос хойш тус сумын нийтийн эзэмшлийн гудамж талбайн тохижилт үйлчилгээ, айл өрх, албан байгууллагын энгийн хог хаягдлын тээвэрлэлт, төвлөрсөн хогийн цэгийн арчилгаа үйлчилгээ зэргийг хариуцан ажилладаг.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Ханбогд сумын төвийн нийтийн эзэмшлийн талбай болон хүн амын төвлөрөл ихтэй цэгүүдэд хог ангилах, ачих, цуглуулах зориулалттай хогийн савтай болж хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, иргэдийн хог хаягдлын талаарх боловсролыг дээшлүүлэх.

### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Ханбогд сумын төвийн нийтийн эзэмшлийн талбай болон хүн амын төвлөрөл ихтэй цэгүүдэд ангилах, ачих, цуглуулах зориулалттай 30ш хогийн сав нийлүүлж байршуулна. Төслийн ажлыг 2024 оны 1-р улиралд дуусгана.

### ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэхэд дэмжлэг болно.
- Иргэн бүрд хог хаягдлаа ил задгай хаяхгүй, ангилан хаях зөв дадал зуршлыг сурч хэвшүүлэх, өөрсдийн хандлагаа өөрчлөхөд нь эергээр нөлөөлнө.
- “Ханбогд хот тохижилт” ОНӨААТҮГ-ын ажилтан, ажилчдын өдөр тутмын ажлын ачаалал багасна.
- Сумын өнгө үзэмж сайжирна.



## 12. “ДУЛААН БАЙР ТУХТАЙ ОРЧИН” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ХАНБОГД СУМЫН ЗДТГ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

П.ОЮУ-ЭРДЭНЭ

19,945,000 төгрөг



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Ханбогд сумын ЗДТГ-ын өмчид бүртгэлтэй төрийн албан хаагчийн 4 айлын орон сууц нь 2009 онд ашиглалтад орсон 1 давхар, шувуун нуруун дээвэртэй, тоосгон барилга бөгөөд ашиглалтад орсноос хойш засвар үйлчилгээ хийж байгаагүй тул барилгын өнгө үзэмж, чанар маш муудсан байна. Тухайн орон сууцанд сумын төрийн албанд ажиллахаар ирсэн залуу гэр бүлийг дэмжин оруулдаг бөгөөд одоогоор сумын ЗДТГ-ын 2 албан хаагч, цагдаагийн 2 албан хаагчийн гэр бүл буюу нийт 17 хүн амьдарч байна. Сумын ЗДТГ-с төрийн албан хаагчдын амьдрах орчныг сайжруулах, нийгмийг баталгааг хангах зорилгоор төслийг санаачилсан байна.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Ханбогд сумын төрийн албан хаагчийн орон сууцанд амьдардаг албан хаагчдын амьдрах нөхцөлийг сайжруулж цаашлаад төрийн албанд тогтвор суурьшилтай ажиллахад нь эерэг дэмжлэг болох.

### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Ханбогд сумын төвд байрлах төрийн албан хаагчийн 4 айлын орон сууцыг хэсэгчлэн засварлана. Төслийн ажлыг 2024 оны 1-р улиралд дуусгана.

### ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Төрийн албан хаагчийн орон сууцанд амьдардаг иргэдийн амьдрах орчин сайжирч тогтвор суурьшилтай ажиллахад нь нь дэмжлэг болно.
- Сумын ЗДТГ өмч хөрөнгөө арчлан хамгаалж барилгын эдэлгээний хугацаа уртасна.
- Тус орон сууцны барилгын ашиглалтын хэвийн нөхцөл дээшилнэ.
- Сумын өнгө үзэмжид эергээр нөлөөлнө.



Итгэцээг суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ

### 13. “ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ ХОТХОН” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

**ХАНБОГД СУМЫН ЗДТГ**

**“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”**

**О.АЛТАНГЭРЭЛ**

**20,000,000 төгрөг**



#### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс нь Хууль зүй дотоод хэргийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Цагдан хорих байр, Баривчлах байр байгуулах тухай” А/238 дугаар тушаал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2019 оны 7 дугаар сарын 14-ны өдрийн А/146 дугаар тушаалаар Өмнөговь аймгийн Ханбогд суманд 19 алба хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр захиргаа санхүү, цагдан хорих байр, иргэний шийдвэр гүйцэтгэл, хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа гэсэн үндсэн 4 чиглэлээр Ханбогд, Манлай, Цогтцэций, Баян-Овоо сумдыг хариуцан ажиллаж байна.
- Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд Ханбогд сумын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн 13 айлын орон сууцыг барьж ашиглалтад оруулсан. Үүний үр дүнд тус хэлтэст бусад аймаг, орон нутгаас томилогдон гэр бүлээрээ ажиллаж, амьдарч байгаа алба хаагчид, залуу гэр бүлийн амьдрах нөхцөл бололцоог нь сайжруулж тогтвор суурьшилтай ажиллахад нь бодитой дэмжлэг болсон юм. Гэвч тус орон сууцны гадна тохижилт хийгдээгүй байгаа тул хашаа, ногоон байгууламж, хүүхдийн тоглоомын талбай, явган хүний зам, автомашины зогсоол зэргийг үе шаттайгаар барьж тохижуулахаар эхний ээлжид хашаа барих төслийг санаачилсан.

#### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Ханбогд сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн алба хаагчдын тав тух, эрүүл аюулгүй орчинд амьдрах хэрэгцээ шаардлагыг хангахад дэмжлэг болох.

#### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн алба хаагчдын 13 айлын 1 давхар орон сууцны гадуур хашаа барина. Төслийн ажлыг 2024 оны 1-р улиралд дуусгана.



### **ТӨСЛИЙН ҮР ДҮН:**

- Нийтийн зориулалттай орон сууцны орчны газрын тохижилт барилгын норм, дүрэмд зааснаар тохижуулагдаж оршин суугчдын эрх хангагдана.
- Орон сууцны орчны газар гадна зам талбайгаас тусгаарлагдаж оршин суугчдад ая тухтай, аюулгүй амьдрах орчин бүрдэнэ.
- Сумын өнгө үзэмжид эергээр нөлөөлнө.



Итгэцлэгд суурьлсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ

## 14. “АЛСЛАГДСАН БАГИЙН БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭГ ДЭЭШЛҮҮЛЭХ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ХАНБОГД СУМЫН ЗДТГ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

“ӨНДӨР БУЯНТ ХАЙРХАН” ХХК

40,000,000 төгрөг



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Өмнөговь аймгийн Ханбогд сумын Хайрхан багийн нутаг буюу хилийн бүсэд үйл ажиллагаа явуулдаг 32 дугаар цэцэрлэг нь Өмнөговь аймгийн төвөөс 350 км, Ханбогд сумын төвөөс 140 км-т байрладаг бөгөөд 2022 онд байгуулагдаж бүлгийн багш 2, туслах багш 2, тогооч, үйлчлэгч нийт 11 багш ажилтантайгаар үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчид байгууллага юм. Одоогоор тус цэцэрлэгт Хайрхан баг, Цагаан хад суурьшлын бүс, Гашуун сухайт боомт, Хилийн цэргийн 8-р заставын ажилтан албан хаагчдын 42 хүүхдүүд хамрагдан сургуулийн өмнөх боловсрол эзэмшиж байна. Төв сууринаас алслагдсан тус цэцэрлэгийн хувьд хүүхдийн хоол хүнсний материалын чанарыг алдагдуулахгүй хурдан шуурхай тээвэрлэх нь нэн тэргүүний асуудал болсон байна.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсний материалын чанарыг алдагдуулахгүй хурдан шуурхай тээвэрлэж эрүүл аюулгүй хоол хүнсээр хангахад дэмжлэг болно.

### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Ханбогд сумын Хайрхан баг дахь 32-р цэцэрлэгт Toyota Prius-41 автомашин нийлүүлсэн.



## ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Алслагдсан багийн нутаг дахь боловсролын үйлчилгээг сайжруулахад дэмжлэг болно.
- Хүүхдийн хоол хүнс, хэрэглэгдэхүүний чанарыг алдагдуулалгүй хурдан шуурхай тээвэрлэх боломжтой болсон.
- Төрийн үйлчилгээний тасралтгүй байдлыг хангахад дэмжлэг болсон.
- Яаралтай үед тусламж үйлчилгээ үзүүлэх нөхцөл боломжоор хангагдана.

## СЭТГЭГДЭЛ Ханбогд сумын 32 дугаар цэцэрлэг:



### ТАЛАРХАЛ

Ханбогд сумын 32 дугаар цэцэрлэг нь улс монголынхоо урд хилийн үүдэн босго нь болсон тус сумын “Хайрхан” багийн иргэд төдийгүй хил гааль, цагаан хад суурьшлын бүсийн хүүхэд багачуудыг хөгжүүлэх, зөв монгол иргэн болж төлөвшүүлэх эрхэм

зорилгын дор үүд хаалгаа нээж 3 дахь жилдээ сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагааг явуулж байна. “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-ийн санхүүжилтээр хэрэгжсэн “Алслагдсан багийн боловсролын үйлчилгээг дэмжих” төслийн хүрээнд манай байгууллага суудлын авто машинтай болж цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсийг тээвэрлэх, материаллаг баазыг бэхжүүлэх гэх мэтээр манай байгууллагад нийгмийн асуудлын бодитой дэмжлэг боллоо. Одоо бид цаг тухай бүрд Ханбогд сумаас хүүхдийн хоол хүнсний материалыг тээвэрлэж хүүхэд багачуудаа шим тэжээл, илчлэгтэй хоол хүнсээр ханган ажиллаж байна. Мөн багш ажилчдаа сургалт семинарт цаг алдалгүй түргэн шуурхай хамруулж ажиллаж байна.

САЙН БАГШИЙН ГАР ДЭЭР  
МАРГААШИЙН НАР МАНДАНА



Итгэцээг суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ



## 2023 ОНД МАНЛАЙ СУМАНД ОЛГОСОН КВОТООР САНХҮҮЖҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ:

### 1. НААДМЫН ТАЛБАЙН УСЖУУЛАЛТ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

МАНЛАЙ СУМЫН ЗДТГ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

Н.ПУНЦАГБОЛД

30,000,000 төгрөг



#### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Манлай сумын баруун хойд хэсэгт наадмын талбайтай зэргэлдээ 175м\*50м хэмжээтэй талбайд мод тариалсан. Уг модны талбай нь услалтын системд холбогдоогүй тул ёмкостьтой автомашинаар ус зөөж усалдаг. Зөөврийн усаар услахад тээвэр шатахууны зардлаас эхлээд урсгал зардал өндөр гардаг. Иймд шинээр байгуулсан модны талбай болон наадмын талбайг усалгааны нэгдсэн системд холбох шаардлага үүсэж байна.

#### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Суманд шинээр байгуулагдсан модны талбайг услалтын нэгдсэн системд холбож сумын төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх усалгааны зардлыг бууруулна.

#### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Манлай сумын наадмын талбайн хойд талын модны талбайг усны эх үүсвэрт холбож байна. Модны усалгааг шандын усалгаагаар хийнэ.

#### ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Сумын төвийн тодорхой хувийг ойжуулж ногоон байгууламж байгуулснаар зуны улиралд сумын нутаг дэвсгэрт орон хур тунадасны хэмжээ нэмэгдэх, цаашлаад сумын өнгө үзэмжид сайнаар нөлөөлж чийглэг уур амьсгал бий болоход дэмжлэг үзүүлнэ. Мөн хөрсний чийгийг хадгалснаар хөрсний элэгдлийг бууруулж, элсний нүүдлийг бууруулахад дэмжлэг үзүүлнэ.





## 2. МАНЛАЙ СУМ 100 ЖИЛД

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

МАНЛАЙ СУМЫН ЗДТГ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

Д.ОТГОНБАТ

60,000,000 төгрөг



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Манлай сум нь 1924 онд байгуулагдсан ба 2024 онд түүхт 100 жилийн ой тохиож байна. Түүхт ойг угтан сум орон нутгийн иргэдийн ёс заншил, байгаль цаг уур, орон нутгийн онцлог, алдар суутай хүмүүс, мал сүрэг, түүх соёлын үнэт биет болон биет бус өвийг олон нийтэд сурталчлах, түгээх, баримтжуулан авч хойч үедээ хадгалуулан үлдээх зорилготой.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Манлай сумын өнгөрсөн түүх, өнөө үеийн ололт амжилт, онцлог, түүх соёлын үнэт өв, дахин давтагдашгүй 100 жилийн олон баримтыг хадгалж, баримтжуулж өвлүүлэн үлдээх зорилготой.

### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Манлай сумын түүх, соёл, аж амьдралыг харуулсан номын баримт цуглуулах, эх бэлтгэлийн ажил явагдаж байна. Номыг 1000 хувь хэвлэнэ.

### ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Орон нутгийн настан буурлууд, иргэд хөдөлмөрчид, залуу хойч үе, алс хол суугаа нутгийн уугуул иргэд сум орон нутгийнхаа 100 жилийн түүхийг баримтжуулж авна.



Итгэцлэгд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ

### 3. СУРГУУЛИЙН ХҮҮХДИЙН АВТОБУС

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

**МАНЛАЙ СУМЫН ЗДТГ**

**“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”**

**Н.ГАНТӨМӨР**

**65,000,000 төгрөг**



#### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Манлай сумын ерөнхий боловсролын сургуульд энэ хичээлийн жилд 386 сурагчтай бөгөөд аймгийн хэмжээнд 9 жилийн сургалттай сургуулиудаас хамгийн олон суралцагчтай сургууль юм. Нэг хичээлийн жилд арваас дээш удаа тэмцээн уралдаанд явах шаардлагатай байдаг ба ихэнх тэмцээн уралдаанд явах сурагчид, хариуцах багш, эцэг эхийн тоо нь 16-аас дээш хүн болдог. Эдгээр хүмүүс аймаг, сумын тэмцээнд явахад унаа, тээврийн асуудал ихээр тулгардаг. Мөн Өмнөговь аймгийн Засаг дарга сар бүрийн нэгний өдрийг хүүхдээ сонсох өдөр болгосонтой холбогдуулан сум орон нутгийн удирдлагууд, сургуулийн удирдлагаас 2021-2023 онд 15 удаа хүүхдээ сонсох өдрийг зохион байгуулж саналыг сонсоход сурагчид сургуулийн автобустай болох гэсэн саналыг удаа дараа гаргаж байсан. Иймд суудлын тоо, аюулгүй, тав тухтай байдлыг хангасан тээврийн хэрэгсэл зайлшгүй шаардлагатай болж байна.

#### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Сурагчдыг багтаамж сайтай, аюулгүй байдалд нийцсэн унаагаар хангаж, уралдаан тэмцээнд явуулах, тэмцээн уралдаанд өргөн бүрэлдэхүүнээр оролцуулж, үе тэнгийн хүүхдүүдтэй уулзуулж, туршлага, мэдлэгээ солилцох зэргээр хүүхдийн хөгжлийг дэмжих зорилготой.

#### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Манлай сумын ерөнхий боловсролын сургуульд БНСУлсад үйлдвэрлэсэн Hyundai маркийн 25 хүний суудалтай бага оврын автобус нийлүүлсэн.



### ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Сурагчдын тэмцээн, уралдаанд гаргах амжилт ахих, оролцох хүүхдийн тоо нэмэгдэнэ.
- Аюулгүй байдлыг бүрэн хангасан, тав тухтай унаагаар үйлчилнэ.

### Сэтгэгдэл

Манлай сумын ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын багш  
Б.Баярмэнд:



Бид бүгдийн хүсэл биелж 25 хүний суудалтай иж бүрэн автобустай болсондоо баяртай байна. Аймгийн аварга шалгаруулах тэмцээнүүд болон улсын чанартай, бүсийн чанартай тэмцээнүүдэд олон хүүхэдтэй фургон машинд явахад хэцүү байдаг байсан. Одоо бол эдийн засагт хэмнэлттэй, нэг унаагаар ирж очиход хялбар болсон. Энэ асуудлыг шийдэж өгсөн “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-д баярлалаа.

### Сэтгэгдэл

Манлай сумын ерөнхий боловсролын сургуулийн 8Б ангийн сурагч  
И.Нандин-Эрдэнэ:



Манай суманд сар бүр хүүхдээ сонсох өдөр зохион байгуулагддаг. Үүнд хүүхэд бидний санал хүсэлтийг хүлээн авч хүүхдийн автобустай болгож өгсөн сум, сургуулийн удирдлагууддаа эх орны ирээдүй болсон эрдмийн их өргөөний эзэд багш сурагчдынхаа өмнөөс баярлаж талархаж буйгаа илэрхийлье. Хүүхдийн автобустай болсноор багш, ажилчид болон сурагчид бид аливаа тэмцээн уралдаан, олимпиад, чуулганд оролцохдоо ая тухтай тохилог аюулгүй зорчих болно гэдэгт бид баяртай байна. Алтан шар автобусандаа суугаад амжилт бүтээлээр дүүрэн, Манлай сумын манлайлагч нар гэдгээ батлан харуулахыг хүсэн ерөөе.



Итгэцээд сууринсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ

#### 4. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙГ АВТОМАШИНААР ХАНГАХ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

МАНЛАЙ СУМЫН ЗДТГ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

Т.БУРМАА

26,317,000 төгрөг



#### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Манлай сумын эрүүл мэндийн төв нь сумын нийт 2632 хүн амд эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээг түргэн шуурхай чанартай хүргэж ажиллах зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулж байна. Эрүүл мэндийн төв нь мал аж ахуйн 34 баг, сумын төвийн иргэд, зам ангийн ажилчдад эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байна. Эрүүл мэндийн даатгалаар санхүүждэг болсонтой холбоотойгоор гэрийн тусламж үйлчилгээ, өдрийн эмчилгээ, сэргээн засах тусламж үйлчилгээ зэргийг иргэдэд үзүүлж эхэлсэн ба эдгээр үйлчилгээг үзүүлэхэд ээлжийн эмч, сувилагч, ажилчдад бага оврын үйлчилгээний автомашин шаардлагатай байна. Мөн эрт илрүүлэг үзлэг шинжилгээнд хамрагдсан иргэдийг эмчлэн эрүүлжүүлэх, хавдартай иргэдэд хөнгөвчлөх эмчилгээ хийх зэрэг тусламж үйлчилгээ үзүүлэхэд эмч мэргэжилтнүүд иргэдэд хүрч үйлчлэх эрүүл мэндийн төвийн автомашин дутмаг, шаардлага хангахгүй байна.

#### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Эрүүл мэндийн төвийг бага оврын автомашинаар хангаснаар гэрийн тусламж үйлчилгээ, өдрийн эмчилгээ, сэргээн засах тусламж үйлчилгээний хүртээмж нэмэгдэж, эрт илрүүлэг, үзлэг, дархлаажуулалтын түвшин нэмэгдэнэ.



### **ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:**

- Сумын эрүүл мэндийн төвд эмнэлгийн тоноглолоор тоноглогдсон Тоёота пробокс маркийн автомашин нийлүүлсэн.

### **ТӨСЛИЙН ҮР ДҮН:**

- Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ, хүнд өвчтөнийг гэрээр асарч сувилах, гэрийн тусламж үйлчилгээ, өдрийн эмчилгээ, төрсөн эхийн нярайн эргэлт, сэргээн засах тусламж үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдэнэ.
- Эрт илрүүлэг үзлэг, дархлаажуулалтын түвшин нэмэгдэх, дуудлага хооронд иргэдийг удаан хүлээлгэх байдал багасна.



*Итгэцээг суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

## 5. ЧАЦАРГАНЫН ТӨГӨЛ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ: **5,370,800 төгрөг**

**МАНЛАЙ СУМЫН ЗДТГ**

**“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”**

**Д.ӨӨЛИЙ**



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Манлай сумын хэмжээнд 562 ахмад настан амьдардаг. Эдгээр ахмад настнуудаас амьдрах орчноо сайжруулах, залуу хойч үедээ сурч, хөдөлмөрлөх таатай орчныг бүрдүүлэх санал санаачилга гаргасан. Сумандаа мод тарих хүсэл эрмэлзэл бүхий ахмад настнуудыг дэмжих, хөдөлмөр эрхлэх боломжоор хангах, тэдний туршлага, мэдлэгийг хүүхэд, залуучуудад залгамжлуулан үлдээх хэрэгцээ шаардлага үүсэж байна.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Сумын ахмад настнуудын санаачилсан чацарганын төгөл байгуулах, түүнийг усалгаагаар хангах зорилготой.

### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Сумын төвөөс баруун урагш байрлах ногооны талбайн худгийг түшиглэн чацаргана мод тариалсан ба уг талбайг усалгааны системээр хангана.

### ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Сумын ахмад настан ажлын байраар хангагдана.
- Экологийн цэвэр бүтээгдэхүүнээр хангагдана.
- Сумын өнгө үзэмжид эерэг нөлөө үзүүлэх ногоон байгууламжтай болно.



## 6. ШАТАР ДААМНЫ КАБИНЕТ ТОХИЖУУЛАХ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

МАНЛАЙ СУМЫН ЗДТГ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

Б.БЯМБАНАСАН

10,000,000 төгрөг



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Манлай сумын шатрын клуб нь тус сумын сурагчдад шатрын сургалт явуулдаг ба одоогийн байгаа ширээнүүд стандарт шатрын хөлөг нарийддаг тул 2 ширээ нийлүүлж нэг шатар өрөөд тоглуулахаар сургуулийн насны болоод цэцэрлэгийн хүүхдүүдэд ширээ нь өргөдсөнөөс, шатар тоглох явцад ширээ нь салж шатраа бутрааж эвдэлдгээс гадна хүүхдэд маш тухгүй тул анхаарлаа төвлөрүүлж чаддаггүй. Одоогоор шатрууд нь хугарч эвдэрснээр сурагчдад хүрэлцдэггүй, гэрээсээ авчирсан шатраа унагаж хагалах зэрэг хүндрэлтэй байдаг.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Шатрын сургалтын иж бүрэн хэрэгсэлтэй, стандартад нийцүүлэн тохижуулсан кабинеттай болж сургуулийн хүүхдүүд төдийгүй насанд хүрэгчдэд оюуны спортыг түгээн дэлгэрүүлэх, хүүхэд залуучуудын цахим хэрэглээг багасгах, шат шатны тэмцээн уралдаанд тамирчид бэлтгэх зорилготой.



*Итгэцээг суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

### **ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:**

- Спорт цогцолборын шатар даамны кабинетад 51см\*51см хэмжээтэй хулдаасан хөлөгтэй шатар 24, шатрын цаг 12, 80см\*80см хэмжээтэй ханын шатар 2, өндрийг нь тохируулж болдог шатрын ширээ 12, 48см\*48см хэмжээтэй 100 буудалт даам 12 ширхгийг тус бүр нийлүүлсэн.

### **ТӨСЛИЙН ҮР ДҮН:**

- Хүүхдүүд шатрын спортоор тав тухтай орчинд хичээллэх боломж бүрдсэн.
- Хүүхдийн бие даах, сэтгэх бодох чадвар хөгжинө.
- Оюуны спортыг сонирхдог хүүхдүүд олон бол цахим хэрэглээг хязгаарлах боломжтой болсон.





## 7. ГЭР БҮЛИЙН ХАРИЛЦААНЫ ҮНЭ ЦЭНЭ СУРГАЛТ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

МАНЛАЙ СУМЫН ЗДТГ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

Э.БАЛЖИРМАА

7,262,000 төгрөг



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Өнөөгийн нийгэмд тулгамдаж буй асуудлын нэг болох гэр бүл салалтаас болж хүүхэд хамгийн ихээр хохирдог. Иймд иргэдэд гэр бүл төлөвлөлт, түүний талаар ойлголт өгөх, мөн гэр бүлийн харилцаа, тогтвортой байдлын талаар гэр бүлийн боловсрол олгох шаардлага үүсээд байгаа юм.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Сумын нийт ард иргэдэд гэр бүлийн боловсрол олгож, гэр бүлийн тогтвортой байдал, харилцаа холбоог дэмжих, төлөвшсөн гэр бүл бий болгоход оршино.

### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Сумын иргэдэд хүүхэд хамгаалал, гэр бүлийн харилцааны тэгш байдлыг хэрхэн хангах, гэр бүлийн үнэ цэнэ, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдэд цахим орчин ба хэрэглээ, хүүхэд өөрийгөө хамгаалах зэрэг сэдвүүдээр нийт 8 цагийн, 4 удаагийн сургалт зохион байгуулна.



## ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Иргэд гэр бүл төлөвлөлт, харилцаа, хандлагын талаар ойлголттой болно.

## Сэтгэгдэл **Манлай сумын иргэн Б.Оюун:**



Өнөөгийн нийгэмд болж буй муухай бүхний эхлэл бол гэр бүлийн хүмүүжил, хувь хүний харилцаа хандлагаас ихээхэн шалтгаалдаг гэж боддог. Гэр бүлд чиглэсэн энэ сургалтууд маань цаг үеэ олсон сэдвийн дор явагдлаа. Энэ сургалт лекцийг хүн бүр сонсоод нэгийг бодоосой. Гэр бүлийн аз жаргал гэж чухам юу вэ гэдгийг мэдээсэй. Инээмсэглэл ямар их ид шидтэй юм бэ гэдгийг энэ сургалтаас олж авлаа. Энэ төслийг санхүүжүүлсэн Говийн оюу хөгжлийг дэмжих санд баярлалаа.



## 8. АЮУЛГҮЙ ЦЭВЭР ОРЧИНД АЯ ТУХТАЙ СУРАЛЦАЦГААЯ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

МАНЛАЙ СУМЫН ЗДТГ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

Б.БАЯНМӨНХ

9,794,000 төгрөг



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Манлай сумын ерөнхий боловсролын сургууль, дотуур байр, бага сургууль, спорт заалны ариун цэврийн өрөөний цэвэр усны шугам, жийрэг элэгдэн, ашиглалтын шаардлага хангахгүй болсон учраас ариун цэврийн өрөөг ашиглахгүй байна. Ариун цэврийн өрөөг засварлан, ашиглалтад оруулах шаардлагатай.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Хүүхдэд ээлтэй, суралцах, амьдрах таатай, аюулгүй орчин бүрдүүлэх зорилготой.

### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Сумын ерөнхий боловсролын сургууль, дотуур байр, бага сургууль, спорт заалны ариун цэврийн өрөө, халуун усны өрөөний гар угаах 60 тосгуур, 40 суултуур, 5 шүршүүрийн хэвийн ажиллагааг хангах жийргэвч, уян хоолойг шинэчилсэн.

### ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Сурагчид ээлтэй, таатай орчин бүрдсэн.
- Гадаа ариун цэврийн байгууламж ашигласнаар үүсэх аливаа халдварт өвчөөс урьдчилан сэргийлнэ.



*Итгэцээд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

## **Сэтгэгдэл** ЕБС 6-р ангийн сурагч Баярчимэгийн Тэмүүлэн:



*Бидний амьдарч буй орчин нөхцөлийг сайжруулан эвдэрсэн байсан тоног төхөөрөмжүүдийг янзалснаар бид бүхэн ая тухтай орчинд тав тухтай суралцацгааж байна.*




## 2023 ОНД БАЯН-ОВОО СУМАНД ОЛГОСОН КВОТООР САНХҮҮЖҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ:

### 1. ИРГЭДДЭЭ ОЙРХОН ШУУРХАЙ ТӨРИЙН АЛБА

ЗАХИАЛАГЧ:  
САНХҮҮЖҮҮЛЭГЧ:  
ГҮЙЦЭТГЭГЧ:  
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

БАЯН-ОВОО СУМЫН ЗДТГ  
“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”  
О.АЛТАНЦЭЦЭГ  
35,000,000 төгрөг



#### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Баян-Овоо сумын 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд Иргэддээ ойрхон шуурхай төрийн албыг бэхжүүлэн, төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл боломж, тоног төхөөрөмжөөр хангах талаар тусгагдсан. Энэ хүрээнд төрийн албыг иргэдэд шуурхай хүргэх, албан хаагчдын тоног төхөөрөмжийг сайжруулах хэрэгцээ шаардлага бий болоод байна. Учир нь дэлхий нийтээр нүүрлэсэн цар тахлын гамшиг, эдийн засгийн хүндрэлүүд, Засгийн газрын төсөв хэмнэх бодлогын хүрээнд шинээр хөрөнгө бэлтгэхийг хязгаарласан тул төрийн албанд зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмжийн дутагдалд ороод байна.

#### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд учирч буй хүндрэл, техник тоног төхөөрөмжийн дутагдлыг арилгах, төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, төрийн албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах зорилготой.

#### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Баян-Овоо сумын Засаг даргын тамгын газарт зөөврийн компьютер, өнгөт хэвлэгч зэрэг 2 нэр төрлийн 13 тоног төхөөрөмжийг нийлүүлсэн.

#### ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Иргэдэд хүрэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмж дээшилнэ.
- Төрийн албан хаагчид ажиллах нөхцөл боломжоор хангагдана.
- Цахим Монгол хөтөлбөр хэрэгжих боломж бүрдэнэ.



*Итгэлийг суурьлсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

## 2. ЧАМБАЙ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

**БАЯН-ОВОО СУМЫН ЗДТГ**

**“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”**

**“БУЯНТ ХӨХӨЛ” ХХК**

**35,000,000 төгрөг**



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- “Эко Баян-Овоо хот тохижилт” ОНӨААТҮТ нь тус сумын цэвэр бохир ус, хог тээвэр, тохижилт үйлчилгээ хариуцан ажилладаг. Одоогоор тус аж ахуй нэгжийн үндсэн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай бохир соруулах, хог тээврийн, цэвэр ус зөөвөрлөх автомашин, байгууллагын албан хэрэгцээний фургон автомашинууд байгаа ба тусгай зориулалтын гарааш, агуулах байгууламжгүй, айлын хашаанд байрлуулдаг бөгөөд ил задгай байрласнаар эд хөрөнгийн насжилт, тоног төхөөрөмжийн эдэлгээнд сөргөөр нөлөөлж байна.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Сумын ахуйн хэрэглээнд ашигладаг дээрх автомашинуудын эдэлгээг уртасгах, байгалийн болон нар салхины хүчин зүйлээс хамаарсан элэгдэл, хорогдлоос хамгаалах зорилгоор уг автомашинуудыг байрлуулж, гаднын хүчин зүйлээс хамгаалах гарааш барих зорилготой.

### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- 15м x 9м хэмжээтэй 4 автомашины гарааш барьж хүлээлгэн өгсөн.

### ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Төслийг хэрэгжүүлснээр дараах ач холбогдол, үр өгөөжтэй.
- Сумын ахуйн хэрэглээнд ашигладаг автомашиныг элэгдэл хорогдлоос хамгаална.
- Сумын иргэдэд тохижилт, ахуйн үйлчилгээг тасралгүй үзүүлэх боломж бүрдэнэ.





### 3. АНГЛИ ХЭЛНИЙ КАБИНЕТ ТОХИЖУУЛАХ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

БАЯН-ОВОО СУМЫН ЗДТГ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

Д.ЦЭРЭН

21,000,000 төгрөг



#### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Техник технологи эрчимтэй хөгжиж байгаа өнөө үед хүн бүрд гадаад хэлний мэдлэг, харилцан ойлголцох хэрэгцээ өдөр бүр тулгарч байна. Даяаршиж байгаа энэ цагт англи хэлний мэдлэгтэй боловсон хүчин, хүүхэд багачуудыг бага наснаас эхлэн сургах нь нэн чухал юм. Сурагчид орон нутагт ирсэн гадаад иргэд болон найз нөхдөдөө орон нутаг, сургууль, ёс заншлаа тайлбарлан ойлгуулах, бусдадаа орчуулга хийж өгөх, тэдэнд зориулсан дотоодын болон олон улсын хөтөлбөрт хамрагдах зэрэгт гадаад хэлний мэдлэгтэй байх шаардлага тулгарч байна. Энэ нь сурагчид бага наснаас англи хэлний мэдлэгийг өндөр түвшинд эзэмших хэрэгцээ шаардлага зайлшгүй байгааг илтгэж байгаа юм.

#### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Сурагчдын хэл сурах хүсэл сонирхлыг нэмэгдүүлж, улмаар англи хэлний үндсэн чадваруудын түвшнийг дээшлүүлэн англи хэлээр өөртөө итгэлтэй харилцах чадвартай болгох.

#### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Баян-Овоо сумын сургуулийн ерөнхий боловсролын сургуулийн англи хэлний кабинетыг тохижуулж 236 ширхэг ном, сургалтын хэрэглэгдэхүүн, үзүүлэнгийн материалаар хангасан.



## ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Сурагчдын сонсох, унших, бичих, ярих зэрэг үндсэн чадварт ахиц гарна.
- Гадаад хэлний үгийн сан нэмэгдэнэ.
- Хамтран суралцах боломж бүрдсэнээр өөртөө итгэх итгэл, урам зориг дээшилж, хамтран хөгжинэ.

## Сэтгэгдэл 8а ангийн сурагч Б.Аминзул:

Англи хэлний кабинет миний төсөөлснөөс илүү болсон. Бүх юмыг нь цаанаасаа хангаад өгсөн болохоор бүүр их таалагдсан. Тийм кабинетад сурч байгаа бид нар алзахгүй ээ. Англи хэлийг тоглоомоор ч тоглож сурдаг болохоор бид нарын анхаарлыг их татдаг. Ийм гоёо кабинетаар хангаж өгсөн бүх хүмүүст баярлалаа.

## Сэтгэгдэл 8а ангийн сурагч Б.Энхжин:

Англи хэлний кабинеттай болсноор хүүхдүүдэд англи хэл сурах маш хөгжилтэй санагддаг англи хэлийг сонирхолтойгоор орох орчин бүрдээд англи хэл сурах их амархан санагддаг ойлгохгүй байгаа зүйлээ илүү ойлгоод бас өдрийн цагаар ч гэсэн англи хэлний кабинетад очоод хичээл давтаад өөрийнхөө түвшинд тохирсон хичээлүүдийг үзэх боломжтой нь надад үнэхээр таалагддаг.

## Сэтгэгдэл А.Отгонсүвд:

Англи хэлний кабинеттай болсноор бид нарт сурах орчин мөн чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөхөд маш сайн үр дүн үзүүлсэн.





## 4. ХҮҮХЭД БҮР ЖАРГАЛТАЙ БАЙГ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

БАЯН-ОВОО СУМЫН ЗДТГ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

Ц.ОТГОНЧИМЭГ

20,000,000 төгрөг



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Баян-Овоо сумын 19-р цэцэрлэг нь 90 хүүхдийн хүчин чадалтай, 13 ажилтантай, өдрийн ангид 90 хүүхэд, хувилбарт сургалтад 28 хүүхэдтэйгээр үйл ажиллагааг тогтмол явуулж байгаа бөгөөд 2016 онд анги бүлгүүдийг дэвсгэрлэсэн боловч үүнээс хойш уг дэвсгэр элэгдэж бага насны хүүхдийн эрүүл ахуйн шаардлага хангахгүй болсон. Мөн цэцэрлэгийн хүүхдүүдийн хэрэглэдэг сандлуудад эвдрэл гарч ашиглалтын шаардлага хангахгүй болж, засаж сэлбэсэн нь хүүхдийн аюулгүй байдалд эрсдэл учруулахаар болсон.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Цэцэрлэгийн хүүхдүүдийн сурч, хөгжих таатай орчныг бүрдүүлэхэд нэн шаардлагатай байгаа дэвсгэр, ширээ сандалтай болох хэрэгтэй байна.

### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Баян-Овоо сумын 19-р цэцэрлэгийн 3 бүлгийн дэвсгэрийг сольж, анги бүрд 6 ширээ, 30 сандал, нийт 18 ширээ, 90 сандал нийлүүлж, цэцэрлэгийн коридорыг будаж сайжруулсан.

### ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Цэцэрлэгийн насны хүүхдүүдэд эрүүл орчинд суралцах боломж бүрдсэн.
- Суралцах орчин сайжирснаар хүүхдүүдийн идэвх оролцоо сайжирсан.
- Анги танхимын орчин сайжирснаар багш нарын ажлын бүтээмж дээшилсэн.



*Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

## **СЭТГЭГДЭЛ** Бэлтгэл бүлгийн багш Р.Болорзаяа:



*“Хүүхэд бүр аз жаргалтай байг” төсөл хэрэгжсэнээр манай цэцэрлэг болон бүлэгт маш их өөрчлөлт орсон. Ангийн өнгө үзэмж сайжирч хүүхдүүдийн сурч хөгжих таатай орчин бүрдүүлсэнд маш их сэтгэл хангалуун байна.*



## 5. СОЁЛЫН ТӨВИЙН ТОХИЖИЛТ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

БАЯН-ОВОО СУМЫН ЗДТГ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

“ШАНХ ЧАНДМАНЬ” ХХК

50,000,000 төгрөг



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Баян-Овоо сумын соёлын төв нь 1941 онд Улаан булан нэртэйгээр байгуулагдсан бөгөөд 2014 онд шинэ барилгатай болсон. Одоогоор 6 ажилтантайгаар урлаг, соёлын үйлчилгээг үзүүлж байна. Соёлын төв нь тайзны тохижилт багатай, заалны хана нь дуу шингээгчгүй тул аливаа урлаг, соёлын үйл ажиллагаа явуулахад цуурайтах, ярьж буй хүний дуу ялгагдаж сонсогдохгүй байх, мөн үзэгчдийн сандал нь дангаараа байдаг тул тогтворгүй байдаг зэргээр тухгүй байдаг. Тиймээс тайзны үзэмжийг сайжруулах, цуурайталтыг багасгах, үзэгчдэд тав тухтай орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Соёлын төвийн дотоод орчныг сайжруулах, иргэдэд урлаг, соёлын үйлчилгээг хүргэхэд таатай орчныг бүрдүүлэх зорилготой.

### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Баян-Овоо сумын соёлын төвийн тайзны хэсэгт тохижилт, үзэгчдийн хэсгийн сандлын суурь бэхэлгээ хийж, ханыг дуу шингээгч хавтангаар өнгөлсөн.



*Итгэцээг суурьтсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

### **ТӨСЛИЙН ҮР ДҮН:**

- Урлаг соёлын үйл ажиллагааны тоо нэмэгдсэн.
- Соёлын төвийн дотоод өнгө үзэмж сайжирсан.
- Сумын иргэд урлаг соёлын үйл ажиллагаанд тогтмол оролцох боломжтой болсон.

### **СЭТГЭГДЭЛ** **Соёлын төвийн эрхлэгч Ч.Соёл-Эрдэнэ:**

*Манай байгууллага энэхүү төслийг хэрэгжүүлснээр тайзны хөшигнүүд маань бүрэн солигдож сайхан болсон. Мөн шинээр шал шахаж сандлаа зөөгөөд нийтийн бүжиг цэнгээнт бүжгээ зохион байгуулахад шал сайхан болсон. Мөн гадагшаа маш ихээр дуу чимээ тархдаг орчны айл өрхүүдэд хэцүү байсан бол одоо дотор талаараа битүү бүрэн дуу тусгаарлагчаар бүрхэгдсэн.*



## 6. “ИДЭР АВАРГА” БӨХИЙН КЛУБ БАЙГУУЛАХ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

БАЯН-ОВОО СУМЫН ЗДТГ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

А.ЭРДЭНЭБАТ

25,000,000 төгрөг



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Баян-Овоо сум нь Улсын начин 3, аймгийн арслан 6 болон аймаг, цэрэг, сумын олон цолтон, мөн чөлөөт бөхийн олон улсын хэмжээний мастер 3, спортын мастер, дэд мастер олноор төрөн гарсан өлгий нутаг. Сүүлийн жилүүдэд суманд бөхийн төрлийн спортын хөгжил удааширч, бөхөөр хичээллэх хүүхэд, залуучуудын тоо цөөрсөөр байна. Иймд шинээр клуб байгуулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх, 2024 онд болох Баян-Овоо сум байгуулагдсаны 100 жилийн ойн үйл ажиллагаанд өсвөрийн 100 бөх барилдуулах, бөхийн бусад төрлөөр аймаг, улсын аварга, бүсийн уралдаан, тэмцээнд оролцох бэлтгэл хангах нөхцөл боломжийг бүрдүүлнэ.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Сумын өсвөр залуу үеийн бөхчүүдийг бэлтгэх, хичээллүүлэх, улс, аймаг, сумын цолтой бөхчүүдийн залгамж халааг бэлтгэх, Самбо, жудо, сумо, үндэсний бөхөөр хичээллэх хүүхдийн тоог нэмэгдүүлэх, хүсэл сонирхлыг өрнүүлэх, эрүүл чийрэг бие бялдрыг хөгжүүлэх зорилготой.

### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Баян-Овоо сумын фитнес клубт 8м\*8м хэмжээтэй чөлөөт бөхийн дэвжээ, чөлөөт бөхийн өмсгөл 20 ширхэг, үндэсний бөхийн зодог шуудаг 45 ширхэг, бөхийн жанжин малгай 30 ширхгийг тус тус нийлүүлсэн.

### ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Суманд бөхийн дэвжээтэй болсон.
- Хүүхэд залуус бөхийн спортоор хичээллэх боломж бүрдсэн.



## 7. АРИУН БАГАЖ АЮУЛГҮЙ ҮЙЛЧИЛГЭЭ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

**БАЯН-ОВОО СУМЫН ЗДТГ**

**“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”**

**Д.НАСАНЖАРГАЛ**

**19,650,000 төгрөг**



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Сумын Эрүүл мэндийн төвийн ариутгалын багаж, тоног төхөөрөмжүүд их хуучирсан, автоклавт ариутгалд орсон багажууд чийгтэй, нойтон гарч байгаа нь үйлчлүүлэгчид болон эмч нар тухайн багажаас халдвар авах эрсдэл үүсээд байна. Мөн лабораторийн шинжилгээний төрөл үзүүлэлт хангалтгүйгээс болж эмчилгээний үр дүн бага, үйлчлүүлэгч зарим шинжилгээг өгөхийн тулд аймаг болон бусад сум руу явах зэргээр цаг хугацаа алдах, санхүүгийн хувьд өндөр зардал гаргах зэргээр чирэгдэл үүсэж байна.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Ариутгалын тасагт нэн шаардлагатай тоног төхөөрөмж, багаж, хэрэгслийг худалдан авч, тасгийг тохижуулж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн стандарт, журмын дагуу багаж, хэрэгслийн ариутгалыг хийж, эмнэлгээр үйлчлүүлж буй иргэдэд аюул, эрсдэлгүй ариун багаж, хэрэгслээр чанартай үйлчилгээг үзүүлэх үйл ажиллагаа тогтмол болно.

### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Баян-Овоо сумын эрүүл мэндийн төвийн ариутгал, халдваргүйжүүлэлтэд нэн шаардлагатай байгаа автомат автоклав, ус нэрэгч, биохимийн хагас автомат анализатор, багаж хадгалах шүүгээ, гурван дамжлагат угаалтуур, багаж хадгалах кварцын шүүгээ зэрэг 17 нэр төрлийн 38 тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг нийлүүлсэн.



### ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Багаж хэрэгслийн ариутгалын чанар сайжирна.
- Үйлчлүүлэгчийн болон эмнэлгийн мэргэжилтний аюулгүй байдал хангагдаж, багаж хэрэгслээс авах халдварын эрсдэл буурна.
- Аюулгүй ээлтэй орчин бүрдэнэ.
- Ариутгалын урсгал зөв явагдана.
- Лабораторийн шинжилгээний чанар, хүртээмж сайжирна.
- Оношилгоо, эмчилгээнд ахиц гарна.
- Үйлчлүүлэгчийн цаг, санхүүг хэмнэнэ.

### СЭТГЭГДЭЛ **Эрүүл мэндийн төвийн сувилагч Н.Цагаанцэцэг:**



*Бидэнд нэн шаардлагатай хэрэгцээтэй болоод байсан тоног төхөөрөмж туслах материалаар хангагдсанд маш их баяртай байна.*



*Итгэцлэлд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

## 8. НУТГИЙН ЦОМОГ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

**БАЯН-ОВОО СУМЫН ЗДТГ**

**“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”**

**О.ЦОГБАДРАХ**

**19,000,000 төгрөг**



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Баян-Овоо сум нь нутгийнхаа онцлогийг харуулсан бэлэг дурсгалын зүйл байхгүй бөгөөд сум орон нутгийнхаа үзэсгэлэнт байгаль, зэрлэг амьтад, ургамлын хэв маягийг харуулсан зургийн цомог болон ном товхимол гаргаж байгаагүй учир сумын онцлогийг харуулсан гэрэл зургийн цомог, гарын авлагатай болох шаардлагатай байна. Сумын ард иргэдийн шүтээн болсон уул хайрхан, үзэсгэлэнт байгалийн тогтоц газар, зэрлэг амьтан, ургамал, байгаль цаг уурын цаг үеийн үзэгдэл, хүн ардын аж амьдралын хэв маягийг харуулсан гэрэл зураг бүхий ном бүтээнэ.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Сумын түүхт 100 жилийн ойг угтсан нутгийнхаа байгаль, дэлхийн үзэсгэлэнт газар нутгуудаа, нутгийн мал сүрэг, ургамал амьтан, иргэдийн амьдралын хэв маягаа гэрэл зурагт буулган үлдээж мөнхлөх, суманд зочилсон иргэдэд сум орон нутгаасаа өгөх дурсгалын цомог бий болгоно.

### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Сумын түүхэн дурсгалт газар, ан амьтан, иргэдийн амьдралын хэв маягийг харуулсан 170 зураг бүхий 160 нүүртэй гэрэл зургийн цомгийг бүтээн 500 ширхгийг хэвлэсэн.

### ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Сумын онцлогийг харуулсан дурсгалын зүйлтэй болсон.
- Үзэсгэлэнт газар, ан амьтад, ургамал, иргэдийн амьдралын онцлогийг харуулсан гэрэл зургийн сантай болсон.





## 9. СОНИНД МӨНХӨРСӨН БАЯН-ОВООГИЙН 100 ЖИЛ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

БАЯН-ОВОО СУМЫН ЗДТГ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

Ц.ГАЛБАДРАХ

20,000,000 төгрөг



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Нэгэн зууны хугацаанд Баян-Овоо сум, сумынхаа тухай төвийн болон орон нутгийн сонин, сэтгүүлд гарсан нийтлэл, тэмдэглэл, сурвалжилга, мэдээ мэдээллийг нэг дор үзэх боломж бололцоо өнөө хэр байгаагүй. Сумын түүх, нутаг ус, байгаль, тус сумын хөдөлмөрч ард түмний аж амьдралын талаар төвийн болон орон нутгийн сонин, сэтгүүлд 1924-2024 он хүртэлх 100 жилийн хугацаанд гарсан 2500-3000 орчим материалыг олж цуглуулан, сумын иргэдийн тухайн цаг үеийн түүхийг яг тэр цаг үедээ хэвлэлд гарсан баримтаар ном хэвлүүлэх нь үндэсний түүхэн талаасаа болон танин мэдэхүйн талаасаа ач холбогдолтой бүтээл болно.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Түүхт тэгш ой тэмдэглэж байгаа аймаг, сумдын хийж байгаа номын ерөнхий жишиг нь сумаас төрсөн нэр алдартай хүмүүсийн намтарт тулгуурласан танилцуулгын хэмжээнд хийгдсэн байдгаас зайлсхийж, илүү өргөн хүрээг хамарсан, бодит баримтаар ном бүтээх зорилготой.

### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Баян-Овоо сумын тухай төвийн болон орон нутгийн сонин, сэтгүүл гарсан мэдээллийг цуглуулж, сумын түүхэн номыг бүтээж байна.

### ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Баян-Овоо сумын 100 жилийн түүхэн мэдээллийн сантай болно.
- Сонинд гарсан мэдээлэл, түүхийг нэг дороос уншиж, танилцах боломжтой болно.
- Нутаг орныхоо тухай уншиж, үзэж танилцах боломж бүрдэнэ.



*Итгэцлэлд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*



## 2023 ОНД БАЯНДАЛАЙ СУМАНД ОЛГОСОН КВОТООР САНХҮҮЖҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ:

### 1. “УЛАМЖЛАЛТ ГЭР ТЭРЭГ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

**БАЯНДАЛАЙ СУМЫН ЗДТГ**

**“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”**

**О.АЛТАНСҮХ**

**10,000,000 төгрөг**



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Монгол Улсын Засгийн Газраас аялал жуулчлалыг шинэ түвшинд хөгжүүлэх зорилгоор 2023, 2024, 2025 онуудыг “Монголд зочлох жил”-ээр зарласан. 2022 оны зөвхөн 1-р улиралд манай улсад 12,336 гадаадын жуулчид ирсэн бол 2023 оны зөвхөн 1-р улиралд 78,000 гаруй жуулчид ирсэн нь өмнөх оныхоос 6 дахин нэмэгдсэн байна. Түүнчлэн Өмнөговь аймгийг зорин ирдэг жуулчдын ихэнх нь Баяндалай, Сэврэй, Гурвантэс сумд уруу аяллын маршрут гарган аялдаг байна. Тиймээс энэ зам дагууд үндэсний өнө эртний өв соёлыг харуулсан гэр тэрэгтэй жуулчдад үйлчлэх явуулын үйлчилгээг бий болгохоор сумын Баян багийн иргэн О.Алтансүх төслийг санаачилжээ. Тэрээр морин тэргэнд хөллөсөн монгол гэрт гадаад, дотоодын жуулчид, сонирхсон хэн бүхэнд идээ, ундаагаар үйлчлэхийн зэрэгцээ цаашид их эзэн Чингис хааны түүх, нүүдэлчдийн эртний өв соёлыг сурталчлан таниулах олон ажлын санаа гарган хэрэгжүүлнэ гэж төлөвлөсөн байна.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Иргэд олон нийтэд үндэсний өв соёлыг сэргээн таниулах, гадаад, дотоодын жуулчдад өв соёлоо сурталчлах.



#### **ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:**

- Баяндалай сумын ЗДТГ-г аялал жуулчлалын зориулалтаар дээр нь гэр барьж ашиглах морин тэрэг хийж нийлүүлсэн.

#### **ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:**

- Гадаад, дотоодын аялагч, жуулчдад үндэсний өв соёлыг сурталчлан таниулах
- Үндэсний өв соёлоо ирээдүй хойч үедээ сэргээн таниулах, хэрэглээнд оруулах
- Суманд аялал жуулчлалаас орох орлогыг нэмэгдүүлэх.



Итгэцээд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ

## 2. “ИРГЭНИЙ ТАНХИМ АЛДРЫН БУЛАН” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

БАЯНДАЛАЙ СУМЫН ЗДТГ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

Э.БҮРЭНЗАЯА

10,000,000 төгрөг



### ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Баяндалай сум нь 2100 хүн амтай, засаг захиргааны 3 багтай, Улаанбаатар-Өмнөговь-Баяндалай-Гурвантэс сумын хатуу хучилттай автозамаар холбогдсон, аялал жуулчлалын бүс нутаг дахь сум юм. Нутгийн өөрөө удирдах албан ёсны байгууллага болох ИТХ, ЗДТГ-ын барилга 2013 онд ашиглалтад орсон бөгөөд 2023 онд барилгын их засварт орохоор зураг төсөв, хөрөнгө батлагдсан байна. Мөн 2023 онд сум үүсэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ой тохиож байгаа бөгөөд энэ хүрээнд ойгоо угтан 100 бүтээлч ажил зарласны нэг нь сумын ЗДТГ-ын “Иргэний танхим”-ийг тохижуулж сумаас төрж гарсан алдар гавьяатнуудаа танилцуулах алдрын булан хийх ажил юм.

### ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- Байгууллагын дотоод үзэмж нэмэгдэхээс гадна иргэд олон нийтэд сургалт мэдээлэл, хурал хийхэд зориулсан тав тухтай орчин бүрдэх юм.

### ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Өмнөговь аймгийн Баяндалай сумын ЗДТГ-ын Иргэний танхимыг тохижуулан шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангасан.

### ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- Байгууллагын дотоод өнгө үзэмжид эергээр нөлөөлсөн
- Төрийн албаны үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдэхээс гадна иргэд олон нийтэд сургалт мэдээлэл, хурал хийхэд зориулсан тав тухтай орчин бүрдсэн



### 3. “ГАДАА ТАЛБАЙН ЗАСВАР БА ТОГЛООМ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

БАЯНДАЛАЙ СУМЫН ЗДТГ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

С.ГАНЦЭЦЭГ

23,000,000 төгрөг



#### ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Баяндалай сумын 13-р цэцэрлэгийн тоглоомын талбай нь 2012 онд ашиглалтад орсон бөгөөд одоогоор тоглоомуудын зарим нь эвдэрсэн, хамгаалалтын резин талбай элэгдэж хуурсан юм. Өнгөрсөн хугацаанд цэцэрлэгийн багш, эцэг эхчүүд өөрсдийн нөөц боломжоороо тоглоом, талбайн эвдрэлийг засаж сэлбэдэг ч хөрөнгийн нөөц бололцооноос шалтгаалж тоймтой засвар шинэчлэлт хийгдэхгүй байгаа нь боловсролын өмнөх сургалтын стандартын шаардлагад нийцэхгүй хэвээр байсаар байна. Энэ нь цэцэрлэгийн хүүхдүүд тоглож байхдаа гэмтэх эрсдэл өндөртэй болгож байна. Мөн зарим тоглоомууд нь цэцэрлэгийн насны хүүхдийн бие бялдарт тохирдоггүй тул зарим тоглоомыг шинээр худалдаж авах шаардлагатай байсан.

#### ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- Сургуулийн өмнөх боловсролын ая тухтай орчин бүрдүүлэх, хүүхдийг гэнэтийн аваар ослоос урьдчилан сэргийлэх.

#### ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Өмнөговь аймгийн Баяндалай сумын цэцэрлэгийн гадна тоглоомын талбайг шинэчлэн тохижуулж шаардлагатай тоглоом нийлүүлсэн.

#### ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- Хүүхдүүд ая тухтай, аюулгүй орчинд сурч хөгжихөд нь дэмжлэг болно.
- Хүүхдийн бие бялдрын хөгжилд эергээр нөлөөлнө.
- Цэцэрлэгийн гадна өнгө үзэмж сайжирна.



## Сэтгэгдэл 13-р цэцэрлэгийн багш Б.Мөнхцэцэг:



“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн 23,000,000 сая төгрөгийн санхүүжилтээр манай цэцэрлэгийн гадна тоглоом шинэчлэн засварлах, зарим тоглоомыг шинээр нийлүүлэх, талбайн зөөлөвч резин солих ажлууд хийгдэж бага насны хүүхэд аюулгүй, эрсдэлгүй орчин сурч хөгжих нөхцөл бүрдсэн билээ. Манай хамт олны ажлыг дэмжсэнд цэцэрлэгийн хамт олон болон асран хамгаалагчид, хүүхэд багачуудынхаа өмнөөс баяртай байна.

## Сэтгэгдэл 13-р цэцэрлэгийн эцэг эхийн төлөөлөл Б.Нансалмаа:



“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн санхүүжилтийн квотын хөрөнгө оруулалтын үр дүнд сумын цэцэрлэгийн хүүхдүүдийн сурч хөгжих орчин эрүүл аюулгүй, өнгө үзэмж, эмх цэгцтэй боллоо гэж харж байна, маш их баярлалаа. Энэхүү төслийн санхүүжилтээр манай сумын цэцэрлэгийн сургалтын гадна орчны өнгө үзэмж сайжирсан, тоглоом хэрэглэгдэхүүн нэмэгдсэн зэргээр хүүхэд багачуудын тоглох ая түхтэй орчин бүрдсэн байна.



#### 4. “СОЁЛЫН ТӨВИЙН ХУВЦАС ХИЙХ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

БАЯНДАЛАЙ СУМЫН ЗДТГ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

“СҮҮНДАЛАЙ ЭЭЖ” ХХК

35,956,200 төгрөг



#### ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Баяндалай сумын түүхт 100 жилийн ойд зориулж хүндэтгэлийн концерт, наадмын нээлтэд нутгийн ардын авьяастан, аймаг, хотод амьдардаг уран бүтээлчидтэй хамтарсан уран бүтээл хийгдэнэ. Харин сумын соёлын төвийн урлагийн хувцас хуучирч муудсан, мэргэжлийн шаардлага хангасан хувцас дутмаг байдаг. Иймд 100 жилийн ойгоо угтан соёлын төвийнхөө хувцас хэрэглэлийг шинэчлэхээр төслийн санаачилсан байна.

#### ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- Сум орноос зохион байгуулах урлаг соёлын арга хэмжээний өнгө үзэмжийг сайжруулах, уран бүтээлчдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх.

#### ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Баяндалай сумын Соёлын төвд үндэсний загварын урлагийн хувцас оёж нийлүүлсэн. (Ботгон тэшээ хувцас-75ш, Гоцлол бүжиг-3ш, уртын дуучны дээл-50ш, Морин хуурын дээл-30ш, бүжгийн хувцас-42ш, гоцлол дуучны дээл-2ш).



### **ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:**

- Баяндалай сумын соёлын төв шинэлэг, өнгө үзэмжтэй, тоглолт, арга хэмжээ зохион байгуулахад шаардлагатай урлагийн хувцсаар хангагдсан.
- Уран бүтээлчдийн ажиллах урам зоригийг нэмэгдүүлэхэд эергээр нөлөөлсөн.

### **СЭТГЭГДЭЛ** Баяндалай сумын уран сайханч Ц.Цогнэмэх:



*Энэ жил сумынхаа 100 жилийн ойн нээлтэд оролцож уртын дууны хэсэгт зогсож дуулсан. Энэ дуунд 50 хүн оролцож, “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн санхүүжилттэй хийгдсэн дээлийг өмсөж оролцлоо. Үнэхээрийн сэтгэл хангалуун байна. Маши гоё хийгдсэн урлагийн хувцас байсан. Энэ даирамд Өмнөговьчуудын төлөө сэтгэл оюунаа зориулан ажилладаг Говийн оюу хөгжлийг дэмжих санд ажлын өндөр амжилт хүсэн ерөөе.*





## 5. “100 ЖИЛ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:  
САНХҮҮЖҮҮЛЭГЧ:  
ГҮЙЦЭТГЭГЧ:  
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

**БАЯНДАЛАЙ СУМЫН ЗДТГ**  
**“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”**  
**“БҮРЭНЗАНДАН” ХХК**  
**38,000,000 төгрөг**



### ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Монгол Улсын Засгийн Газраас 2023 оныг “Монголд зочлох жил”-ээр зарласан, Баяндалай сумын түүхт 100 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан үндэсний өв соёлыг шингээсэн ёслол хүндэтгэлийн өргөөтэй болохыг зорьсон. Баяндалай сумын ЗДТГ-с жил бүр цагаан сарын нийтийн золголтыг зохион байгуулдаг бөгөөд цаашид залуу гэр бүлийг дэмжин гэрлэлт, хурим ёслолын хүндэтгэлийн арга хэмжээг үндэсний заншил шингэсэн орчинд зохион байгуулахад ёслол хүндэтгэлийн өргөө байгуулах нь чухал дэмжлэг болох юм.

### ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- Үндэсний зан заншил шингэсэн орчинд ёслол хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулан иргэд, залуу гэр бүлдээ үйлчлэх, ирээдүй хойч үе, аялагч жуулчдад өв соёлоо сурталчлан таниулах.

### ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Өмнөговь аймгийн Баяндалай сумын ЗДТГ-т 8 ханатай сийлбэртэй гэр, сийлбэртэй тавилга нийлүүлсэн.

### ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- Цагаан сарын нийтийн золголт, гэрлэлт, хурим ёслолын үйл ажиллагаа гэх мэт хүндэтгэлийн арга хэмжээг үндэсний зан заншлын дагуу зохион байгуулах орчин бүрдсэн.
- Аялагч жуулчдад өв соёлоо сурталчлах, иргэд, ирээдүй хойч үед үндэсний зан заншлыг сэргээн таниулахад дэмжлэг болсон.
- Сумын 100 жилээр наадамчин олондоо тохилог орчинд үйлчилгээ үзүүлсэн.



*Итгэцлэлд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*



## 2023 ОНД МАНДАЛ-ОВОО СУМАНД ОЛГОСОН КВОТООР САНХҮҮЖҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТЭСӨЛ:

### 1. “МОНГОЛ СОЁЛ БИДНИЙ БАХАРХАЛ” ТЭСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

МАНДАЛ-ОВОО СУМЫН ЗДТГ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

“ХАХИЛГА ДӨРВӨН БЭРХ” ХХК

89,000,000 төгрөг



#### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Мандал-Овоо сумын соёлын төв нь 1970 онд баригдсан. Тиймээс тус барилгын чанар муудаж ашиглалтын шаардлага хангахгүй болсон бөгөөд 2023 онд 280 хүний суудалтай соёлын төвийн барилга шинээр баригдаж байна. Шинээр баригдаж байгаа соёлын төв нь үзвэрийн танхим, урлаг, бүжгийн заал гэх мэт сумын урлаг соёлын үйлчилгээг явуулах зориулалтын өрөө, тасалгаануудтай болох бөгөөд эдгээрийг тавилга, хэрэгслээр тохижуулах шаардлагатай байсан.

#### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Иргэд олон нийтэд үзүүлэх соёлын үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдэх ба иргэдийн чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, гэр бүл, зорилтот бүлэгт чиглэсэн хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулах.



### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Мандал-Овоо сумын Соёлын төвийн урлаг, бүжиг зааланд шаардлагатай сандал, хөшиг болон 8 ханатай эрээн гэр нийлүүлсэн.

### ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Иргэдэд хүргэх соёлын арга хэмжээний чанар, хүртээмжид эергээр нөлөөлнө.
- Иргэд тав тухтай орчинд үйлчилгээ авна.
- Шинээр баригдаж буй соёлын төвийн тохижилтод дэмжлэг болно.

### Сэтгэгдэл **Соёлын төвийн дарга А.Ариунжаргал:**



*Монгол соёл-Бидний бахархал төсөл нь соёлын биет болон биет бус өвийг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, соёл урлагийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, чанартай хүргэх боломж нөхцөлийг бүрдүүлсэнд бид маш их баяртай байна. “Оюу толгой” ХХК, “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-д баярлалаа.*



*Итгэцлэгд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

## 2. “ИРГЭДИЙН ЭРҮҮЛ АЮУЛГҮЙ АМЬДРАЛ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

МАНДАЛ-ОВОО СУМЫН ЗДТГ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

“ХААНМАНДАЛ” ОНӨААТҮГ

57,400,000 төгрөг



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Нутгийн захиргааны байгууллага нь орон нутгийнхаа иргэдийн амар тайван, эрүүл, аюулгүй амьдрах, ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлж аливаа эрсдэлээс хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг чиглэлийг хэрэгжүүлдэг. Мандал-Овоо сумын төв нь гудамжны гэрэлтүүлэггүй. Үүнээс шалтгаалж иргэд осол бэртэлд өртөх, нохойд уруулах, гэмт хэрэг гарах зэрэг иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд эрсдэл өндөртэй байдаг.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Иргэдийг болзошгүй осол, гэмтэл, аюулаас урьдчилан сэргийлэх, иргэдийн ая тухтай амьдрах орчин сайжруулах, цагдаагийн ажилтны эргүүлийн ажлыг хөнгөвчлөх.

### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын төвийн нийтийн эзэмшлийн талбайд гэрэлт цамхаг суурилуулах, нийтийн эзэмшлийн талбайд хогийн сав байрлуулах, Цагдаагийн тасагт мотоцикл



нийлүүлсэн. (Гэрэлт цамхаг /7ш/, Гэрэлт цамхгийн ламп /12ш/, Гэрэлт лого /100 жил/, цагдаагийн мотоцикл /1ш/, хуванцрын хогийн сав /2ш/, ЛЕД туузан гэрэл /300м/).

### ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Мандал-Овоо сумын төвийн гэрэлтүүлэг сайжирч болзошгүй осол, гэмтэл, аюулаас урьдчилан сэргийлэхэд дэмжлэг болсон.
- Иргэдийн ая тухтай амьдрах орчин дээшлэхэд эергээр нөлөөлсөн.
- Цагдаагийн ажилтны эргүүлийн ажлыг хөнгөвчлөхөд дэмжлэг болсон.
- Нийтийн эзэмшлийн талбайд хогийн савтай болсон.

### Сэтгэгдэл **Сумын цагдаа Э.Бумбаяр:**



Энэхүү төсөл хэрэгжсэнээр цагдаагийн хэсэгтээ шинэ мотоциклтой болж, гэмт хэргээс сэргийлэх эргүүл хяналт хийх, иргэдэд түргэн шуурхай үйлчлэх боломж бүрдсэн. Мөн нийтийн эзэмшлийн талбай, гэр хороололд цамхагт гэрэлтүүлэг тавигдсанаар иргэд шөнө оройн цагаар аюулгүй зорчих, осол гэмтлээс сэргийлэх нөхцөлийг бүрдүүлсэнд иргэд баяртай байна.



*Итгэцлэлд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

### 3. “ҮНДЭСНИЙ ӨВ СОЁЛ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

**МАНДАЛ-ОВОО СУМЫН ЗДТГ**

**“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”**

**Т.МӨНХБАЯР**

**9,000,000 төгрөг**



#### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Монголчууд эрт дээр үеэс үндэсний баяр наадмаараа өөрсдийн урласан гоёмсог хээ, хуартай асар майханд зочид гийчдээ хүндэтгэн залан зочилдог өв соёлтой билээ. Монгол үндэсний майхан нь салхины хагалбарт тохирсон гурвалжин байдгаас гадна олсоор татагдан босдогоороо нүүдэлчин ард түмний амьдралд нийцсэн онцлогтой юм. Тиймдээ ч XIII зууны үед Монголд ирж байсан Европын нэрт жуулчин Марко Поло “Монголчууд бусдын газар нутгаар аялахдаа бороотой үед толгой хоргодох жижиг майхан, зэвсгээс өөр юу ч авч явдаггүй” гэж онцолсон байжээ.

2023 онд Мандал-Овоо сум үүсгэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ой тохиож буй бөгөөд сумын удирдлагууд баяр наадмын бэлтгэл ажил хангахаар төслийг санаачилжээ.

#### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Сумын 100 жилийн ойн хүрээнд наадамчин олонд үндэсний өв соёл шингэсэн, тохилог орчинд үйлчилгээ үзүүлэх. Цаашлаад иргэд, ирээдүй хойч үеийнхэнд зөөврийн асраар олон төрлийн үйл ажиллагаа, үйлчилгээ үзүүлж үндэсний өв соёлоо сэргээх, гадаад, дотоодын аялагч жуулчдад сурталчлах.



### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Мандал-Овоо сумын Засаг даргын Тамгын газарт монгол хээ угалзаар чимэглэсэн, бат бөх материалаар хийгдсэн, хөл, нуруу, баганын төмөртэй, уяа оосор, бүчтэй, савлагааны ууттай, зөөврийн 3 ширхэг асар майхан (4м\*6м) нийлүүлсэн.

### ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Сумын наадам, овоо тахилга тахилга гэх мэт үндэсний баяр ёслол зохион байгуулахад дэмжлэг болно.
- Иргэд, ирээдүй хойч үедээ өв соёлоо сэргээх, хэрэглүүлэх, гадаад, дотоодын аялагч жуулчдад сурталчлах, таниулах.

### Сэтгэгдэл **Мандал-Овоо сумын ЗДТГ-ын дарга Д.Адилбиш:**



Энэ төслөөр өв соёлоо сурталчлах арга хэмжээг зохион байгуулах үндэсний онцлог бүхий зөөврийн асраар хангагдсанаар орон нутгийн иргэд, гадаад, дотоодын аялагчид, хүүхэд залуучуудад соёл уламжлалаа сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, гадаа талбайд өдөрлөг, наадам, сургалт зохион байгуулах нөхцөл бүрдсэнээр өв соёлоороо бахархах, дээдлэх хүмүүжлийг төлөвшүүлэхэд их ач холбогдолтой арга хэмжээ болсонд бид бүхэн маш их баяртай байна. Орон нутгийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж биднийг үргэлж дэмжиж байдаг “Оюу толгой” ХХК, “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-д маш их баярлалаа. Мандал нутгийнхаа зон олны өмнөөс ажлын өндөр амжилт хүсэн ерөөе. Баярлалаа.



## 4. “МОНГОЛ НААДГАЙ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

МАНДАЛ-ОВОО СУМЫН ЗДТГ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

Э.ЛУВСАНСОНОМ

15,000,000 төгрөг



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Иргэд, хүүхэд залуучуудын дунд цахим тоглоом, гар утасны хэрэглээ маш их болсон өнөө цагт тэдний эрүүл мэндийг хамгаалахын зэрэгцээ чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, оюун ухаан, сэтгэн бодох чадварыг нь нэмэгдүүлэхэд үндэсний уламжлалт тоглоом наадгайгаар тоглох зан төлөвийг суулгах, төрөл бүрийн сургалт арга хэмжээ зохион байгуулах зэргээр олон арга хэмжээ зохион байгуулах боломжтой юм. Энэхүү хэрэгцээ, шаардлагаар Мандал-Овоо сумын эмэгтэйчүүдийн зөвлөлөөс төслийг санаачилжээ.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Иргэд, хүүхэд залуучууд, гадаад, дотоодын аялагчдад үндэсний тоглоом наадгайг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, үндэсний тоглоомоор тэмцээн уралдаан зохион байгуулах, үндэсний өв соёлоороо бахархах, дээдлэх хүмүүжлийг төлөвшүүлэх.

### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Мандал-Овоо сумын эмэгтэйчүүдийн зөвлөлд тоглоом, ширмэл эсгий дэвсгэр, олбог нийлүүлсэн (Эсгий тоглоом /мал, амьтан-500ш/, хөлөгт болон яс, шагайн тоглоом /200ш/, ширмэл 2x3 м /2ш/, ширмэл 0,5x0,5 м /10ш/).

### ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Үндэсний тоглоом наадгайг сурталчлах, түгээн дэлгэрүүлэхэд дэмжлэг болсон.
- Сумын эмэгтэйчүүдийн зөвлөлөөс үндэсний тоглоомоор тэмцээн уралдаан зохион байгуулах боломж бүрдүүлсэн.
- Иргэдэд өв соёлоороо бахархах, дээдлэх хүмүүжлийг төлөвшүүлэхэд эергээр нөлөөлнө.
- Сумын гар урлал хийдэг уран бүтээлчдийг түр ажлын байраар хангасан.





## СЭТГЭГДЭЛ **Мандал багийн иргэн М.Оюунбилэг:**



Би хүүхдүүдийнхээ хамтаар гар урлал хийж өрхийн орлогоо нэмэгдүүлэн амьдарч байна. Манай суманд Монгол наадгай төсөл хэрэгжсэнээр олон иргэдийг түрээслэн байраархангаж, орлогыг нь нэмэгдүүлэхийн зэрэгцээ үндэсний өв соёл, монгол тоглоомоо дотоод гадаадын олон иргэдэд таниулах, сурталчлах боломжийг олгосон үр дүнтэй ажил боллоо. Бид энэ төсөлд хамрагдаж 1000 ширхэг эсгий тоглоом урлаж өгч төслийн үр шимийг хүртсэндээ маш их баяртай байна.



Итгэцлэлд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ



## 2023 ОНД СЭВРЭЙ СУМАНД ОЛГОСОН КВОТООР САНХҮҮЖҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ:

### 1. “ЭРЭГТЭЙЧҮҮДИЙН БИЕ ЗАСАХ ГАЗАР”, “ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН БИЕ ЗАСАХ ГАЗАР”, “НИЙТИЙН БИЕ ЗАСАХ ГАЗАР” ТӨСЛҮҮД

ЗАХИАЛАГЧ:

**СЭВРЭЙ СУМЫН ЗДТГ**

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

**“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”**

1. “ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН БИЕ ЗАСАХ ГАЗАР”

ТӨСЛИЙН ГҮЙЦЭТГЭГЧ: **Я.САНДУЙЖАВ**

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН: **15,000,000 төгрөг**

2. “ЭРЭГТЭЙЧҮҮДИЙН БИЕ ЗАСАХ ГАЗАР”

ТӨСЛИЙН ГҮЙЦЭТГЭГЧ: **Я.САНДУЙЖАВ**

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН: **15,000,000 төгрөг**

3. “НИЙТИЙН БИЕ ЗАСАХ ГАЗАР”

ТӨСЛИЙН ГҮЙЦЭТГЭГЧ: **“ЛОЕД МАКС” ХХК**

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН: **40,000,000 төгрөг**



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Сэврэй сум нь засаг захиргааны Сайншанд, Хоолт, Бүйлсэн гэсэн 3 багтай, 2022 оны жилийн эцсийн байдлаар 667 өрхийн 2017 хүн ам тоологдсон байна. Тус сум нь 2015 онд цэвэр ус, 2019 онд бохирын төвлөрсөн шугам сүлжээтэй болсон бөгөөд 2023 онд гэр хороололд цэвэр, бохирын салбар шугамын өргөтгөл хийгдсэн. Одоогоор улсын хэмжээнд хөдөөгийн сумдад нийтийн бие засах газар байгуулах ажил дөнгөж эхлэл төдий байна. Ариун цэврийн хэрэгцээнд нүхэн жорлон ашигласнаар байгаль орчин, нийгмийн эрүүл мэндэд учруулах хорт нөлөөлөл их, тухайн орчны агаар, хөрсний усыг бохирдуулдаг, нийтийг хамарсан халдварт өвчлөлийн эх үүсвэр болдог гэх мэт маш их хор хөнөөлтэй билээ. Тиймээс төвлөрсөн цэвэр, бохир усны шугамд холбогдсон сумын хувьд байгаль орчноо хамгаалах, халдварт өвчлөлийг бууруулах, бусад сумдад үлгэрлэх ажлыг эхлүүлэх чухал ажил гэж төслийг санаачилсан.



### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Эрүүл ахуйн стандартын шаардлагад нийцсэн нийтийн бие засах газар байгуулж иргэдийн эрүүл, тав тухтай орчинд амьдрах эрхийг хангах, болзошгүй халдварт өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах.

### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- “Эмэгтэйчүүдийн бие засах газар” төслийн хүрээнд Сэврэй сумын наадам зохион байгуулах талбайд 20 тн-ын контейнер доторлож эмэгтэй ариун цэврийн өрөөний зориулалтаар тохижуулсан.
- “Эрэгтэйчүүдийн бие засах газар” төслийн хүрээнд Сэврэй сумын наадам зохион байгуулах талбайд 20 тн-ын контейнер доторлож эрэгтэй ариун цэврийн өрөөний зориулалтаар тохижуулсан.
- “Нийтийн бие засах газар” төслийн хүрээнд Сэврэй сумын төвийн нийтийн эзэмшлийн талбайд бие засах газар барьсан.

### ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Сэврэй сумын нийт иргэд, сумын төвөөр дайран өнгөрөх гадаад, дотоодын аялагч жуулчид, амрагчдад стандартын шаардлагад нийцсэн нийтийн бие засах газраар үйлчлэх боломжтой болсон.
- Нүхэн жорлонгоос үүсдэг хөрс, агаарын бохирдол, халдварт өвчлөл гэх мэт олон сөрөг эрсдэлийг бууруулахад эергээр нөлөөлнө.
- Сумын 100 жилийн ойгоор наадамчид, аялагчид тав тухтай, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн орчинд үйлчлүүлсэн.



Наадмын талбайд байршуулсан эрэгтэйчүүдийн бие засах газар, эмэгтэйчүүдийн бие засах газруудыг ижил загвараар буюу тус бүр 20 тн-ын контейнерыг ариун цэврийн өрөөний зориулалтаар тохижуулсан



## СЭТГЭГДЭЛ Сэврэй сумын иргэн Ахмадын хорооны дарга С.Цэнд-Аюуш:



“Нийтийн бие засах газар” төсөл хэрэгжүүлж сумын төвд орчин үеийн боловсон нийтийн бие засах газрыг ийнээр бий болгосон нь цаг үеэ олсон иргэд, аялагчдын сэтгэлд нийцсэн ажил боллоо. Урьд нь энд тэнд олон хуучин модон жорлон байсан нь эрүүл ахуй, өнгө үзэмжийн хувьд тааламжгүй байсан одоо цэвэрхэн сайхан бие засах газартай болсондоо сумын иргэний хувьд баяртай байна. Суманд олон сайхан төсөл хэрэгжүүлэхэд дэмждэг сумын ЗДТГ, “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-д баярлалаа.

## СЭТГЭГДЭЛ Сэврэй сумын иргэн сумын нийгмийн ажилтан П.Бямбадэлгэр:



Эрэгтэй эмэгтэй бие засах газар төслийг хэрэгжүүлж наадмын талбайд боловсон орчин үеийн бие засах газар бий болгож суултуур, тосгуур, толь байрлуулсан нь наадамчин олны тав тухыг хангасан маш сайхан ажил болсон. Наадмын өдрүүдэд цэвэрхэн сайхан байсан нь бүр ч их сайхан сэтгэгдэл төрүүлсэн шүү. Энэ мэт сайхан ажлуудыг дэмжин санхүүжүүлж байдаг “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн санхүүжилтийн квотын бодит үр шим гэж боддог.



## 2. “ЦАГ УУРЫН ТАЛБAYН ТОХИЖИЛТ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:  
САНХҮҮЖҮҮЛЭГЧ:  
ГҮЙЦЭТГЭГЧ:  
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

СЭВРЭЙ СУМЫН ЗДТГ  
“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”  
Ц.БАТБАЯР  
4,000,000 төгрөг



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Сэврэй сумын цаг агаарын харуулын алба нь 1974 оноос өнөөг хүртэл үйл ажиллагаагаа тогтмол явуулж байна. Уг албанд цаг агаарын мэдээ боловсруулах орчин үеийн тоног төхөөрөмж суурилуулаагүйгээс мэдээг өдөрт зөвхөн 3 удаа өгдөг хүчин чадалтай тул цаг агаарын мэдээг түргэн шуурхай, бодитоор хэмждэг хэмжилтийн багажтай болох шаардлагатай байсан.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Иргэд, нийтэд цаг агаарын мэдээг цаг тухайд нь, үнэн зөв мэдээлэх, учирч болзошгүй эрсдэлээс хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах, урьдчилан сэргийлэхэд дэмжлэг болох.

### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Сэврэй сумын цаг уурын ажиглалтын шинэчлэх шаардлагатай зарим хэрэгслийг сольж талбайн өнгө үзэмжийг сайжруулсан.



## ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Иргэд нийтэд цаг агаарын мэдээг цаг тухайд нь, үнэн зөв мэдээлэх, учирч болзошгүй эрсдэлээс хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах зэрэгт эерэг нөлөө гарна.
- Байгууллагын болон сумын өнгө үзэмжид сайнаар нөлөөлсөн.

## Сэтгэгдэл **Сэврэй сумын цаг уурын ажиглагч А.Тунгалагуяа:**



Сэврэй сумын цаг уурын ажиглалтын талбайг “Товийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн санхүүжилтээр засвар үйлчилгээ хийсэн. Засвар үйлчилгээ хийгдсэнээр талбайн өнгө үзэмж сайжирснаас гадна техник хэрэгслээр хангагдаж ажлын чанарт сайнаар нөлөөлж байгаад баяртай байгаагаа илэрхийлж байна. Төслийг дэмжсэн сумын ЗДТГ, санхүүжүүлэгч байгууллагууддаа баярлалаа.



### 3. “СЭВРЭЙ СУМЫН МУЗЕЙН ТОХИЖИЛТ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

СЭВРЭЙ СУМЫН ЗДТГ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

Ш.ЭНХБАЯР

19,800,000 төгрөг



#### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Сэврэй сумын музей нь соёлын төвдөө харьяалагддаг бөгөөд жил бүр 5-аас дээш музейн үзмэрээр баяжилт хийн хүүхэд багачууд болон нутгийн ард иргэддээ тогтмол үйлчилж тэдэнд үндэсний түүх соёлын боловсрол олгох арга хэмжээ, тэмцээн уралдаан зохион байгуулан ажилладаг. Музей нь нийгмийн хөгжилд үр нөлөө үзүүлэхүйц олон нийтэд чиглэсэн байнгын үйл ажиллагаатай, ашгийн бус байгууллага бөгөөд орон нутгийн түүх, амьдрах орчны тухай тухай баримт гэрч болох эд зүйлийг судлах, хүнд сурч мэдэх оюуны хэрэгцээг нь хангах зорилгоор үзмэр олж цуглуулах, хадгалах, хамгаалах, судлан шинжлэх, дэлгэн үзүүлж сурталчлах соёлын өвийг мэдлэг бий болгодог байгууллага юм. Уг орон нутаг судлах музей нь стандарт шаардлагад нийцсэн үзмэрийн хорго байхгүй, танхимын дотоод засал, тохижилт дутмаг тул төслийг санаачилсан байна.

#### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Сэврэй сумын иргэд, гадаад дотоодын жуулчдад сумын түүх соёлтой танилцах боломжийг бүрдүүлж, музейн үйл ажиллагааг өргөжүүлэхэд нь дэмжлэг болох.

#### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Сэврэй сумын Соёлын төвд үндэсний хэв загвар шингээн тохижуулсан монгол гэр нийлүүлж музейн танхимыг орчин үеийн шаардлагад нийцүүлэн нутгийн бахархалт өв уламжлалыг шингээн баяжуулж тохижуулсан.



## ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Сэврэй сумын орон нутгийн хөгжлийн түүх, соёлын өвийг баримтжуулан хадгалж, хамгаалах, хойч үедээ уламжлуулах, иргэдийн оюуны эрэлт хэрэгцээг хангах, тэдний боловсролыг дээшлүүлэхэд эерэг дэмжлэг болно.
- Сум орон нутгийн түүх, соёлын өвийг гадаад, дотоодын жуулчдад сурталчлах таатай нөхцөл бүрдсэн.

## СЭТГЭГДЭЛ **Сэврэй сумын Соёлын төвийн ажилтан Б.Эрдэнэчимэг:**



Манай сумын Музей нь 1974 он байгуулагдсан. Засвар үйлчилгээ хийгдээгүй стандартын бус хуучны барилга дотор байрладаг. 2023 оны 07 дугаар сард “Говийн Оюу хөгжлийн сан”-ийн төсөл хөтөлбөрөөр 19,800,000 төгрөгийн санхүүжилтээр Сэврэй сумын Музейн танхимыг орчин үеийн шаардлагад нийцүүлэн нутгийн бахархалт өв уламжлалыг шингээсэн өнөөгийн оюуны хэрэгцээ шаардлагыг хангасан танхимыг бий болгон баяжуулан тохижуулсан. Тухайн төсөл хэрэгжсэнээр суманд соёл, урлагийн үйл ажиллагаа явуулах, нутгийн иргэд болон гаднаас зорин ирэх зочид, жуулчдад нутгийн түүх, сумын байгаль, нийгмийн түүхэн замнал, өв уламжлал, нүүдэлчин монгол ахуй, нутгийн уламжлалт зан заншлыг шингээсэн, өнөөгийн оюуны хэрэгцээ шаардлагыг хангасан тохижилттой үзмэр бүхий музей бий болж соёлыг

сурталчлах таатай нөхцөл бүрдсэн. Сумын хүүхэд багачууд залуучууд, малчид, ахмад бүх иргэдэд тасралтгүй байнгын нээлттэй үйлчилгээ үзүүлсээр байна. “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-д чин сэтгэлээсээ баярлалаа. Ажлын их амжилтыг хүсье.





#### 4. “ЁСЛОЛ ХҮНДЭТГЭЛИЙН ӨРГӨӨНИЙ ГАДНА ТОХИЖИЛТ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

СЭВРЭЙ СУМЫН ЗДТГ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

Ц.САЙНЗАЯА

20,000,000 төгрөг



##### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Сэврэй сумын ЗДТГ нь 2019 онд 6 ханатай гэр барьж ёслол хүндэтгэлийн өргөөгөө байгуулсан. 2020 онд “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн санхүүжилтээр уг гэрийг нар, салхи, борооноос хамгаалах, өнгө үзэмжийг сайжруулах, ашиглалтын хугацааг нэмэгдүүлэх зорилгоор гадна талаар нь хамгаалах байр барьж дотор тохижилтын ажлыг хийсэн. Энэ тохижилтыг хийснээс хойш жил бүр цагаан сарын нийтийн золголтыг зохион байгуулж 2 залуу гэр бүлийн хуримыг үндэсний заншил шингэсэн орчинд зохион байгуулсан бөгөөд сумынхаа ахмад настнуудын хэрэгцээнд тулгуурлан тэдэнд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх, биеэ даасан байдал, идэвх оролцоог хангах, дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэн үйл ажиллагаагаа өргөжүүлсээр байна. Цаашид ахмадын өргөөгөө хаягжуулах, хашаажуулах, ногоон байгууламжтай болгох гэх мэтээр илүү тохилог орчин бий болгохоор төслийг санаачилсан.

##### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Ёслол хүндэтгэлийн өргөөнийхөө гадна тохижилтыг сайжруулан ахмадууддаа тав тухтай орчинд чөлөөт цагаа өнгөрүүлэх нөхцөл боломжоор хангах бусад ёслол хүндэтгэлийн үйл ажиллагааг өргөн хүрээнд зохион байгуулах.

##### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Сэврэй сумын ёслол хүндэтгэлийн өргөөний гадуур 65м хашаа барьж хаягжуулан, сандал ширээ, цэцгийн мандал худалдан авч, 20ш мод тарьсан.



## ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Сэврэй сумын өнгө үзэмж сайжрахаас гадна хуримын ёслол, гэр бүл батлуулах, ахмадуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хүлээн авах, зочид гийчдэд хүндэтгэл үзүүлэх гэх мэт олон төрлийн хүндэтгэлийн үйл ажиллагаа зохион байгуулахад тав тухтай орчин бүрдүүлсэн.

## Сэтгэгдэл **Засаг даргын Тамгын газрын дарга Ш.Одмаа:**



Сумын ёслол хүндэтгэлийн өргөө буюу хуримын ордныг хаягжуулж, хаашаажуулж тохижуулах ажлыг “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн хөрөнгөөр хийж гүйцэтгэлээ. Уг ажлын хүрээнд ёслол хүндэтгэлийн өргөөнд урсгал засвар хийж нэмэлт тохижил хийлээ. Мөн хаашаажуулж ногоон байгууламж бий болгох нөхцөл бүрдэж, иргэдэд үйлчилгээ үзүүлэх таатай орчин орчин бий болсонд баяртай байна. Сумын хөгжил цэцэглэлт, өнгө үзэмж, бүтээн байгуулалтад үнэтэй хувь нэмэр оруулж байгаа “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-д гүн талархал илэрхийлье.



## 5. “ЦООХОР ИРВЭС ХАМГААЛАХ, СУРТАЛЧЛАХ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ДҮН:

СЭВРЭЙ СУМЫН ЗДТГ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

“СЭВРЭЙ ГУРВАН МӨНХ” ХХК

41,000,000 төгрөг



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Дэлхийн хэмжээнд ховордсон зүйл амьтан болох Цоохор ирвэсийг 2000 онд Амьтны тухай хуулиар “Нэн ховор” гэсэн ангилалд оруулсан ба Байгаль хамгаалах олон улсын холбоо (IUCN)-ны Улаан номын “Устах аюул нүүрлэсэн” гэсэн ангилалд оруулсан байна. Харин 1994 онд зэрлэг амьтан, ургамлын ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцод бүртгэсэн. Цоохор ирвэс нь дэлхийн 12-хон орны нутагт тархсан, манай улс цоохор ирвэсийн тоогоор дэлхийд хоёрдугаарт ордог, монгол улсад 1200 орчим цоохор ирвэс байна гэсэн тоо баримтууд байдаг байна. Сэврэй сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар цоохор ирвэсийг сумынхаа Бахархалт амьтнаар зарлаж түүнийг хамгаалах олон ажлыг хийж байгаа юм. Тус сумын газар нутгийн 83 хувь нь улсын тусгай хамгаалалтад, үлдсэн хувь нь орон нутгийн хамгаалалтад байдаг бөгөөд аялал жуулчлал, мал аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлдэг бөгөөд 2023 онд түүхт 100 жилийн ой нь тохиож байна. Тиймээс ч тухайн сумын аялал жуулчлалын хөгжилд зориулан орон нутгийн онцлогийг харуулсан бүтээн байгуулалт хийх нь чухал үр дүн авчрах юм.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Наадамчдад тохилог сүүдрэвч, стандартад нийцсэн автомашины зогсоолоор үйлчлэх, сумын нийт иргэд, сумын төвөөр дайран өнгөрөх гадаад, дотоодын аялагч жуулчид, амрагчдад улаан номд орсон ховор амьтан цоохор ирвэсийн талаар мэдээлэл сурталчилгаа хийх.



## ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Сэврэй сумын төв рүү орох төв замын хажууд буюу наадмын талбайд сумын бахархалт амьтан цоохор ирвэсийн баримал, мэдээллийн самбар, гэрэлтүүлэг, явган зам, сүүдрэвч бүхий талбай байгуулсан.

## ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Сэврэй сумын нийт иргэд, сумын төвөөр дайран өнгөрөх гадаад, дотоодын аялагч жуулчид, амрагчдад улаан номд орсон ховор амьтан ирвэсийн талаар мэдээлэл сурталчилгаа болно.
- Наадамчдад зориулсан сүүдрэвч, автомашины зогсоолтой болсон.

## СЭТГЭГДЭЛ Байгаль хамгаалагч Э.Оюунцэцэг:



Сэврэй сумын ИТХ-ын 2013 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 41 дүгээр тогтоолоор ирвэс гэдэг амьтныг сумынхаа Бахархалт амьтан болгон зарлаж байсан. 2023 онд Говийн оюу хөгжлийг дэмжих сангийн хөрөнгөөр “Сумын бахархалт амьтан цоохор ирвэсийг сурталчлан, хамгаалах” төслийг хэрэгжүүлж сумын угтах хаалган дээр Сэврэй сумын бахархалт амьтан цоохор ирвэсийг сурталчлах хөшөө, сурталчилгааны самбар, авто зогсоол, сүүдрэвч гэрэлтүүлэг, явган хүний зам, угтах үсгэн хаяг зэргийг хийсэн нь маш их таалагдлаа. Цаашидаа сумын бахархалт амьтан цоохор ирвэсийг хамгаалах талаар сурталчлах олон ажлын эхлэл болж байна гэж харж байна. Та бүхэндээ

говийнхоо ирээдүйн хөгжил, хүн зоньхоо сайн сайхны төлөө олон сайхан төслийг хэрэгжүүлэх их үйлсэд нь өндөр амжилтыг чин сэтгэлээсээ хүсэн ерөөе.



## 2023 ОНД БУЛГАН СУМАНД ОЛГОСОН КВОТООР САНХҮҮЖҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ:

### 1. “ТҮҮХЭЭ МӨНХӨЛЬЕ-ДАЛАН НАМРЫН ТЭРТЭЙГЭЭС” БУЛГАН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН 70 ЖИЛИЙН ТҮҮХИЙН НОМЫН ЭХ БЭЛТГЭЛ, ХЭВЛЭЛ

ЗАХИАЛАГЧ:  
САНХҮҮЖҮҮЛЭГЧ:  
ГҮЙЦЭТГЭГЧИД:  
ЭХ БЭЛТГЭГЧ:  
НОМ ХЭВЛЭЛ:  
2 БАГЦ АЖЛЫН ГЭРЭЭНИЙ НИЙТ ДҮН: 30,000,000 төгрөг

**БУЛГАН СУМЫН ЗДТГ**  
**“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”**  
**ГОЮУНТУНГАЛАГ**  
**“АН ЖИН ТЭЭВЭР НЭГДЭЛ” ХХК**



#### ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Булган сумын ерөнхий боловсролын сургууль 1952 онд үүсгэн байгуулагдаж өдгөө 70 гаруй жил үйл ажиллагаагаа явуулж, тус сумын хүүхдүүдэд ерөнхий боловсрол олгон ажиллаж байна. Булган сумын ерөнхий боловсролын сургууль үүсгэн байгуулагдсанаас хойш сургуулийн үе үеийн удирдлага, багш, ажилчид, ахмадууд, тамирчид, алдартнуудыг мөнхлөн үлдээж алдаршуулах, сургууль байгуулагдсанаас хойших үүх түүхийг олон нийтэд сурталчлан танин мэдүүлэх ном, эмхэтгэл хийж байгаагүйгээс түүхэн үйл явдлууд мартагдах, баримт бичгүүд хуучирч муудах, алдагдах, гэх мэт эрсдэл үүсэж байна.

#### ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- Булган сумын сургуульд ажиллаж байсан үе үеийн удирдлага, багш ажилчид, тус сургууль сурч амжилт гаргасан хүмүүсийн тухай судалгаа хийж номын эмхэтгэл гарган ном хэвлүүлэх, сумын иргэд, зочид гийчдэд үзүүлэх ном хэвлэж гаргах.





## ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Тус хөтөлбөр хоёр үе шаттайгаар хэрэгжсэн цогц төсөл болж чадсан. Эхний ээлжид Булган сумын сургуулийн 70 жилийн түүхийн судалгаа шинжилгээний ажил хийж холбогдох зураг, ном, сонин, сэтгүүлүүдийг цуглуулан номын хэвлэлд зориулсан материал эмхэтгэн бэлтгэсэн. Түүний дараа энэхүү судалгаанд үндэслэн өнгө будаг сайтай, стандартад нийцсэн зураг, график, схем гэх мэт элемент сайтай А4 хэмжээтэй, 368 хуудастай, 1000 ширхэг ном хэвлэж улмаар олон нийтийн хүртээл болгосон.

## ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- Хэвлэгдсэн номыг сумын номын сан, архивд хадгалж үе үеийн алдартнууд, ахмадууд, багш ажилчид, сумдын иргэдэд гэх мэтээр тараасан. Уг номоос Булган сумын иргэд сургуулийнхаа түүхийг уншиж мэдлэг мэдээллээ тэлж, мөн цаашид сумын сургуулийн түүхийг хүүхэд залуучуудад түгээх нөхцөл бүрдсэн.

## СЭТГЭГДЭЛ **Булган сумын ЕБС-ийн Сургалтын менежер: Л.Эрдэнэцэцэг:**



*Манай сургууль 1953 онд байгуулагдсан 70 жилийн түүхтэй сургууль билээ. Өнгөрсөн 2023 оны сард түүхт 70 жилийн ойгоо тэмдэглэж ойд зориулан 70 жилийн түүхэн номоо бүтээхээр 10 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгээ байгуулан ахмад багш Л. Сугир, Н.Должидмаа нарын бичиж үлдээсэн гар бичмэл, хувийн архив нутгийн ард иргэд, төгсөгчдийн гэрэл зураг, дурсамж яриаг үндэслэн 70 жилийн номоо бүтээлээ.*

*Энэхүү түүхэн номын эх бэлтгэл, судалгааны ажил, мөн хэвлэлтийн ажлууд “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн санхүүжилтээр санхүүжүүлэгдсэн бөгөөд энэ сургуулийг төгссөн төгсөгчид, нутгийн ард иргэд, ахмад багш ажилчдын гар дээр хүрч сургууль маань 70 жилийн түүхэн номтой болсондоо туйлын их баяртай байна. Ингээд “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-д чин сэтгэлийн халуун талархал дэвшүүлж ажлын арвин амжилт хүсье.*



## 2. “5-Р ЦЭЦЭРЛЭГИЙН ГАЛ ТОГООНЫ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:  
САНХҮҮЖҮҮЛЭГЧ:  
ГҮЙЦЭТГЭГЧИД:  
ГЭРЭЭНИЙ ДҮН:

БУЛГАН СУМЫН ЗДТГ  
“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”  
“БАЯНЗАГ ДИНОЗАВР” ХХК  
20,000,000 төгрөг



### ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Булган сумын 5-р цэцэрлэгт тус суманд бүртгэлтэй сургуулийн өмнөх насны 104 хүүхэд танхимаар суралцаж боловсрол эзэмшиж байна. Цэцэрлэгт хамрагдаж буй хүүхдүүдэд чанартай боловсрол эзэмшүүлэх, нийгэмд өөрийгөө зөв боловсон авч явах чадвартай болгож төлөвшүүлэх ажлыг цэцэрлэгийн багш ажилчид хийж байна. Гэвч эрүүл аюулгүй байдалд сурч хүмүүжих нь цэцэрлэгийн орчин нөхцөлөөс шууд хамаардаг тул цэцэрлэгийн тоног төхөөрөмжийг шаардлагатай үед сольж байх нь их чухалд тооцогддог. Тус цэцэрлэгт одоо ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжүүдийн зарим нь ашиглалтын хугацаа дуусаж, зарим нь засварлах боломжгүй болсон. Иймд чанартай хоол хүнсээр хүүхдүүдийг хангахын тулд тус цэцэрлэгийн гал тогооны тоног төхөөрөмжийг шинэчлэх шаардлагатай байна.

### ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- Цэцэрлэгийн хүүхдүүдэд амин дэмтэй, шим тэжээлтэй, амт чанар сайтай хоолоор үйлчлэхийн тулд хоол хийхэд шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэх.



### ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Булган сумын 5-р цэцэрлэгийн гал тогоонд 1-р хоолны тогоо, дээжийн хөргөгч, буузны жигнүүр, босоо хөргөгч, махны машин, уур сорогч, хүүхдэд зориулсан иж бүрдэл таваг гэсэн 8 төрлийн 87 ширхэг эдлэл хэрэгсэл, тоног төхөөрөмж нийлүүлсэн.

### ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- Булган сумын 5-р цэцэрлэгт суралцаж өсөж торниж буй 104 хүүхдийн хоол хүнсний эрүүл ахуй, чанар хүртээмж сайжирсан.

### Сэтгэгдэл **Булган сумын 5-р цэцэрлэгийн тогооч М.Гэрэлчулуун:**



*Хөргөгч, 1-р хоолны тогоо, Буузны жигнүүр, махны машин, дээжийн хөргөгч, уур татагч, иж бүрдлийн таваг гэх мэт тоног төхөөрөмжөөр хангагдсан. Шинэ тоног төхөөрөмжтэй болсноор хүүхдүүддээ шим тэжээл, илчлэг сайтай хоолоор ханган 50-н нэр төрлийн хоол гарган ажиллаж байна. Шинэ тоног төхөөрөмжтэй ажиллахад сайхан байна. Нийт эцэг, эх болон Цэцэрлэгийн багш ажилчид бяцхан хүүхдүүдийнхээ өмнөөс баярлаж талархсанаа илэрхийлье. “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн санхүүжилтээр орчин үеийн тоног төхөөрөмжтэй болсондоо туйлын их баяртай байна..*






### 3. “ТУХТАЙ ОРЧИН” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:  
САНХҮҮЖҮҮЛЭГЧ:  
ГҮЙЦЭТГЭГЧ:  
ГЭРЭЭНИЙ ДҮН:

БУЛГАН СУМЫН ЗДТГ  
“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”  
Ц.ТОГООХҮҮ  
19,900,000 төгрөг



#### ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Булган сумын соёлын төвийн номын сан 1954 онд байгуулагдаж өдгөө хүртэл үйл ажиллагаа явуулж байна. 2010 онд “Тогтвортой амьжиргаа” төслийн хүрээнд номын санд тохижилтын ажил хийсэн боловч түүнээс хойш тохижилтын ажил хийх төсөв, санхүүжилт байхгүйгээс хүмүүс номын санд сууж ном унших боломжгүй сандал ширээ дутагдалтай гэх мэт хүндрэлүүд байсаар ирсэн.

#### ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- Булган сумын соёлын төвийн номын санд шаардлагатай тохижилтын ажил хийж шаардлагатай эдлэл хэрэгсэл, тоног төхөөрөмж нийлүүлж номын сангаар үйлчлүүлэгчийг тав тухтай орчинд хүссэн ном, сонин уншиж судлах боломж олгоно.

#### ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Булган сумын соёлын төвийн номын санд ханын өнгө сэргээх, дэвсгэр дэвсэж, таазны нөхөөс хийж танхимын гэрэл солих ажил хийж уншлагын 10 ширээ, ном бичиг баримт хийх зориулалтын 1 төмөр шкаф, 1 ханын тавиур, 7 эсгий самбар, 1 картын тавиур, 1 мэдээллийн самбар, номын үзэсгэлэнгийн 1 тавиур, 1 тоос сорогч, 1 суурин компьютер, 1 хар принтер, 1 ламинаторын машин нийлүүлсэн.



### ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН:

- Булган сумын байнгын оршин суугчид, мөн явуулын иргэдэд үйлчлэх тохь тухтай орчин бүрдүүлсэн.

### СЭТГЭГДЭЛ **Булган сумын Соёлын төвийн Номын санч И.Бат-Оюун:**



Миний бие 2023 оны 08 дугаар сараас эхлэн номын санчаар ажиллаж байна. Анх ажиллахад дотоод тохижилт муу, техник хэрэгсэл хоцрогдсон байсан. Говийн оюу хөгжлийг дэмжих сангаас номын сангийн төслийг дэмжин ажиллаж уг төслийн хүрээнд хана, тааз, дэвсгэр, ширээ, сандал, шкаф, тавиур, өнгөт, хар принтер, тоос сорогч, суурин компьютер, ганцаарчилсан унилагын кабин, мэдээллийн самбар, картын тавиур зэрэг бүгд шинэчлэгдэн солигдож хүүхэд багачууд, номд хайртай хэн бүхэнд хүртээмжтэй маш сайхан тохь тухтай орчин нөхцөлөөр бүрэн хангагдлаа. Энэхүү төслийг сэтгэл гарган хийж гүйцэтгэсэн

Ц.Тогоохүүэгчдээ болон “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-д чин сэтгэлээсээ ажлын өндөр амжилт хүсэн ерөөж, цаашид улам олон, нийтэд хүртээмжтэй сайхан ажлуудыг дэмжин ажиллахыг хүсье. Та бүхэнд баярлалаа сангийн хамт олонд баярласан талархсанаа илэрхийлье.




## 2023 ОНД НОМГОН СУМАНД ОЛГОСОН КВОТООР САНХҮҮЖҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ:

### 1. ХҮНДЭТГЭЛИЙН ӨРГӨӨ

ЗАХИАЛАГЧ:  
САНХҮҮЖҮҮЛЭГЧ:  
ГҮЙЦЭТГЭГЧ:  
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

НОМГОН СУМЫН ЗДТГ  
“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”  
Б.ГАНТУЛГА  
48,857,000 төгрөг



#### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Номгон сум байгуулагдсаны түүхт 100 жилийн ой 2024 онд тохиож байна. Тус сум нь Монгол улсын өмнөд цэгийн сум бөгөөд унаган байгаль, түүхийн өв соёл ихтэй, мал аж ахуйн 5 баг, газар тариалангийн 2 цэг, хилийн 3 заставтай төрийн үйлчилгээ хүргэх томоохон нэгж талбартай нутаг юм. Сумын ойг тохиолдуулж Номгон сумын уугуул, суугуул иргэд, үе үеийн алдар суутнуудыг хүлээн авч хүндэтгэл үзүүлэх тав тухтай орчныг бүрдүүлэхээр ажиллаж байна. Мөн цагаан сарын нэгдсэн золголт, сумын наадам, хурим найр, зочид гийчин хүлээн авах зэргээр ашиглах хүндэтгэлийн өргөөтэй болох хэрэгцээ шаардлага гарч байна.

#### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Сумын баяр ёслол, наадам зэрэг албан ёсны үйл ажиллагаанд ашиглах хүндэтгэлийн өргөө нийлүүлнэ.



Оюу  
Толгой

*Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

#### **ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:**

- Номгон сумын Засаг даргын тамгын газарт зургаан ханатай модон сийлбэртэй хүндэтгэлийн өргөө, дэвсгэр, сийлбэртэй модон ширээ, сандал хүлээлгэн өгсөн.

#### **ТӨСЛИЙН ҮР ДҮН:**

- Сумын онцгой үйл ажиллагаанд ашиглах өргөөтэй болсон.



## 2. ЭРҮҮЛ ОРЧИНД ХҮҮХЭД БҮР ЖАРГАЛТАЙ БАЙГ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

НОМГОН СУМЫН ЗДТГ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

Б.АЛТАНТУЯА

6,900,000 төгрөг



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Номгон сумын цэцэрлэг нь 2009 онд 100 хүүхдийн хүчин чадалтай шинэ хичээлийн байрандаа орж хамран сургах тойргийн 213 хүүхдийн 100 хүүхдийг өдрийн ангидаа 4 бүлэгтээ хүлээн авч хамруулан сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэн сургалт үйл ажиллагаагаа зохион байгуулан ажиллаж байна. Тус цэцэрлэг нь 2013 онд анги бүлгийн дэвсгэрийг шинээр сольж сайжруулсан бөгөөд одоогийн байдлаар ахлах, бэлтгэл бүлгийн дэвсгэрийг тасралтгүй 10 жил ашигласны улмаас уг дэвсгэр нь элэгдэж муудан, тоос тоосонцор, нян үржих зэргээр хүүхдийн эрүүл аюулгүй орчинд сурч хүмүүжих, өсөж торниход сөргөөр нөлөөлж байна. Тиймээс хүүхдийн сурч хөгжих таатай орчныг бүрдүүлж шинэ дэвсгэртэй болох хэрэгцээ шаардлагатай байна.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Цэцэрлэгийн ахлах, бэлтгэл бүлгийн сургалт үйл ажиллагаа зохион байгуулдаг хоёр анги бүлгийг үлгэр жишээ, орчин үеийн шийдэлтэй дэвсгэр нийлүүлэн тохижуулна.

### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Номгон сумын 14-р цэцэрлэгийн ахлах, бэлтгэл бүлгийн ангид эрүүл ахуйн шаардлага хангасан дэвсгэр нийлүүлэн хүлээлгэн өгсөн.



*Итгэцлэлд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

### ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Хүүхэд сурч хөгжих эрүүл ахуйн шаардлага хангасан таатай орчин бүрдсэн.
- Багш, хүүхэд, эцэг эхийн хамтын ажиллагаа сайжирсан.
- Тоглож наадан, сурч хүмүүжих нөхцөл бүрдсэн.

### СЭТГЭГДЭЛ **Нахиа бүлгийн багш А.Долгорсүрэн:**



*Ангийн дэвсгэрийг 100% шинэчилж өгсөнд баярлалаа. Бяцхан шавь нар маань тав тухтай цэвэр тохилог орчинд сурч хөгжиж байгаад баяртай байна.*

### СЭТГЭГДЭЛ **Бэлтгэл бүлгийн багш А.Чулуунцэцэг:**



*Говийн оюу хөгжлийн сангаас манай ангийн дэвсгэрийг шинэчилж өгсөнд үнэхээр их баяртай байна. Манайх Бэлтгэл бүлэг нийт 30н хүүхэд хамран тойргоор суралцаж байна. Хүүхдүүдийн маань сурах таатай орчныг бүрдүүлж өгсөнд маш их баярлаж байна.*



### 3. УРЛАГИЙН УРАН ШАГЛАА

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

НОМГОН СУМЫН ЗДТГ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

Ц.НАРАНГЭРЭЛ

92,143,000 төгрөг



#### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Номгон сум нь соёл, урлагийн салбараас төрөн гарсан алдартан гавьяатан олонтой, соёлын өвөө уламжлуулан хөгжүүлж байна. Иргэдийн улс, аймаг, бүсийн чанартай уралдаан тэмцээнд оролцох, мөн аливаа арга хэмжээний эхлэл нь соёлын үйлчилгээ тул соёлын өвийг түгээн дэлгэрүүлж иргэдийнхээ авьяас билгийг хөгжүүлж, урлагийн хувцасны орчин үеийн донж маягийг уламжлалт угсаатны гоо зүй, өв соёлтой хослуулан шинэчлэл хийх хэрэгцээ тулгараад байна.

#### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Урлагийн хувцасны шинэ шатны шинэчлэлийг хийж, иргэдийн урлаг, уран бүтээлийн ажлыг дэмжих, орон нутгийн онцлог уран урлагийн бүтээлийг бий болгох.

#### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Номгон сумын соёлын төвд нэн шаардлагатай байгаа урлагийн хувцас хэрэглэл, ялангуяа үндэсний соёлын шинж чанарыг агуулсан малгай, дээл, гутал, чимэглэл зэрэг 18 нэр төрлийн 209 хувцас хэрэглэлийг оёж нийлүүлсэн.

#### ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Ахмадаасаа уламжлагдан үлдэж буй соёлын төвийг түгээн дэлгэрүүлэх, уламжлах, шавь сургалтаар бусдыг хөгжүүлэх.
- Сумын нийт ард иргэд, хүүхэд залуучууд түүх соёлоо мэдэж, түүгээрээ бахархах, хамгаалах нөхцөл бүрдэнэ.
- Соёлын үйлчилгээний чанар, хүртээмж дээшилнэ.



Итгэцээд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ



## 2023 ОНД ХҮРМЭН СУМАНД ОЛГОСОН КВОТООР САНХҮҮЖҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ:

### 1. ЛЕД ДЭЛГЭЦ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:


ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ: **21,000,000 төгрөг**

ХҮРМЭН СУМЫН ЗДТГ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

“ИВЭЭЛ ХИШИГТЭН” ХХК



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Хүрмэн сум тэртээ 1923 онд байгуулагдсанаас хойш түүхт 100 жилийн ой 2023 онд тохиосон. Сумын ойг тохиолдуулан гадна, дотнын зочид төлөөлөгчид, жуулчид, явуулын хүмүүст сумын түүх, соёл, байгалийн үзэсгэлэнт газрууд, ард иргэдийн аж амьдралын талаар танилцуулах, иргэдэд сум, орон нутагт болох гэж буй болон болж буй үйл явдлуудыг түргэн шуурхай, цагийн хязгаарлалтгүй хүргэх зэргээр ашиглах мэдээлэл, сурталчилгааны самбарыг сумын хэд хэдэн газарт байрлуулах хэрэгцээтэй байна.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Сумын төвийн болон ирсэн зочид төлөөлөгч, малчин иргэд мэдээ мэдээллийг цаг тухай бүр хүртэх боломжийг бий болгох, сумын өнгө үзэмж, хөгжилд технологийн дэвшлийг ашиглах.

### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Хүрмэн сумын цэнгэлдэх хүрээлэнгийн хойд хаалганы хоёр талд мэдээлэл хүргэх 2 ширхэг лед гэрлэн дэлгэц, гурван хэсэг бүхий нэг ширхэг мэдээллийн самбар, сумын угтах үдэх хаалганы дэргэд гурван хэсэг бүхий мэдээллийн самбар суурилуулсан.





### **ТӨСЛИЙН ҮР ДҮН:**

- Энэхүү төсөл хэрэгжсэнээр сумын төвийн нийт 569 өрхийн 1557 иргэнд мэдээ мэдээллийг цаг алдалгүй, хүртээмжтэйгээр хүргэх боломжтой болсон.
- Хүүхэд залуучуудад зурган болон бичгэн мэдээллийг цаг тухай бүрд давтамжтай хүргэснээр тэдэнд эерэг нөлөө үзүүлнэ.
- Сумын төвд ирсэн гадна дотнын төлөөлөгчид сум орон нутаг, байгалийн үзэсгэлэнт газруудын тухай мэдээлэл, аялах зөвлөмж авах боломжтой болсон.



Итгэцээг суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ

## 2. ДОТУУР БАЙРНЫ ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ХҮРМЭН СУМЫН ЗДТГ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

“ИВЭЭЛ ХИШИГТЭН” ХХК

25,000,000 төгрөг



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Хүрмэн сумын ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд тогтмол 30-40 хүүхэд байрладаг бөгөөд шинэ дотуур байр баригдсан боловч хуучин хоёр давхар модон төмөр ортой тул дотуур байранд амьдардаг хүүхдүүдийн амьдрах орчин, эрүүл ахуйн шаардлага хангахгүй болсон тул уг орнуудыг солих шаардлагатай байсан.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Сургуулийн дотуур байранд амьдардаг хүүхдүүдийн ая тухтай амьдрах орчныг бүрдүүлэх, хуучин төмөр модон орыг солих.

### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Хүрмэн сумын ерөнхий боловсролын дунд сургуулийн дотуур байранд сайн чанарын модон материалаар хийсэн 50 ширхэг орыг суурилуулан хүлээлгэн өгсөн.

### ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Сургуулийн дотуур байранд амьдардаг хүүхдүүд тав тухтай орчинд сурч, хөгжих боломж бүрдсэн.



### 3. ГЭРЭЛТ ХҮРМЭН

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ХҮРМЭН СУМЫН ЗДТГ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

“ПРЕМИУМ ЭКО” ХХК

48,200,000 төгрөг



#### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Төв суурин газарт оршин суугаа иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэхэд гудамж талбайн гэрэлтүүлэг, зүлэгжүүлэлт нь чухал нөлөө үзүүлдэг. Хүрмэн сумын төв нь гэрэлтүүлэг харьцангуй бага, мөн сумын ЗДТГ-ын зүүн талаар гэрэлтүүлэггүй харанхуй байдгаас сургуулийн бага насны гурван хүүхэд нохойд уруулж эрүүл мэндээрээ хохирсон учраас иргэд үдэш, оройн цагаар гудамж талбайгаар явахад таатай орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

#### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Сумын төвийн гэрэлтүүлэг багатай газарт үдэш, оройн цагаар учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор гэрлийн шон суурилуулж, гэрэлтүүлэг нэмэх зорилготой.

#### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Хүрмэн сумын төвийн дөрвөн байршилд нийт 20 ширхэг гэрэлтүүлэг суурилуулж, төвийн албан байгууллагуудын барилгыг 1000 метр туузан неон гэрлээр чимэглэсэн.

#### ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Сумын төвийн гэрэлтүүлэг нэмэгдсэн.
- Сумын төвийн өнгө үзэмж сайжирсан.
- Иргэд үдэш, оройн цагаар аюулгүй зорчих боломж бүрдсэн.



*Итгэцлэлд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

## 4. НАЙРСАГ ХҮРМЭН

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ХҮРМЭН СУМЫН ЗДТГ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

“ИХЭР БАЯН ГОВЬ” ХХК

59,999,500 төгрөг



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Монголчууд эртнээсээ алсаас ирсэн зочид, гийчдийг угтан авч дайлж цайлан үдэж явуулдаг соёлтой ард түмэн билээ. Эртний энэхүү соёлыг хадгалж Хүрмэн суманд зочлон ирж буй иргэдийг хүлээн авах, сумын байгаль, орон нутаг, ард иргэдийн ахуй амьдралын талаар мэдээлэл түгээх хэсэг, зочдоо угтаж, үдэж буй хүмүүс хүлээх зуураа саатан амрах орчныг бүрдүүлэх, одоо байгаа угтаж үдэх хаалганы өнгө үзэмжийг сайжруулах шаардлагатай байна.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Хүрмэн сумын угтах үдэх хаалганд тухайн орон нутгийн түүх, уламжлалт соёл шингэсэн бүтээн байгуулалт, тохижилтын ажил хийж гүйцэтгэнэ.

### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Сумын угтах, үдэх хаалганы орчинд 500м цахилгааны шугам татаж, 4 ширхэг гэрэлтүүлэг суурилуулсан. Мөн явган хүний зам, талбайн тохижилт хийж, сумын үзэсгэлэнт газрууд, мэдээллийг харуулсан зургуудыг хийсэн.

### ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Суманд зочлон ирж буй зочид, нутгийн зон олонд түүхэн газар нутгийн танилцуулга, мэдээлэл авах боломж бүрдсэн.



## 5. ХҮНДЭТГЭЛИЙН ӨРГӨӨ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ: 16,962,000 төгрөг

ХҮРМЭН СУМЫН ЗДТГ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

“СТРАТОНН ОАКМОНД” ХХК



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Хүрмэн сумын иргэдэд зориулсан баяр ёслол, хүндэтгэлийн үйл ажиллагаа, гэрлэх ёслолыг зохион байгуулдаг ёслол хүндэтгэлийн өргөө нь гадна талаараа бороо, салхинаас хамгаалах байгууламжтай байдаг тул агаар сэлгэлт багатай, мөн гэрэлтүүлэг муу байдаг учраас олон хүнийг хамарсан үйл ажиллагаа зохион байгуулахад халуун бүгчим болох, харанхуй дайрах зэргээр хүндрэл учирдаг. Тиймээс уг өргөөний агаар сэлгэлт болон гэрэлтүүлгийг сайжруулах хэрэгцээ байна.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Ёслол хүндэтгэлийн өргөөг тохижуулж, зочид төлөөлөгч нар ая тухтай үйлчлүүлэх орчныг бүрдүүлэх агааржуулагч суурилуулж, гэрэлтүүлэг нэмнэ.

### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Хүндэтгэлийн өргөөнд 30 ширхэг модон сандал нийлүүлж, хоёр ширхэг босоо хөргүүр, 24 ширхэг гэрэлтүүлэг суурилуулсан.

### ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Ёслол хүндэтгэлийн өргөө дотор орчин гэрэлтэй саруул болж иргэдэд үйлчлэхэд таатай орчин бүрдсэн.
- Зуны халуун өдрүүдэд өргөөний дотор хэмийг жигд байлгах, агаар сэлгэлтийг сайжруулсан.



*Итгэцээг суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*



## 2023 ОНД ЦОГТЦЭЦИЙ СУМАНД ОЛГОСОН КВОТООР САНХҮҮЖҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ:

### 1. “АЗ ЖАРГАЛЫН ӨРГӨӨ-ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ДОТУУР БАЙРНЫ ТОХИЖИЛТ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ЦОГТЦЭЦИЙ СУМЫН ЗДТГ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

“ХАЙРХАН БАЯН БОР” ХХК

130,000,000 төгрөг



#### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Цогтцэций сумын сургуулийн дотуур байр 1976 оноос үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Түүнээс хойш 2016 онд 20 ширхэг давхар ор буюу 40 хүүхдийн ор нийлүүлсэн ба 2023 оныг хүртэл 7 жил ашиглаж байна. Тус сургуулийн нийт сурагчдын 13 хувь буюу 169 нь малчин өрхийн 1-12 дугаар ангийн хүүхэд байгаа бөгөөд 30 хувь нь дотуур байранд амьдардаг. Сурагчид жилийн 250 хоног дотуур байранд амьдарч боловсролын үйлчилгээнд тасралтгүй хамрагдаж байна. Байгаль цаг уурын хүнд нөхцөл байдлаас шалтгаалан отрын малчдын нүүдэл их байгаатай холбоотой жилээс жилд дотуур байранд амьдрах хүүхдийн тоо нэмэгдэж байгаа тул дотуур байрны орчин нөхцөлийг сайжруулах зайлшгүй шаардлага байна. Сургуулийн төсөвт дотуур байрны зардал суугдаагүй тул 10 гаруй жил дотуур байранд хатуу зөөлөн эдлэл, тохижилтын ажил хийгдээгүй учраас одоо ашиглагдаж буй ор, ширээ, сандал, гудас, цагаан хэрэгсэл гэх мэт эдлэл хэрэгслүүд эрүүл чанарын шаардлага хангахгүй байна.

#### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Цогтцэций сумын сургуулийн дотуур байранд амьдарч сургуульд сурдаг 50 сурагчдын эрүүл аюулгүй, тохилог, тав тухтай орчин нөхцөл бүрдүүлэх.



### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Хүүхдийн амьдрах тасаг, хүүхэд хөгжлийн өрөө, угаалгын өрөө, халуун усны өрөө, эцэг эхийн уулзалтын өрөөнүүдийн тохижилтын ажил хийж дотуур байр руу орох хэсэгт гутал, хувцас агуулах сав/локер/ гэх мэт 462 ширхэг эдлэл хэрэгсэл, тоног төхөөрөмж нийлүүлсэн.
- Мөн гадна дотор камер суурилуулалт, гадна талбайн хогийн сав, явган замын гэрэл, гадна хаалга, өрөөнүүдийн хаалга суурилуулах ажлууд хийж гүйцэтгэсэн.

### ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Дотуур байрны хүүхдийн амьдрах, амрах тав тухтай орчин нөхцөл бүрдсэн.
- Багш ажилчид ажлын байран дээрээ хөгжих, тав тухтай орчинд ажиллах орчин бүрдсэн.
- Дотуур байрны өнгө үзэмж нэмэгдэж эцэг эх, сурагчдын сэтгэл ханамж дээшилж дотуур байранд амьдрах хүсэлтэй сурагчдыг хүлээн авах боломжтой болсон.

### СЭТГЭГДЭЛ Цогтцэций сумын Т.Борын нэрэмжит ЕБС-ийн 7а ангийн сурагч Ч.Должин:



*Сайн байна уу намайг Ч.Должин гэдэг. Гоё өрөөтэй болсондоо баяртай байна. Шинэ ор, дэр, хөнжил давуу, ширээ, сандал, шкаф, хивс дээд бүгд шинэ бас халуун ус угаалгын машинтай болгосонд маш их баярладаг. Цаашидаа илүү ихийг сурч сайн сурагч болно. Та нартаа баярлалаа.*

### СЭТГЭГДЭЛ Цогтцэций сумын Т.Борын нэрэмжит ЕБС-ийн 10б ангийн сурагч И.Үүрийнцолмон:



*Би анх амарч ирэхэд надад маш гоё сэтгэгдэл төрсөн. Манай байр маш гоё орчинтой. Сайхан зантай багштай болсон болохоор одоо манай байр илүү гоё болж эвтэй найртай хамт олон болон хичээнгүй мундаг байх болно. Ийм гоё орчныг бүрдүүлж өгсөн Өмнөговь аймгийн Цогтцэций сумын ЗДТГ болон Говийн Оюу хөгжлийг дэмжих сангийн ах эгч нартаа болон сургуулийн захирал, багш, ажилчдадаа маш их баярлалаа. Бид цаашидаа илүү их*

*хичээн суралцах болно.*



*Итгэцээд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

## 2. “МОРИН ХУУРЫН СУРГАЛТ, ХӨГЖМИЙН ЗЭМСЭГ НИЙЛҮҮЛЭЛТ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ЦОГТЦЭЦИЙ СУМЫН ЗДТГ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

А.МӨНГӨН

100,630,000 төгрөг



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Морин хуур нь Монголын төдийгүй дэлхийд гайхагдсан үндэсний язгуур өв юм. 2003 онд ЮНЕСКО Монголын уламжлалт морин хуур хөгжмийн уламжлалт урлагийг “Хүн төрөлхтний аман болон утга соёлын шилдэг дээж”-ээр тунхаглаж, 2008 онд ЮНЕСКО-ийн хүн төрөлхтний соёлын биет бус өвийн төлөөллийн жагсаалтад бүртгэсэн. Энэ агуу үндэсний язгуур өвийг Монгол улсад ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт тусган хөгжмийн хичээл ордог хэдий ч 3-р ангиас эхлэн орох ба зөвхөн морин хуурын бүтцийн талаар зураг дээр ярилцах, морин хуурын хөгжим сонсох зэргээр сургалт явуулж байна. Тиймээс морин хуур тоглож сурах сонирхолтой бага насны хүүхдүүдийг сургалтад хамруулах, өв соёлоо түгээн дэлгэрүүлж мөн бага наснаас нь хүүхдүүдийг үндэсний шинж чанартай хөгжмийн зэмсэг эзэмшүүлж сургах нь чухал юм.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Цогтцэций сумын сургуулийн морин хуур тоглож сурах сонирхолтой сурагчдыг морин хуурын сургалтад хамруулах, дүрс бичлэг хийж түгээн дэлгэрүүлэх, цаашид тасралтгүй сургалт явуулахад шаардлагатай боловсон хүчин чадавхжуулах сургалт явуулах.

### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- 2001 оноос хойш уртын дууны концертмейтр багш, морин хуурын багш, Япон улсад морин хуурын хөгжимчин, нийслэлийн Улаанбаатар чуулгат морин хуур хөгжимчин хийж байгаа гэх мэт туршлагатай морин хуурч, багш, урлаг судлаач А.Мөнгөн нь төслийг хэрэгжүүлж байна.
- Уг төслийн хүрээнд Төв аймаг, Дундговь аймгийн Дэрэн сум, Өмнөговь аймгийн Цогтцэций,





Мандал-Овоо, Цогт-Овоо сумдаар хийсэн судалгаа дээрээ үндэслэн Цогтцэций сумын 21 сурагч, хөгжмийн багш нарыг сургалтад хамруулж, дүрс бичлэг хийж Цогтцэций сумын 2024 онд болох 100 жилийн ойд зориулсан сурагчдын тоглолт зохион байгуулах, цахимаар болон телевизээр олны хүртээл болгох, мөн Цогтцэций сумын хөгжмийн багш нарыг чадавхжуулан цаашид Цогтцэций сумын сурагчдыг морин хуурын сургалтад тогтмол хамрагдаж байх боломжийг бүрдүүлж байна. Уг төслийн хүрээнд зохион байгуулагдах сургалтуудыг тогтвортой явуулахын тулд Цогтцэций сумын Соёлын төвд 35 ширхэг морин хуур, 2 ширхэг ёочин хөгжим, 4 ширхэг ятга, 2 ширхэг лимбэ, нийт 43 хөгжмийн зэмсэг нийлүүлж байна.

### ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Энэхүү төслийн хүрээнд эхний ээлжид Цогтцэций сумын 21 хүүхэд үндэсний өв соёл болсон морин хуураа тоглож сурах, цаашлаад өв тээгчид болох, хөгжмийн зэмсэг эзэмшиж чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх, бусдад түгээн дэлгэрүүлэх боломжтой болох юм.

### СЭТГЭГДЭЛ

Сурагч Ч.Хишигбаярын аав:



Миний хүү Ч.Хишигбаяр нь морин хуурч, хөгжимчин, хуурын багш Мөнгөний удирдлага доор морин хуурын сургалтад хамрагдаад хоёр сар болж байна. Сургалтын үйл ажиллагаа чанартай сайн явагддагаас гадна, Цогтцэций сумандаа мэргэжлийн түвшинд анхан шатнаас нь зөв арга зүйтэй

зааж, хүүхдийн ур чадварыг нээн хөгжүүлж, сэтгэл зүйг нь дэмжин урам хайрлаж цаашид сурах урам зориг, өөртөө итгэлтэй байдал, үндэсний хөгжмөө дээдлэн, сурах хүсэл эрмэлзэл ихтэй болж байгаад манай гэр бүлийн хувьд сайшаалтай байгаа билээ. Үндэсний өв соёлын томоохон хэсэг болон морин хуур хөгжмөө гэрэлт ирээдүй болсон хүүхэд багачууддаа түгээн дэлгэрүүлж, зааж сургаж байгаа Мөнгөн багшдаа баярлалаа.



Итгэцээд суурьлсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ



## 2023 ОНД ХАНХОНГОР СУМАНД ОЛГОСОН КВОТООР САНХҮҮЖҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ:

### 1. “ЦИТОГОВЬ” ЭМИЙН САНГ ТОХИЖУУЛАХ, ЦЭВЭР БОХИРЫН ШУГАМД ХОЛБОХ ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

ХАНХОНГОР СУМЫН ЗДТГ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

“БАЯЖИХ ГАЛУУТ” ХХК

155,754,889 төгрөг



#### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Ханхонгор сум нь эмийн сангүй учир ахмад настнуудын даралтын эмээс эхлээд эмийн сангийн үйлчилгээ шаардлагатай болсон бүх хүмүүс нь аймгийн төв Даланзадгадаас эмээ захиж авчруулдаг чирэгдэлтэй байсан. Стандарт шаардлага хангасан эмийн сантай болбол иргэд эрүүл мэндийн даатгалаар үйлчлүүлэн эмийн сангийн үйлчилгээг сумандаа авах боломж бүрдэнэ.

#### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Ханхонгор сумын “Цитоговь” ӨӨААТҮГ-ын өмчлөлийн барилгыг сэргээн засварлаж, цэвэр бохирын шугамд холбон, шаардлагатай тавилга, техник хэрэгслээр тохижуулан стандарт шаардлагад нийцсэн эмийн сантай болох.

#### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Барилгад иж бүрэн засвар тохижилтыг мэргэшсэн төсөвчний хийсэн зураг төсвийн дагуу гүйцэтгэж, эмийн санд шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга хэрэгслээр бүрэн хангаж тохижуулсан.



### **ТӨСЛИЙН ҮР ДҮН:**

- Ханхонгор сум стандарт хангасан эмийн сантай болж иргэд сум орон нутагтаа эмийн сангийн үйлчилгээ авах боломж бүрдсэн.
- Ханхонгор сум бодлогоор бэлтгэсэн сумын мэргэжлийн залуу ажилтан ажлын байртай болж эмийн сангаа хариуцан ажиллуулж байгаа.
- Аймгийн төсвөөс шинэ тутам эмийн сангийн үйл ажиллагааг дэмжиж эм хэрэгсэлд зарцуулах эргэлтийн хөрөнгийг шийдэж өгсөн.



Итгэцлэлд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ



## 2023 ОНД НОЁН СУМАНД ОЛГОСОН КВОТООР САНХҮҮЖҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТЭСЭЛ:

### 1. “ДЭЛХИЙН ХҮҮХДИЙН ГАРАА” ТЭСЭЛ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТЭСӨВ:

НОЁН СУМЫН ЗДТГ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

“УРГАМЛЫН ДАЛАЙ” ХХК

50,000,000 төгрөг



#### ТЭСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Ноён сумын 16-р цэцэрлэг нь 2014 онд гадна тохижилт цэцэрлэгийн тоглоом суурилуулж, эцэг эх, багш нарын хүчээр биеийн тамирын хэрэглэгдэхүүнийг гарын доорх материал ашиглан хийсэн нь цаг хугацааны явцад агаар салхинд муудан эвдэрч, эрүүл ахуй орчны шаардлага стандартад нийцэхгүй, хүүхэд осол гэмтэлд өртөх магадлалтай болсон тул шинэчлэн сайжруулах шаардлагатай байсан.

#### ТЭСЛИЙН ЗОРИЛГО:

- Цэцэрлэгийн гадна тоглоомын талбайг засварлаж цэцэрлэгийн хүүхдийн хөдөлгөөн эрүүл мэндийг дэмжсэн цогц талбайтай болох.

#### ТЭСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Цэцэрлэгийн гадна талбайн 2x12 м2 талбайд хөрсийг тэгшитгэн бетон цутгаж леги шал угсарсан. Тоглоомын ком, дамжуурга шат, хөл савлуур, гэдэсний таталт, нурууны үрэлт, гүйлтийн зам, эргэдэг тоглоом, дугуйтай төхөөрөмж, хос дүүжин, пүржинтэй тоглоом, түшлэгтэй болон түшлэггүй сандал, 3 ангилдаг хогийн сав зэрэг иж бүрдэл тоглоом хэрэгслийг байрлуулснаас



гадна дотор төхөөрөмж 10 гаруйг мөн нийлүүлсэн.

### **ТӨСЛИЙН ҮР ДҮН:**

- Ноён сумын хүүхдийн цэцэрлэгт сургуулийн өмнөх боловсрол эзэмшиж 2-5 насны хүүхдүүд сургалтын хөтөлбөрийн дагуу гадаа агаарт аюулгүй орчинд тоглох наадах боломж бүрдсэн.
- Мөн сумын сургуулийн бага ангийн хүүхдүүд ч тоглож наадах боломжтой, цэцэрлэгт хамрагдах нас нь болоогүй хүүхдүүдийг эцэг эх асран хамгаалагч нар нь уг тоглоомын талбайд тоглуулах, салхилуулах, хөдөлгөөний эвсэл сайжруулах, хөгжүүлэх боломж нөхцөл сайжирсан.





*Итгэцлэлд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

## 2. “ИРГЭНИЙ ТАНХИМЫН ЗАСВАР ТОХИЖИЛТ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

**НОЁН СУМЫН ЗДТГ**

**“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”**

**“ОРШДОС” ХХК**

**30,000,000 төгрөг**



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Ноён сумын ЗДТГ-ын барилга 2016 онд ашиглалтад орсноос хойш засвар үйлчилгээ хийгдээгүйн улмаас Иргэний танхимд иргэдэд зориулсан үйл ажиллагаа зохион байгуулахад хуучирч муудсан, проектор зэрэг хуучирсан технологитой учир интернэт хурал зөвлөгөөн сургалт зэрэг орчин үеийн хэрэгцээ шаардлага хангахгүй болсон.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Иргэний танхимд дотоод засвар тохижилт хийж уг танхимаар үйлчлүүлж байгаа иргэдийн ая тухтай үйлчлүүлэх орчин бүрдүүлэх, улмаар ухаалаг дэлгэц суурилуулан цахим хурал, сургалт зохион байгуулах, мэдээллийн хүртээмжтэй байдлыг дээшлүүлнэ.

### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Төслийн хүрээнд төрийн албан хаагчдын үйл ажиллагаанд шаардлагатай Dell Optiplex 5400 загварын 3 ширхэг суурин компьютер, Dell Vostro 3520 загварын 8 ширхэг зөөврийн компьютер, Dell Vostro 153510 i7 загварын 4 ширхэг зөөврийн компьютер, XP laser jet MFP 137NW олон үйлдэлт хэвлэгч 1 ширхэг, Epson L3256 олон үйлдэлт өнгөт хэвлэгч 3 ширхэг, canon 60D18-55 зургийн аппарат ашиглагч байгууллагад нийлүүлсэн.



### ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Захиалагч Ноён сумын ЗДТГ-н ажлын даалгавар, гэрээгээр тохиролцсон техникийн тодорхойлолтын дагуу модон ренкээр явган хана, акустик хана зэрэг тохижилтын ажил бүрэн хийгдэж, android windows хос үйлдлийн системтэй, 75 инчийн зөөврийн хөл бүхий ухаалаг дэлгэц суурилуулсан.

### Сэтгэгдэл **Ноён сумын ЗДТГ-ын дарга С.Жаргалсүрэн:**



*“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-гийн хөтөлбөрт манай сум анх удаагаа хамрагдаж байна. 2023онд манай сум 3 төсөл хэрэгжүүлснээс ИТХурал нь Төрийн албан хаагчдын ажиллах таатай орчин бүрдүүлэх зорилгоор Иргэний танхимд засвар тохижилтын ажлыг 30сая төгрөгөөр, Засаг даргын Тамгын газар нь Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх орчин бүрдүүлэх зорилгоор компьютер техник хэрэгслийг шинэчлэхээр 70 сая төгрөгийн төслийг амжилттай хэрэгжүүллээ. Ингээд*

*Иргэдийн төлөөлөгчдийн хурал Засаг даргын Тамгын газрынхаа нийт ажилтан албан хаагчдын өмнөөс “Оюу толгой” ХХК болон “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-д талархал илэрхийлье.*



*Итгэцлэлд суурилсан сайхан ирээдүйг  
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

### 3. “ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ИРГЭДЭД ТҮРГЭН ШУУРХАЙ ХҮРГЭХ” ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:


ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

НОЁН СУМЫН ЗДТГ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”

Х.ЭНХДАЛАЙ

70,000,000 төгрөг



#### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

- Ноён суманд 100 орчим төрийн албан хаагчид ажилладаг ба иргэдэд төрийн үйлчилгээ хүргэн ажилладаг эдгээр ажилтнуудын ашиглаж буй компьютер тоног төхөөрөмжид 2012 оноос хойш шинэчлэл хийгээгүй тул ажил үйлчилгээнд сөргөөр нөлөөлдөг тул шинэчлэх шаардлагатай.

#### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Алслагдсан орон нутагт ажиллаж буй албан хаагчид төрийн үйлчилгээг иргэдэд цаг алдалгүй шуурхай хүргэн ажиллахад шаардлагатай техникийн шинэчлэл хийх, орчин үеийн технологи ашиглах боломж бүрдүүлэх.

#### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- Төслийн хүрээнд төрийн албан хаагчдын үйл ажиллагаанд шаардлагатай Dell Optiplex 5400 загварын 3 ширхэг суурин компьютер, Dell Vostro 3520 загварын 8 ширхэг зөөврийн компьютер, Dell Vostro 153510 i7 загварын 4 ширхэг зөөврийн компьютер, XP laser jet MFP 137NW олон үйлдэлт хэвлэгч 1 ширхэг, Epson L3256 олон үйлдэлт өнгөт хэвлэгч 3 ширхэг, canon 60D18-55 зургийн аппарат ашиглагч байгууллагад нийлүүлсэн.

#### ТӨСЛИЙН ҮР ДҮН:

